

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2022.12.16

Эрдэнэт хот

№	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
									Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5		6	7	8	9	10	11	12	13
НЭГ.ЭРҮҮЛ МЭНД, БИЕИЙН ТАМИР, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО													
ЭРҮҮЛ МЭНД													
1	1.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, үр нөлөөг дээшлүүлэн ажиллах	2021-2024	ЭМГ	ЭМБ	Улс болон олон улсын төсөл хөтөлбөр	133.0	Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж 83%	Хэрэгжилтийн хувь 85%-д хүрсэн байна.	30.0	Орон нутгийн төсөв 304,5	Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг хүчингүй болгосон. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын тушаалуудаар 5 арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж хэрэгжилт дунджаар 83,8 хувьтай байна. Тус арга хэмжээнүүдийн хүрээнд 267,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгаас шийдвэрлүүлэн хэрэгжүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэд 17 удаагийн хяналтыг хийж, зөвлөмжөөр хангасан. Тушаал шийдвэрийн хэрэгжилт дунджаар 84,9% байна.	90%
2		Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх	2022	ЭМГ	Аймгийн ЗДТГ ЭМБ	Олон улсын төсөл хөтөлбөр орон нутгийн төсөв	50.0	Суурь судалгааны тоо, үр дүн-1	Тандалт судалгаанд хүн амын 1%-ийг хамруулсан байна.	50.0		“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд бидний хувь нэмэр, судлаач-2022” уриан дор эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж 36 илтгэл хэлэлцүүлснээс улсын хэмжээнд 2 илтгэл хэлэлцүүлэгдсэн байна. Тайлант хугацаанд: -Ундны уснаас шалтгаалсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний сүүлийн 5 жилийн байдалд судалгаа хийж, нөлөөлж буй хүчин зүйл, цаашид авах арга хэмжээний саналыг "Усны үнэ цэнэ" аймгийн хэмжээний зөвлөгөөнд танилцуулсан. -Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндэд учруулж буй сөрөг үр дагаварт эрсдэлийн үнэлгээ хийж, иргэдийн эрүүл	100%

											аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгамдсан асуудлыг цагаан тоосны эрсдэлийг үнэлэх, бууруулах салбар зөвлөлийн уулзалтад танилцуулсан. -Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 20-59 насны 250 албан хаагчийг архины хэрэглээний түвшинг тогтоох сорилд хамруулсан ба судалгааны үр дүнд 40% нь I-р түвшин, 30% нь II-р түвшин, 20% нь III-р түвшин, 10% нь IV-р түвшний зэрэглэлд хамаарч байгаа тул III, IV-р түвшний хэрэглэгчдийг сэтгэл зүйн сургалт, эмчилгээнд хамруулсан. - 5 сургуулийн ахлах ангийн 885 сурагчаас "Өсвөр насны хүүхдийн сэтгэл гутрал, стресс, өөрийн үнэлгээ, цахим хамаарлын түвшин болон түүний гэр бүлийн байдал, оршин суугаа харьяалал хоорондын хамаарлын байдлыг судлахад 55.4% өөртөө итгэх итгэлтэй, 1.8% өөрийн үнэлгээ багатай, 14.4% сэтгэл гутралын хүндэвтэр түвшин, 7.9% сэтгэл гутралын хүнд түвшинд, 33.2% стрессийн түвшин өндөр, 70,9% интернэтийг эрсдэлтэй нөхцөлд ашигладаг гэсэн үр дүн гарсан байна. Иймд мэргэжлийн 11 сэтгэл зүйч 91 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, 24 төрлийн сэтгэц оношилгоонд 255 иргэн, бүлгийн сэтгэл засалд 240 иргэнийг хамруулсан үр дүнтэй байна.Хүн амын дунд эрүүл мэндийн суурь 3 судалгаанд 10,380 иргэн хамрагдаж, тандалт судалгаанд суурин хүн амын 1%-ийг хамруулж, зорилтот түвшинд хүрсэн.	
3		“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний вирусийг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах	2021-2024	ЭМГ	СӨЭМТ	Эрүүл мэндийг дэмжих сан Улс, Орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	120.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 83.4%	Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.	30.0	Тайлант хугацаанд элэгний В, С, Д вирусийн илрүүлэг шинжилгээнд 8658 иргэн хамрагдсанаас 555 хүн буюу 6.4 хувьд нь С вирус, 551 хүн буюу 6.3 хувьд нь В вирус илэрсэн. Вирусийн эмчилгээ хийх эрх бүхий 6 эмчийн хяналтад 258 иргэн эмчилгээ хийлгэсэн. Нярайн төрсний дараа 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.8%, 2 настай хүүхдийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 98.2%-тай байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагын 176 ажилтан, эрсдэлт бүлгийн 559 хүн ам В вируст гепатитын эсрэг вакцинд сайн дураар хамрагдаад байна. Элэгний хорт хавдрын нас баралт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.2 промиллоор буурсан, элэгний хатуурлын нас баралт 10000 хүн амд 1.7 промилл буюу өнгөрсөн оны мөн үеэс 0.4 промиллоор өссөн байна	90%

4		Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг (хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх) үзлэгийг эрчимжүүлэх	2021-2024	ЭМГ	ЭМБ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	45.0	Эрт илрүүлэг 60.4%	Эрт илрүүлгийг 2%-иар нэмэгдүүлсэн байна.	15.0	Орон нутгийн төсөв 12,0	Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хатуурал, хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Эрт илрүүлэг үзлэг 40.5% байна. Үүнд: - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 43118 буюу хамрагдвал зохих хүн амын 62,8 хувийг эзэлж, өмнөх оноос 5 хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 1.7 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 26522 буюу хамрагдвал зохих хүн амын 78,2 хувийг эзэлж, өмнөх оноос 1,3 хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувь онош батлагдсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 17093 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 49,6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 26,9 хувиар буурсан байна. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2572 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 32,4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 7,6 хувиар буурсан ба 1392 буюу 86.9 хувь нь пап шинжилгээнд хамрагдсан байна. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер зөвлөмжийг 18569 иргэнд хүргэж, 3 өдөрлөгт давхардсан тоогоор 4786 иргэнийг хамруулан 6 эх бэлтгэл, 3 шторка бэлтгэн цахим хуудсаар иргэдэд хүргэсэн.	70%
5		Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	БОЭТ	Орон нутгийн төсөв	280.0	Дэмжлэгт хамрагдсан хувь 16.8%	Дэмжлэгт хамрагдсан хувь 17.1%-д хүрсэн байна.	70.0	Орон нутгийн төсөв 70,0	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс аймгийн Засаг даргын 2022 оны А/214, А/432, А/610, 883 дугаар захирамжаар 130 иргэнд 68,7 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээд байна. Тайлант хугацаанд хавдрын 211 тохиолдол шинээр батлагдсанаас 61,1 хувь нь дэмжлэгт хамрагдсан байна. Тайлант хугацаанд хорт хавдрын шинэ тохиолдол 211 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 27 тохиолдлоор буурч, эрт үедээ оношлогдсон хувь 49,3 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.0 хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна.	100%
6		“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	ТББ	Орон нутгийн төсөв	24.0	ЭМДБ-ын тоо 66	0.5%-иар нэмэгдсэн байна.	6.0	Орон нутгийн төсөв 6,0	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр шалгаруулах болзолт шалгуур болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сурталчлан ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд Эрүүл	100%

		өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах									мэндийг дэмжигч байгууллага 74 болж, үүнээс боловсролын байгууллага 45, үйлдвэр аж ахуйн нэгж 11, эрүүл мэндийн байгууллага 10, бусад 8 байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төсвөөс 6,0 сая төгрөгийг шийдүүлсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд "Өдөр бүр 30 минутыг өөртөө" аяныг өрнүүлж, эрүүл мэндээ дээдлэгч 14 ажилтныг олон нийтэд цахимаар сурталчлан 38904 иргэнд хүргэсэн байна		
7	1.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сэргийлж болох өвчлөл, нас баралтыг бууруулна	БОЭТ-ийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ БОЭТ	ЭМБ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	400.0	-	Төсөвт шаардагдах хөрөнгийг суулгах үйл ажиллагаа тогтмолжсон байна.	400.0	Улсын төсөв - 1711,0 Орон нутгийн төсөв - 289,0	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас нийт 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээс орон нутгаас их засварын ажилд 289,0 сая төгрөг, улсын төсвөөс их засварт 180,0 сая төгрөг, багаж тоног төхөөрөмжид 1,5 тэрбум төгрөгийн үзлэг шинжилгээ болон оношилгооны 34 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. Тус дэмжих төв нь 2022 оны 5 дугаар сарын 7-ны өдөр нээлтээ хийж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн насанд хүрэгчдийн багцын үзлэг хийж байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийг дэмжих төвд 4893 буюу насанд хүрэгчдийн 7,1% үзлэгт хамрагдсан байна.	100%
8	1.2.1.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн менежментийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна.	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг нутагшуулах	2021-2024	ЭМГ БОЭТ	Аймгийн ЗДТГ	Улс болон орон нутгийн төсөв	380.0	-	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологи нэвтэрч үйл ажиллагаа тогтмолжсон байна.	280.0		Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдрэл, дотор, эрчимт эмчилгээний тасагт хийгдэх бүлэн хайлуулах эмчилгээг нутагшуулах ажлын хүрээнд: - 1 эмч, 1 сувилагч сургагдаж бэлтгэгдсэн. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ангиографийн аппаратаар хангагдан 200 хүнд оношилгоог хийснээр зүрхний цочмог шигдээс өвчний нас баралтыг бууруулсан. Дотрын тасагт тархины харвалтын нэгж байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Эрүүл мэндийн даатгалаас өндөр өртөгт хагалгааны зардалд нэг иргэнд 4.9 сая төгрөгийг төлж байна. Орон нутгаас 33,0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж 10 ширхэг бүлэн хайлуулах РЭПИ/актилизе/-р хангасан байна. Зүрх судасны өвчлөлөөр нас барсан 185 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 38 тохиолдлоор буюу 2.2 промиллоор буурсан байна.	100%

9	1.2.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэл зүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн	Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, стандартыг хэрэгжилтийг хангуулан, тогтвортой үйл ажиллагааг дэмжих	2021-2024	ЭМГ	Эм ханган нийлүүлэх байгууллага Эмийн сан Эм холбоо	-	-	Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт 88%	Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилтийг 93%-д хүрсэн байна.	-		2022 онд нийтийн үйлчилгээтэй 81 эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 эмийн сан шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан. 49 эмийн санд "Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт"-аар хяналт хийхэд дунджаар 90,1% үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,4%-аар сайжирсан байна. Тайлант хугацаанд 2 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан. "Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт"-аар 6 байгууллагад хяналт хийхэд дунджаар 93,4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 5,3%-аар сайжирсан байна. Зөвлөмжийг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудад хүргүүлж, хяналт тавин ажилласан.	90%
10	тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулна.	Эмнэл зүй эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалд тохируулан нэвтрүүлэх	2021-2024	ЭМГ	Эм ханган нийлүүлэх байгууллага Эмийн сан Эм холбоо	Улс болон орон нутгийн төсөв	-	Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээ 2 эмнэл зүйн эм зүйч ажиллуул ах	Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.	-		Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 105 эм зүйч, 125 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 9,3%, эм найруулагч 17,9%-иар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 9 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50%-иар нэмэгдсэн байна. Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 55-65%-д тарилгыг хийж, 21-45%-д уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 4,5%-аар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 1-5%-иар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 82,0% болж 0,5%-иар нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,7%-иар буурсан байна.	100%
11	1.2.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, үйлчлүүлэгчийг нэг дороос бүх төрлийн тусламжийг авах нөхцөлийг бүрдүүлсэн төрөлжсөн	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	ХХЭМБ	Орон нутгийн төсөв	92.0	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо 1	Гэрээт үйлчилгээг 1-ээр нэмэгдүүлсэн байна.	22.0	Орон нутгийн төсөв 84,5	Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 118461 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 17.3%-ийг, 19633 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 51.3%-ийг эзэлж Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Коронавируст халдварын 4 дэх давалгаанд хувийн хэвшлийн 4 ортой эмнэлгийг дайчилж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нийт 240 орыг ажиллуулсан. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиниктэй томуу,	100%

	мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлнэ.										томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан. Зорилтот бүлгийн уураг илчлэгийн хурц болон архаг дутагдал, сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 264 хүүхдийг "Бүжинлхам" хүүхдийн сувилалд нар, ус, агаар, эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх ажлыг орон нутгийн 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр гэрээгээр хийж гүйцэтгүүлсэн. Чийрэгжүүлэлт, сувилгаанд хамрагдсан 100 хүүхдийн 87 /70.4%/ нь зөв хооллолт сувилгааны үр дүнд хүүхэд бүр 100-500 гр жин нэмэгдэж, эмнэлзүйн хувьд хооллолтын бэрхшээл арилсан. Жин, өсөлтийн 1-р зэргийн хоцрогдолтой 56 хүүхдүүд, 2-р зэргийн 35 хүүхдүүдийн 3-р зэргийн 4 хүүхдийн жингийн үзүүлэлт 200-500 гр нэмэгдэж, 83 хувь нь жин, өсөлтийн үзүүлэлт дээшилсэн үр дүн гарсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхээр "Хан шунхлай нуруу" ХХК-ийн 6 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90.0 хувь болж өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88.2 хувиар багассан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/105 дугаар захирамжаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэд хэрэгжүүлж байгаа "Сэтгэлд нийцсэн хөтөч" үйлчилгээ ажиллуулахад дэмжлэг үзүүлж, 6 хөтөч сувилагчийн цалин, нэг удаагийн хэрэгсэлд 35,2 сая төгрөгийг шийдвэрлэсэн. "Хан шунхлай нуруу" ХХК 14 хоног бүр "Герман Монголын хамтын ажиллагааны нийгэмлэг"-ийн Froggress төслийн болон "Илтгэх урлагийн индэр" төрийн бус байгууллагатай хамтарсан төлөвлөгөөт сургалт, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулан ажилласан. Хөтөч үйлчилгээний үр дүнд эмч нарын цагийг иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор хөндлөнгөөс хянадаг болсноор ажлын цаг ашиглалт, үйл ажиллагаа эрс сайжирч, иргэдийн хүлээгдэл 88.2 хувиар багассан үр дүн гарсан.	
12		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний	2021-2024	Хувийн хэвшл	Аймгийн ЗДТГ	Олон улсын төсөл	-	Төрөлжсөн мэргэшлийн	Төрөлжсөн мэргэшлийн төв	-	Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд оношилгооны чадавхыг сайжруулснаар хэрэгжилт 85.0 хувьд хүрсэн нь	100%

		хэрэгцээг тодорхойлж, төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг дэмжих		ийн байгууллагууд	ЭМГ	хөтөлбөр Орон нутгийн төсөв Төр, Хувийн хэвшлийн түншлэл		йн тусламж үйлчилгээг үзүүлж буй байгууллага-2	эмнэлгийн чадавхыг нэмэгдүүлж, хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.			өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлын шийдвэрээр "Талын булаг" ор бүхий клиникт дүрс оношилгооны эмнэлэг, "Очир-Увидас" уламжлалт сэргээн засах клиникт дотрын тусламж үйлчилгээний чиглэлийн эмнэлэг, "Эко" эмийн санд 24 цагийн үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээг нэмж олгосон байна. "Шинэ эрин мед" клиникт "ЭХО Туяа" оношилгоо, "Теку анка" дотрын клиникийг нэгтгэж төрөлжсөн мэргэжлийн клиник болгож өргөжүүлсэн. "Баян-Өндөр мед" нэгдсэн эмнэлэгт "Онош" лабораторийг нэгтгэн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн.Хувийн хэвшлийн 8 ор бүхий эмнэлэг амбулаторийн болон өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээгээр эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтад тэнцэж 105 ор бүхий өдрийн эмчилгээ хийж байна. "Эрдэнэт Медикал" эмнэлэг, "Баян-Өндөр мед" нэгдсэн эмнэлэг нь хөнгөвчлөх тусламж үйлчилгээг нэмж үзүүлэхээр бэлтгэл хангаж байна. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эмнэлгүүд өмнөх онтой харьцуулбал 2-3 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн ажилласан.	
13	1.2.4.Хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эх, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг бууруулна.	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМГ	БОЭТ ХХЭМ Б		Улс болон орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр	47.0	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулсан хувь 10%	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт 15 хувийг хамруулсан байна.	10.0	Орон нутгийн төсөв 25,0	"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуурыг батлуулж, хэрэгжилт 76.0 хувьтай байна. Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар салбаруудад мэдээлэл 5, зөвлөмж 1 удаа хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд: - Орон нутгийн санхүүжилтээр "Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв" шалгаруулах 3 сарын болзолт уралдааныг зохион байгуулж, Үйлсбадрах, Мөнхсүндэрэл, Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төвүүд эхний 3 байрыг эзэлсэн байна. - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2,0 сая төгрөгийн төсвөөр зорилтот бүлгийн 100 хүүхдийг аминдэмжүүлсэн. - "Зүрх мартахгүй" төслийн хүрээнд зүрхний төрөлхийн гажигтай 0-16 насны 152 хүүхдийг үзлэгт хамруулж, 45 хүүхдийг хагалгаанд оруулахаар төлөвлөсөн. - Тайлант хугацаанд 0-5 насны эрт илрүүлэг 9335 буюу хамрагдвал зохих хүн амын 76,2%, 6-17	100%

											насны эрт илрүүлэгт 14481 буюу хамрагдвал зохих хүн амын 53,5% тус тус хамрагдаж дунджаар 60,7%-тай байна. - Давхардсан тоогоор сум, өрхийн 112, хүүхдийн байгууллагын 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, баг, сургуулийн нийгмийн ажилтан, цагдаагийн 141 ажилтныг мэдээлэл, зөвлөмжөөр хангаж хүүхэд хамгааллын багийг чадавхжуулсан. - Томуу томуу төст өвчин алаг цоог дэгдэлтийн түвшинд хүрсэн тул нэмэлтээр 200-250 ор дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалт хийж, өрх, хувийн хэвшлийн 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулсан. - Төрөлт 2287 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,2%-аар буурсан. Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 6,6 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,8 промиллоор, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 промиллоор тус тус буурсан байна. - Өсвөр үе, зорилтот бүлгийн 546 эмэгтэйг нөхөн үржихүйн насны 4640 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулсан нь нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйн 18,5 хувийг эзэлж зорилтот түвшинд хүрсэн. 16-49 насны эмэгтэйчүүдийн 62,1 хувь гэр бүл төлөвлөлтийн 5 төрлийн арга хэрэгсэлд хамрагдаж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар нэмэгдсэн байна.		
14		Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулах	2021-2024	ЭМГ	БОЭТ СӨЭМ Т	Улсын төсөв Орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	23.0	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн хөхүүл эхийг аминдэмээр хангасан хувь 10%	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн хөхүүл эхчүүдийн 12%-ийг аминдэмээр хангасан байна.	5.5	Орон нутгийн төсөв 5,0	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэхэд зориулж аймгийн Засаг даргын 2022 оны А/171 дүгээр захирамжаар батлагдсан төсвийн хүрээнд 353 эхийг аминдэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 353 эхээс цус багадалттай 201 эх байгаа нь 57 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 95 эх байгаа нь 27 хувийг, биологийн эрсдэлтэй 11 эх байгаа нь 3 хувийг, эх барихын ужиг дутагдалтай 46 эх байгаа нь 13 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд: - Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад хоёр сая төгрөг буюу 40.0 хувиар нэмэгдэж хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.74 дахин өссөн.	90%

											- Зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн 27,4 хувийг аминдэмжүүлэлтэд хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувиар нэмэгдсэн байна. Аминдэмжүүлэлтийн үр дүн 85.0 хувьтай байна. Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулснаар Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 6,6 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,8 промиллоор, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 промиллоор тус тус буурсан үр дүнтэй байна.		
15		Нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2021-2024	ЭМГ БОЭТ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	176.0	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь 33.5%	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийг 28.5% болгож бууруулна.	44.0	Орон нутгийн төсөв 58,5	Орон нутагт нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологиудыг амжилттай нэвтрүүллээ. Үүнд: • Сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нярайн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж, тайлант хугацаанд амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд сурфактант эмчилгээг хийж, 86,6 хувийн үр дүнтэй байна. • Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 1920 нярайд 100 хувь үзүүлсэн. • Нярайн тандалт скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100 хувь хамруулж байгаа бөгөөд түнхний үений ЭХО оношилгоонд 1920, ретинопатийн оношилгоонд 56 нярайг хамруулж, 2 нярайг лавлагаа шатлалд илгээсэн байна. Тайлант хугацаанд нярайн эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 6,6 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,9 промиллоор буурсан ба нярайн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болох амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл гараагүй байна. Нялхасын эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16 тохиолдлоор буюу 5.7 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.	100%
16	1.2.5.Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан	БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	2021-2024	Аймгийн ЗДТГ БОЭТ	ЭМГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	2.100.0	БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 75%	-	-	Орон нутгийн төсөв 1900,0 Улсын төсөв 1800,0	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангахаар 241,5 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийн дэмжих төвд улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр тоног төхөөрөмжөөр ханган урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн насанд хүрэгчдийн багцын үзлэг хийж байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний	100%

	стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.										төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92.0 хувь болж өмнөх онтой харьцуулахад 2 хувиар нэмэгдсэн байна.		
17		БОЭТ-ийн барилга их засвар, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ БОЭТ	ЭМГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	1.000.0	БОЭТ-ийн барилга их засвар	Гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабель шугамыг шинэчлэнэ.	272.2	Орон нутгийн төсөв 1300,0	Орон нутгийн 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амбулаторийн 1 болон 2 дугаар давхрын их засварын ажил бүрэн хийгдэж дууссан. Сүрьеэгийн диспансерын механик агааржуулалт, салхивч хийх, цогцос хадгалах байрны өргөтгөлийн ажлууд бүрэн дууссан. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн цахилгаан кабель шугамыг шинэчлэхэд 135,0 сая төгрөг, гадна инженерийн шугам сүлжээний засварт 150.0 сая төгрөгийн ажлууд хийгдсэн.	100%
18		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай лабораторийн болон бусад тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	Жаргалант сумын ӨЭМТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	1.500.0	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 85%	Мобайл үйлчилгээг нэвтрүүлэх /6 ӨЭМТ/	150.0	Улсын төсөв 16,3	Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн найман төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 2 mb/ps хурдтай интернетэд холбогдсон. Жаргалант сумын эрүүл мэндийн төвд холбооны байрнаас эмнэлэг хүртэл шилэн кабелиар холбож байршуулснаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй холбогдох боломжтой болсон. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерийн хангалт 90.0 хувьтай байна.	100%
19	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгож ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	2021, 2023	Аймгийн ЗДТГ ЭМГ Жаргалант сумын ЗДТГ	Жаргалант сумын ӨЭМТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	2.150.0	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн Сум, өрхийн эрүүл мэндийн төв-7	-	-		Өрхийн 8 эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгосноор ажиллах орчин нөхцөл 100 хувь сайжирсан. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн ажил 477,0 сая төгрөгийн өртөгөөр 100 хувь гүйцэтгэлтэй хийгдэж, сумын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна .	100%	
								“Энхжих Мандарива” ӨЭМТ-ийн барилгыг дуусгасан байна.	1.500.0				
								Жаргалант сумын өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг дуусгасан байна.	500.0				

20	1.3.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлнэ.	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	19.0	Хариу арга хэмжээний чадавх 75%	Хариу арга хэмжээний чадавхыг 80%-д хүргэнэ.	5.0	ЭМГ-ын даргын 2022 оны А/85 дугаар тушаалаар гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөнд бие бүрэлдэхүүн, хүч хэрэгслийг тодотгож гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтад оролцож онц үнэлгээгээр дүгнэгдсэн. ЭМЯ, ХӨСҮТ-тэй хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтэн 120 хүнийг 2 удаагийн сургалтад хамруулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 85.0 хувьтай байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 90.0 хувь болж өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдсэн байна	100%
21		Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	60.0	Нөөц бүрдүүлэлт 50%	Эрүүл мэндийн байгууллагаудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна.	20.0	Эрүүл мэндийн гамшигийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 85.0 хувьтай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92.0 хувь, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98.0 хувьтай байна. 2022 оны байдлаар Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн.	100%
22	1.4.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах үйлчилгээг нэвтрүүлнэ.	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ БОЗТ	Эрүүл мэндийн байгууллагууд Олон улсын байгууллагууд	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Зайн оношилгоо-2 чиглэлээр хэрэгжиж байна. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалт 17%	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалтыг 33%-д хүргэсэн байна.	-	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд суурилагдсан зайн оношилгооны телемедициний хурлын төхөөрөмжөөр 134 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 512 холбогдох удирдлага эмч, мэргэжилтэн оролцсон байна. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100 хувьтай байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн телемедициний алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжөөр уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize программыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа	100%

												алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийн хангалтыг 37.9 хувьд хүрч, суурь үзүүлэлтээс 16,0 хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна.	
23		Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерыг үе шаттайгаар шинэчлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ БОЭТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 10%-д компьютерыг шинэчлэл хийгдсэн.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 50%-д компьютерийг шинэчилсэн байна.	-	Орон нутгийн төсөв 50,4	Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн 8 төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвүүд нь 2 mb/ps хурдтай интернетэд холбогдсон. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийг холбооны байрнаас эмнэлэг хүртэл шилэн кабелиар холбож байршуулснаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй холбогдох боломжтой болсон. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 90.0 хувьтай байна.	100%
24	1.5.Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих, "Эмч" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	520.0	Эмч хөтөлбөрийн хэрэгжилт 95.3%	Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.	120.0	Орон нутгийн төсөв 60,0	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор "Эмч" хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж орон нутгаас 60,0 сая төгрөгийг шийдвэрлэж, хөтөлбөрийн хэрэгжилт 96.0 хувьтай байна. - Гамшиг нийгмийн цаг үеийн байдалтай холбоотой дотоод сургалтад 1031 эмч, ажилтныг хамруулсан. - Австри улсын Зайлцбург хотод сургалтад 1 эмч, Япон улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын эмнэл зүй, эмгэг судлаач эмч нарын XVII их хуралд 1 эмч, Америкийн Нэгдсэн улсын Чикаго хотод болсон сургалтад 1 эмч, Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг хамруулсан. - Дэлхийн эмч нар болон олон улсын сувилагчдын өдрийн хүрээнд Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж шилдэг 12 илтгэлийг шалгаруулсан. Судалгааны арга зүйн сургалтад 68 эмч, сувилагчийг хамруулсан. Эмч, сувилагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, алдаршуулах хүрээнд ажил мэргэжлийн уралдаан 1, хэлэлцүүлэг 1, теле нэвтрүүлэг 4, аян 2 удаа зохион байгуулж, шилдэг 3 байгууллагыг шалгаруулсан. - Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн болон эрүүл мэндийн салбаруудын удирдлага 70 гаруй хүний төлөөлөл оролцсон. - Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 80 жилийн ой хүрээнд багш шавийн	100%

											уулзалтыг зохион байгуулж, 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - БОЭТ-ийн "Ерөнхий мэргэшил судлал"-аар тайлант хугацаанд 1 резидент эмч, төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцаж байна. - Англи хэлний чадварыг дээшлүүлэх сургалтад 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Тайлант хугацаанд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд гомдол ирээгүй. - 40-ээс дээш насны 329 эрүүл мэндийн ажилтанд хавдрын маркер хийлгэж, 3 мэргэжилтнийг нарийн мэргэжлийн эмчид илгээсэн байна. Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9 хувь нь, нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 17.0 хувь нь хамрагдсан байна.	
25		Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн чадавхийг сайжруулж нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургах	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 12.5%	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 13.5%-д хүргэсэн байна.	-	Тайлант хугацаанд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн, нийт 170 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна. Нэн шаардлагатай хүүхдийн мэс засал, компьютер томограф соронзон давтамжит дүрс оношилгоо судлалаар улсын төсвийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2 эмчийг сургалтад хамруулсан. Аймагт шаардлагатай тэргүүлэх чиглэл болох "Анатомийн эмгэг судлал"-ын үндсэн мэргэшлийн 2 жилийн сургалтад 1 их эмч, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн "Ерөнхий мэргэшил судлал"-аар тайлант хугацаанд 1 резидент эмч суралцаж байгаа ба "Эрчимт эмчилгээний сувилахуй", Яаралтай тусламжийн сувилахуй" чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтыг 2022 оны 10 сарын 01-нээс 16 сувилагч элсэн суралцаж байна. Нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 74,4 хувь ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдаж, 71 эмч, эмнэлгийн мэргэжилтэн лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажилласан байна. Төвийн болон орон нутагт зохион байгуулсан ажлын байран дээр дадлагажуулах 4 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан	100%

												байна. Докторын зэрэгтэй эмч 0,2 хувь, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 12.0 хувьтай байна. Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9 хувь нь хамрагдсан байна.	
Биеийн тамир, чийрэгжүүлэлт													
26	1.6.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт, баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ.	Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубын тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	ЭМД-ын сан	-	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо 3	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо 4	-		Манай аймгийн хэмжээнд 13 фитнес клуб үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 3 клубүүд магадлан итгэмжлэл авч ажиллаж байна. Тайлант онд 1 клуб спортын магадлан итгэмжлэлд хамрагдахаар материалаа ирүүлснийг Засгийн Газрын Тохируулагч Агентлаг-Биеийн Тамир, Спортын Улсын Хороонд албан бичгээр хүргүүлсэн. Тайлант онд фитнес клубээр хичээллэгсдийн тоог 130-аар нэмэгдүүлж, 1750 иргэн тогтмол хичээллэж байна.	70%
27		Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Тамирчдын тоо 140	Тамирчдын тоо 168	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 50,0	2022 онд өсвөрийн шигшээ багт теннисний төрлийг шинээр нэмж, тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж, нийт 15 төрөлд 168 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулиалт хийж байна. Өсвөрийн шигшээ багийн төрөл, тамирчдын тоо: сагсан бөмбөг 3х3, 5х5 төрөлд 28 хүүхэд, байт харваа-8, гимнастик-8, цана-8, хөлбөмбөг-20, бадминтон-8, бокс-8, буудлага-8, таеквондо-8, ширээний теннис-6, самбо, жүдо-16, чөлөөт бөх-10, волейбол-20, хөнгөн атлетик-12 тамирчин тус тус хичээллэж байна. Өсвөрийн шигшээ багийн төрлүүдээс сагсан бөмбөг, цана, хөл бөмбөг, буудлага, таеквондо, ширээний теннис, жүдо, самбо бөх, чөлөөт бөх, волейбол гэсэн спортын 9 холбоодын багш нартай гэрээ байгуулж ажиллаж байна. Өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр спортын холбоодтой хамтран зохион байгуулж, нийт 1550 тамирчин хамрагдсан байна. Мөн орон нутгийн төсвийн 33.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цанын өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилтад цанын иж бүрдэл 10, тэшүүр 8 ширхэгийг худалдан авч тамирчдыг хэрэглэл материалаар хангах ажлыг зохион байгуулсан.	100%
28		Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв, Спортын	Батлагдсан төсвийн	Зохион байгуулсан тэмцээний тоо 2	Зохион байгуулсан тэмцээний тоо 4	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 40,0	Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 4, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 тус тус орон нутагтаа зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2-оор, бүсийн аварга шалгаруулах	100%

						холбоод болон ААНБ-ын хандив	хүрээнд					тэмцээнийг 3-аар нэмэгдүүлж зохион байгуулсан. Үүнд: "Самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга" шалгаруулах тэмцээн, "Бадминтоны улсын аварга" шалгаруулах тэмцээн, "100 буудалт даам" сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээн, "Уулын дугуйн улсын аварга шалгаруулах" тэмцээн, "Усанд сэлэлтийн 30 дахь удаагийн өсвөр, насанд хүрэгчдийн улсын аварга" шалгаруулах тэмцээн, Монгол Улсын гавьяат тамирчин Д.Нармандахын нэрэмжит "Жудо бөхийн өсвөр үеийн аварга" шалгаруулах тэмцээн, "Жүдо бөхийн өсвөр үеийн төвийн бүс"-ийн аварга шалгаруулах тэмцээн, "Сумо бөхийн өсвөр үеийн төвийн бүсийн аймгуудын 9-12 насны аварга" шалгаруулах тэмцээн, "Мөсний шагайн харвааны хойд бүсийн тэмцээн"-ийг тус тус амжилттай зохион байгуулж орон нутгийн төсвөөс 30,0 гаруй сая төгрөг зарцуулсан байна. Дээрх тэмцээнд хот хөдөөгийн 2830 гаруй тамирчид оролцож манай аймгийн баг тамирчид 80 гаруй медаль хүртсэн амжилт үзүүлсэн.	
29		Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын их наадмыг шат дараатай зохион байгуулж, төрлүүдийн тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Спортын 5 төрөл	Спортын 6 төрөл	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 7,0	Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант сумын 25 багийн иргэдийн дунд спортын 6 төрөл /үндэсний бөх ширээний теннис, орс таталт, буудлага, сагсан бөмбөг, волейбол/-өөр тэмцээн зохион байгуулж, 1200 гаруй иргэдийг хамруулсан. Энэхүү тэмцээнд үндэсний спортын төрөл мөн техник спортын төрлүүдийг шинээр нэмэгдүүлсэн.	100%
30		Спортын хэрэгслийн (ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр) түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих	2021-2024	НБХ	БТСГ ХЗА	Орон нутгийн төсөв	-	-	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдсэн байна.	-		Тайлант онд чарга, тэшүүр, дугуйн түрээсийн болон төлбөрт үйлчилгээнд 6500 гаруй иргэн хамрагдсан байна. Үүнд: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н Сархиа цанын баазад чарганы төлбөрт үйлчилгээнд 1800 гаруй, "Эрдэнэт спорт амралтын хүрээлэнг"-ийн 400 метрийн мөсөн талбайд 01 дүгээр сараас 03 дугаар сар хүртэл тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 орчим иргэн хамрагдсан байна. Мөн ердийн болон гэр бүлийн дугуйн түрээсийн үйлчилгээ үзүүлэх 1 иргэнтэй гэрээ байгуулж А.Амарын талбай, "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д 05 дугаар сараас 10 дугаар сард түрээсийн үйлчилгээ үзүүлж давхардсан тоогоор 3500 иргэн тус тус хамрагдсан.	100%

31	1.7.Хүн амын зорилтот бүлгүүд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.	Ахмадуудад спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хичээллэгсдийн тоо 750	Хичээллэгсдийн тоо 800	Батлагдсан төсвийн хүрээнд	Ахмад настныг биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангах зорилгоор 4 спорт зааланд 7 хоногт 2 цагаар үнэ төлбөргүй хичээллэх орчинг бүрдүүлж, 600 гаруй ахмад софт волейбол, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг зэрэг спортоор хичээллэж чөлөөт цагаа идэвхтэй өнгөрүүлж байна. Мөн аймгийн ахмадын хорооны чийрэгжүүлэлтийн зааланд хуваарийн дагуу багийн ахмадууд хийн дасгал, чийрэгжүүлэлтийн дасгалуудаар хичээллэж байна. Аймгийн хэмжээнд ахмадад чиглэсэн 7 удаагийн уралдаан тэмцээнд 820 ахмадыг хамруулж ажилласан.	75%	
32		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулах уралдаан тэмцээний төрлийг нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хичээллэгсдийн тоо 250	Хичээллэгсдийн тоо 300	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 10,0	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Биеийн тамир, спортын газрын А, Б зааланд спортын 4 төрлөөр 7 хоногт 5 удаа 2 цагаар үнэ төлбөргүй хичээллэх нөхцлийг бүрдүүлсэн. Иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх зорилгоор 210 хүн хамрагдаж байна. Үүний үр дүнд Монголын бүх ард түмний спортын XV наадмын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд сагсан бөмбөг, волейбол, хонхот бөмбөг, суугаа волейбол, хөнгөн атлетикийн анхан шатны тэмцээнийг амжилттай зохион байгуулж нийт 167 тамирчин хамруулсан. Шигшээ тэмцээнд 34 тамирчин оролцсоноос суугаа волейболын төрөлд эмэгтэй баг хүрэл медаль, пара хөнгөн атлетикийн төрөлд 1 мөнгөн медаль, хонхот бөмбөгийн төрөлд эмэгтэй баг хүрэл медаль авсан амжилтыг тус тус үзүүлсэн.	90%
33	1.8.Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн өрнүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж, спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аяныг аймгийн иргэд болон ААНБ-уудын дунд өрнүүлэх	2021-2024	БТСГ БШУГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хамрагдах иргэдийн тоо 7000	Батлагдсан төсвийн хүрээнд	"Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аян болон "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны арга хэмжээг аймгийн хэмжээнд өглөө бүр 06.30-07.30 цагт зохион байгуулж ажиллалаа. Аяны хүрээнд аймгийн хэмжээнд спорт заал-4, гадна талбай-9, танхим-11, бүжгийн клуб-1, төрийн болон төрийн бус 44 байгууллага, иргэд хамтран ажиллаж нийт давхардсан тоогоор аймгийн 44856 иргэн аянд нэгдэж идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр эрүүл амьдралын дадлыг хэвшүүлээд байна. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг өглөө 6:30-7:30 цагт иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулж "Эртэч Эрдэнэтчүүд" өглөөний дасгалыг зохион байгуулж, 10000 гаруй эцэг эхчүүд, сурагчдыг хамруулсан. Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл амьдралын дадалыг олгох нөхцөл бүрдсэн.	100%	

34		Биеийн тамир, спортоор хичээллэх заал талбайг нэмэгдүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ-ын НБХ	БТСГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	33	Жил бүр 1 талбай нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулиудад 34 спорт заал үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н санхүүжилтээр "Энэрэл төв"-д 18х24 харьцаатай спорт заал, улсын төсвийн санхүүжилтээр ерөнхий боловсролын 1-р сургуулийн барилгын өргөтгөлд 18х24 харьцаатай спортын заал тус тус ашиглалтад орсноор аймгийн 1 хүнд ногдох спорт заалны хүртээмжийн индекс 2021 онд 0.11м2 байсан бол 2022 онд 0.13м2 болж өмнөх оноос 0.02м2 -иар нэмэгдсэн.	100%
35	1.9.Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, боловсон хүчин болон материаллаг баазаар ханган хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.	Өвлийн спортын дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2023	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хэрэгжилтийн хувь 10%	Хэрэгжилтийн хувь 70%	Батлагдсан төсвийн хүрээнд	Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 11 арга хэмжээг 100 хувь, 1 арга хэмжээ 70 хувиар, 1 арга хэмжээг 50 хувиар, 2 арга хэмжээг 30 хувиар тус тус хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг 86.5 хувьд хүргэж ажилласан. Орон нутгийн төсвөөс 23,1 сая төгрөгийг зарцуулсан. "Эрдэнэт мөнгөн өвөл-2022" аяныг зохион байгуулж спортын 6 төрлөөр 300 гаруй тамирчдыг хамруулсан аймгийн аварга шалгаруулах болон нээлттэй тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулсан. Мөн Эрдэнэт спорт, амралтын хүрээлэнд 400м мөс тавьж тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 гаруй хүүхэд залуус хамрагдсан бол ерөнхий боловсролын сургуулиудын 26 биеийн тамирын багш, дасгалжуулагч нарт "Цанын спортын үүсэл хөгжил, түүнд хийсэн дүн шинжилгээ" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Хөтөлбөр хэрэгжсэнээр өвлийн спортын секц, дугуйланд хамрагдагсдын тоо сүүлийн 2 жилд 180-аар нэмэгдсэн байна.	100%
36		"Эрдэнэт-Спорт амралтын хүрээлэн" болон ЕБС-иудын гаднах талбайд өвлийн спортоор хичээллэх орчин бүрдүүлэх	2021-2024	БТСГ БШУГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Мөсөн талбайн тоо 3	Жил бүр 1 талбайн нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Тайлант онд "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д 400м мөсөн зам, Сархиа цанын бааз, Хангарьд клубын хоккейн талбайд мөсөн талбайг байгуулж, чарга, тэшүүрийн түрээсийн үйлчилгээг 3200 гаруй иргэдэд үзүүлж, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцлийг бүрдүүлсэн. Мөн ерөнхий боловсролын 2, 15, 20 дугаар сургуулиудын гадна талбайд мөс тавихаар бэлтгэл ажил хангагдсан. -Монголын "Цасан зам"-ын холбооны төлөөлөл хүрэлцэн ирж "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-н Сархиа уулын урд энгэрт олон улсын стандартанд нийцсэн 2.7 км бүхий гүйлтийн цанын зам байгуулах транс хэмжилт хийсэн.	70%

ХОЁР.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД, АХМАД НАСТАН

37	2.1.1.Гэр бүлд суурилсан салбар дундын уялдаа холбоог сайжруулан идэвхэжсэн хандлага оролцоог дэмжинэ.	Зорилтот гэр бүлд чиглэсэн ажил, үйлчилгээг сайжруулах	2021-2024	ГБХЗ ХГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв	60.0	Зорилтот гэр бүлийн 10%	Зорилтот гэр бүлийн 20%	15.0	Улсын төсөв 10,0	Орхон аймгийн хэмжээнд 0-18 насны хүүхэдтэй 153 өрх толгойлсон эцэг, 1250 өрх толгойлсон эх байна. Үүнээс Дэлхийн Зөн ОУБ-ын дотоодын хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт 532 өрх хамрагдаж байна. Эдгээр өрхүүдэд гэр бүлийн боловсрол олгох , Гамшгийн үед өрхийн бэлэн байдлыг хангах чиглэлээр сургалт үйл ажиллагаанд хамруулан ажиллаж байна. Өрх толгойлсон аавуудын хувьд “Аавын хайр” чуулган зохион байгуулж, тэдэнд тулгамдаж буй асуудлыг 2023 оны төлөвлөгөөндөө тусган ажиллахаар зорьж байна. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах арга хэмжээний хүрээнд 46 төрлийн зөвлөмж, постер гарган цахимаар түгээн дэлгэрүүлсэн. Иргэдийн хандалт 5300 гаруй байна. 2022 оны байдлаар Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 32 насанд хүрэгч болон хүүхдүүдийг түр хамгаалах байранд байрлуулж, хуулийн дагуу үйлчилгээ үзүүлсэн. Жаргалант суманд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх арга хэмжээний хүрээнд архины хамааралтай хэдий хандлага өөрчлөх, амьдралын чанараа дээшлүүлэх хүсэл, эрмэлзэлтэй өрхийн гишүүдтэй бүлгийн ярилцлага зохион байгуулж, сэтгэл зүйн мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналтад авч ажиллаж байна. Энэ хүрээнд 35 өрхийн хүүхдийн мөнгө олголтыг хүүхдийн эрхийн улсын байцаагчийн шийдвэрээр түр зогсоосон байсныг сэргээн, хүүхдийн мөнгийг зориулалтын дагуу ашиглах талаар ярилцаж, шийдвэрлэсэн. Түүнчлэн алхам алхмаар хөтөлбөрийн үйлчилгээг 11 өрхөд үзүүлж, хуулийн болон сэтгэл зүйн зөвлөгөөг 111 хүнд өгч ажилласан. Нийт 8 төрлийн сургалт, нөлөөллийн ажилд 427 өрхийг хамруулсан.	90%
38		Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Улсын төсөв	20.0	Нийт өрхийн 15%	Нийт өрхийн 25%	5.0	Улсын төсөв 3.0	Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтын хүрээнд багийн иргэдийн төлөөлөл, байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан. Байгууллагуудаас ирсэн хүсэлтийг үндэслэн “Эрдэнэт үйлдвэр”-ийн Ил уурхайн цех, Татварын хэлтэс, Гаалийн газар, “Орхон АЗЗА” ТӨХК, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 0437-р хорих ангийн ажилтан, хүмүүжигчид, ОБГ-ын салбар 81-р анги, ЗХ 186-р ангийн албан хаагч, офицеруудад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль болон хувь хүний хөгжлийн сургалтыг	100%

											явуулж, 907 гэр бүл, багуудаар дамжуулан 56 удаагийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнд нийт 2607 иргэд хамрагдсан. Дэлхийн гэр бүлийн өдрөөр Гэр бүлийн өдөрлөг, Гэр бүлийн чуулган, Онол практикийн бага хурал, гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн зэргийг зохион байгуулж, 8539 гэр бүлийг оролцуулан, аймгийн хэмжээний нийт өрхийн 30 гаруй хувийг хамруулсан байна. Цаашид “Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулах талаар судлан ажиллаж байна.		
39		Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Улсын төсөв	20.0	Эцэг эхчүүдийн 10%	Эцэг эхчүүдийн 20%	5.0	Улсын төсөв 2.0	Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийн дарга, гишүүдийг чадавхжуулах, бусад эцэг эхэд сургалт зохион байгуулах арга зүй мэдээ, мэдээллээр хангах зорилгоор "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтыг 17 байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад сургагч багш нараар дамжуулан зохион байгуулж, 1135 багш ажилтан, 10046 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, гэр бүл судлаач нартай хамтран 6-18 настай хүүхэдтэй асран хамгаалагчдыг хүүхдийн хамт бүлгийн сургалтад хамруулж, хүүхдийн нас насны онцлогт тохирсон зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн онцлогт хэрхэн зөв харилцан ойлголцож, ярилцах тухай, мөн хүүхдүүд томчуудтай харилцах харилцааны тухай мэдлэг мэдээллийг олгосон. Сургалтад 120 гаруй гэр бүл хамрагдлаа. Нийт 5 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 12681 эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүд оролцсон.	100%
40		Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд чиглэсэн төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Орон нутгийн төсөв	-	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн 30%-д хүрсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 88.0	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 61 дүгээр тогтоолоор "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг батлуулан 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна."Жендерт суурилсан хүний эрхийг хүндэтгэе" аяныг 5 сарын турш зохион байгуулж, жендерийн тухай ойлголт мэдээллийг олон нийтэд сурталчилсан. Тухайлбал аяны хүрээнд: "Эмэгтэйчүүдийн эрх, хөгжил - өнөөгийн байдал" сургалт, "Гэр бүлийн үнэ цэн" өглөөний уулзалт, "Гэр бүлийн уламжлал, хөгжлийн чиг хандлага" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ онол-практикийн бага хурал, гэр бүлийн өдөрлөг, хүмүүжлийн эерэг арга сургалт, гэр бүлийн чуулган зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулсан. Түүнчлэн "Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй	90%

											төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл, Орхон аймгийн "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"- ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн шийдвэр гаргах түвшинд болон бодлого тодорхойлох түвшинд ажиллаж байгаа төрийн албан хаагч эмэгтэйчүүд, улс төр, бизнес, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоо зэрэг салбар бүртээ манлайлан ажиллаж байгаа эмэгтэйчүүдээ дэмжих, шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг хангах, удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих зорилготой "Эмэгтэйчүүдийн манлайлал" сургалтыг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнд давхардсан тоогоор 6500 гаруй охид, эмэгтэйчүүд хамрагдсан. Үүнээс гадна "Гэр бүлийн харилцаа" сэдвээр эрдэмтэн, докторуудын илтгэлийг эмхэтгэн 200 ширхэг гарын авлага, номыг хэвлүүлэн гэр бүлүүдэд хүргэсэн.		
41	2.1.2.Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж, салбар дундын үйл ажиллагааг сайжруулна.	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах	2021-2024	ГБХЗ ХГ	Аймгийн ГХУС АЗСЗ	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	40.0	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 40%	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 55%-д хүрсэн байна.	10.0	Улсын төсөв 10.0	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу хамтарсан багийн 30 кейс үйлчилгээнд дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 22 багийн нийгмийн ажилтнуудад сургалтын гарын авлагыг "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр бэлтгэн хүргүүлж, арга зүйгээр ханган ажиллаж байна. Үүний дагуу багийн нийгмийн ажилтнууд иргэдэд сургалт зохион байгуулж, 5200 орчим иргэдийг хамруулсан. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газрын бэлтгэсэн контентуудыг цахим хуудсаар түгээх нөлөөллийн үйл ажиллагаа тогтмол хийгдэж байна.Хамтарсан багийн гишүүдийг 2022 онд нийт 8 удаа сургалт болон зөвлөн туслах арга хэмжээнд оролцуулсан. Зөвлөн туслах ажлын хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, сайжруулах тал дээр арга зүйгээр ханган байнгын эргэх холбоотой ажиллаж байна.	90%
42		Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад холбогдох	2021-2024	ГБХЗ ХГ	Хамтарсан багууд	Улсын төсөв	60.0	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 90%	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 95%-д хүрсэн байна.	15.0	Улсын төсөв 15.0	Хүүхдийн тусламжийн 108 утсанд 265 дуудлага ирснээс хүүхэд хамгааллын дуудлага 245, зөвлөгөө хүссэн 17 дуудлага, өргөдөл гомдлоор 3 дуудлага, мэдээлэл ирсуна 95 хувийг нь шийдвэрлэсэн байна.. Нийт дуудлагын 82,2 хувь буюу 226 нь гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн дуудлага бөгөөд дуудлагын 40,8 хувийг сэтгэл санааны	95%

		байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах (108 утас, бусад хүсэлт, гомдол)									хүчирхийлэл, 27,7 хувийг үл хайхрах, 25,3 хувийг бие махбодын хүчирхийлэл эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргагч нь аав-76 буюу 33,6 хувь, ээж-71 буюу 31,4 хувийг эзэлж байна.Харин дуудлага өгсөн субъект нь хүүхэд өөрөө -62 буюу 23,3 хувийг эзэлж байна. Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд “Нэгдүгээрт шалга” арга хэмжээг гэрээс сургууль хүртэлх, гэрийн аюулгүй байдал, тоглоомын талбайн аюулгүй байдал, төрийн байгууллагын гадаад дотоод орчны аюулгүй байдал зэрэг чиглэлээр зохион байгуулж, төрийн захиргааны 32 байгууллага, ерөнхий боловсролын 32 сургууль, 27 цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран нийт 45140 эцэг эх, асран хамгаалагч гэрийн аюулгүй байдлын үнэлгээгээ, төрийн өмчийн 45 байгууллага, ерөнхий боловсролын 32 сургууль, 27 цэцэрлэгүүдийн эцэг эхийн зөвлөлүүд байгууллагынхаа гадаад дотоод орчны аюулгүй байдлыг үнэлэн 340 гаруй эрсдэлийг илрүүлж, засаж сайжруулж, аюулгүй, хүүхдэд ээлтэй болгосон. “Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны 6 төрлийн постер, видео хийж, олон нийтийн сүлжээгээр түгээж, сурталчилсан. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг Жаргалант суманд зохион байгуулж, Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын баг, Эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд аргазүйн зөвлөгөө өгч, 208 иргэнд хүрч үйлчилгээ үзүүлээ.		
43		Эрсдэлийн программд бүртгэгдсэн эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдүүдийг хөгжлийн үйлчилгээнд хамруулах	2021-2024	ГБХЗ ХГ	БТСГ	Улсын төсөв	40.0	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 6% хамруулсан.	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 10% хамруулсан байна.	10.0	Улсын төсөв 10.0	Орхон аймгийн хэмжээнд Эрсдэлийн программд бүртгэлтэй эрсдэлт нөхцөлд байгаа 144 хүүхэд байгаа бөгөөд хүүхдүүдийн нөхцөл байдалд дахин үнэлгээ хийж, 29 хүүхдэд кэйс менежментийн төлөвлөгөө гарган хариу үйлчилгээг үзүүлсэн. Нөхцөл байдлын үнэлгээгээр ар гэрийн дэмжлэг тааруу байгаа нь тогтоогдсон 100 хүүхдэд дархлаа сэргээх эрүүл мэндийн багцыг олгосон. Хүүхдийн ордны хөгжлийн хөтөлбөрийн ардын бүжиг, хар уран зураг, шатар, төгөлдөр хуур, математик соробан сампин зэрэг дугуйланд нийт 18 хүүхдийг хамруулан ажиллаж байна. Эрсдэл өндөртэй гэр бүлийн зөрчил маргаантай, архины хамааралтай гэр бүлд амьдарч байгаа 29 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, халамжийн үйлчилгээ, хувцаслах зэрэг үйлчилгээг үзүүлсэн. Хүүхдүүдийн эцэг эхчүүдийг хүмүүжлийн зэрэг арга сургалт, гэр бүлийн боловсрол олгох сургалтуудад хамруулан, 5	100%

											эмэгтэйд хордлого тайлах эмчилгээ хийлгэн зан үйлийг өөрчлөх сургалтад үе шаттайгаар хамруулж байна. Баян-Өндөр сумын гэрээр айлчлах төслийн хүрээнд 164 хүүхэд өндөр эрсдэлтэйгээр тодорхойлогдсон. Эрсдэлт нөхцөлд байгаа 98 хүүхдэд эргэн хяналтыг зохион байгуулсан. Үүнээс өндөр эрсдэлтэй 258 хүүхдийг Номин даатгалтай хамтран хүүхдийн эрсдэлийн даатгалд хамруулсан.		
44		Түр хамгаалах байрны үйл ажиллагааг сайжруулах	2022-2024	ГБХЗ ХГ	ХЭЗХ ЦГ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Үйлчлүүлсэн иргэдийн тоо	Хамгаалах байрны хэрэгцээт орон тоо батлагдаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв 30.0	2022 онд нийт 35 үйлчлүүлэгч хүлээн авч, гэр бүл тус бүрээр нь 12 кейсд, бүртгэл нээн хооллох, хувцаслах, усанд оруулах зэрэг үйлчлүүлэгчийн суурь хэрэгцээг ханган, үйлчилгээ үзүүлсэн. Хамгаалах байрнаас иргэн өөрийн хүсэлтээр гарсан-4 тохиолдол, Хамтарсан баг хуралдаж ар гэрт нь хүлээлгэж өгсөн-12, Цагдаагийн албан хаагчид хүлээлгэж өгсөн-2 байна. Давтан үйлчлүүлсэн иргэд, хүүхэд байхгүй. 2022 оны байдлаар "Түр хамгаалах байр"-аар үйлчлүүлсэн 16 өрхөд эргэн хяналтыг хийж ажиллаж байна. Эргэн хяналтыг хийж, нөхцөл байдлын үнэлгээг хийснээр цаашид ямар үйлчилгээг үзүүлэх талаар төлөвлөгөө гарган ажилладаг.	90%
45	2.1.3.Залуучуудад чиглэсэн арга хэмжээ, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тэдний оролцоог дэмжинэ.	Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг сайжруулах	2021-2024	ГБХЗ ХГ	Баян-Өндөр сумын ЗДТГ	Улсын төсөв	32.0	Залуучуудын хамрагдалт 25%	Залуучуудын хамрагдалт 35%-д хүрсэн байна.	8.0	Улсын төсөв 8.0	Залуучуудад эрүүл амьдралын хэв маягийг сурталчилан таниулах, цахим эмч нөлөөллийн үйл ажиллагаа, эмэгтэйчүүд болон эрчүүдийн 8 эмнэлгийн товч танилцуулга зэргийг бэлтгэн цахимд байршуулснаас гадна өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран зохион байгууллаа. Мөн залуус харилцаанд суралцах нь, өөртөө итгэх итгэл, стрессээ зохицуулах нь, бусадтай харилцах харилцаа, бусдыг мэдэрч ойлгох нь, бусадтай холбоо тогтоох чадвар, сэтгэл зүйн дархлаатай болох, сэтгэл зүйн байдлаа хэрхэн тогтвортой байлгах, өөрийн үнэлгээг нэмэгдүүлэх нь зэрэг сэдвүүдээр онлайн хичээл бэлтгэж цахимд байршуулж олон нийтэд хүргэсэн. Мөн дээрх сургалтуудыг ШШГГ-ын 437-р хорих анги, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн сурагчид, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагчдад зохион байгуулсан.	90%

											Насан туршийн боловсролын төвтэй хамтран компьютерийн анхан болон дунд шат, англи хэлний сургалтуудыг зохион байгуулсан. Мөн сурагчдын "ЗӨГИЙ" сайн дурын клубынхэнтэй хамтран хүүхдүүдийн сурлагын хоцрогдлыг арилгах, сурах эрмэлзлэлийг нэмэгдүүлэх зорилгоор "ҮС АКАДЕМИ" арга хэмжээг зохион байгуулж, 4-6 дугаар ангийн хүүхдүүдэд сонирхсон хичээлээр давтлага өгөх зэрэг ажлуудыг эхлүүлсэн. Гадаадад суралцахаар зорьж буй хүүхэд, залууст ielts, toefl шалгалтанд хэрхэн бэлдэх, Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, гадаадын их сургуулиуд руу APPLY хийхэд анхаарах зүйлс зэрэг өсвөр насны хүүхэд залууст хэрэгтэй мэдээллийг өгөх уулзалтыг үе шаттай хийж байна. Мөн гэр бүлээ төлөвлөж байгаа залуучуудад зориулсан гэр бүлийн боловсрол олгох онлайн сургалтыг цахимаар дамжуулан хүргэснээс гадна гэр бүлийн радиогийн "Тэдний ертөнц" цуврал нэвтрүүлгээр дамжуулан зөвлөгөө мэдээллийг хүргэх ажлыг улирал тутам хийж байна. Залууст зориулсан ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг 174 хүнд, бүлгийн зөвлөгөө засал үйлчилгээг 240 хүнд, сэтгэц оношилгоо, архаг ядаргаа, стрессийн түвшин, зурган тестийн аргаар оношлох, темперамент тодорхойлох гэх зэрэг нийт 24 төрлийн тест оношилгоог 261 хүнд хийж, зөвлөгөө зөвлөмжийг хүргэн ажилласан. Залуучуудын сарын аяны хүрээнд оролцоо төслийн төгсөгч залуучуудад хувь хүний, эрүүл мэндийн, гэр бүлийн боловсрол олгох чиглэлийн хүрээнд оролцоог үргэлжлүүлэе залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулсан. Оролцоо төслийн 1, 2 хөтөлбөрт хамрагдсан 73 залуучуудын судалгааг авч сургалтын талаарх мэдээллийг хүргэсэн. Сургалтад 30 орчим залуучууд хамрагдсан. Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг явуулснаар залуусын амьдралын хэв маяг, сэтгэлгээнд урт хугацааны дэвшил гарсан. 20 багц арга хэмжээний хүрээнд 9000 гаруй залуучуудыг хамруулсан. Амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг явуулснаар залуусын олонхид хүрэх энэ чиглэлийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж, тэдний амьдралын хэв маяг, сэтгэлгээнд урт хугацааны дэвшил гарах сэдэл хандлага, суурийг бий болгосон. Залуучуудын өөрт шаардлагатай мэдээллээ хаанаас авах талаар ойлголт, мэдлэгийг	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											нэмэгдүүлж, мэдээлэлд ойртуулж өгснөөрөө идэвх оролцоо сайжирсан.		
46		Залуучуудын ордны үйл ажиллагааг тогтмолжуулах	2021-2024	ГБХЗ ХГ	Залуучуудын ордон	Улсын болон орон нутгийн төсөв	-	Тохижилт хийгдсэн байна.	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	224.0	Орон нутгийн төсөв 183,6	Залуучуудын ордон, Залуучуудын хөгжлийн төв нь Турник экстрем спорт сонирхогчдын Эрдэнэт хотын “RATG” клубтэй хамтран Турник экстрем тэмцээн, ширээний теннисний тэмцээн, өглөөний дасгал үйл ажиллагаа, дуу, хөгжим сонирхогч өсвөр үе, залуучуудад өөрийгөө нээх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, урлагийн чиглэлээр өөрийгөө хөгжүүлэхэд дэмжих зорилготой Open Mic арга хэмжээ, хорих ангид хүмүүжиж байгаа залуучуудын дунд 4 төрөлт спортын тэмцээн, “Танд захидал ирлээ” нөлөөллийн үйл ажиллагаа, гэгээн хайрын баярыг тохиолдуулан нийгэмд эерэг харилцааг түгээх зорилгоор “Хайрын бэлэг” контент, “Номын бартер” өдөрлөг, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо аяны хүрээнд “Сагсан бөмбөг”-ийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, гэр бүлийн эерэг харилцааг дэмжих, олон нийтэд сурталчлан таниулах, аав охидын нандин холбоог бататгах зорилготой “Аав охидын өдөр”, Мэтгэлцээний өдөрлөг, Маргаашийн манлайлал өдөрлөг зэрэг нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан. Сонирхлын клубүүдэд 150 гаруй залуучууд бүртгэгдээд байна. 2022 оны байдлаар нийт 60 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, 20 гаруй удаагийн цахим сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 16000 орчим залуучуудыг хамруулан ажилласан.	100%
47		Сайн дурын ажилд залуучуудын оролцоог дэмжих, сайн дурын ажилтнуудыг бүртгэлжүүлэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	ХХҮГ	Улсын төсөв	4.0	Сайн дурын ажилд хамрагдагсдын тоо 25	Сайн дурын ажилд хамрагдагсдын тоо 35	1.0	Улсын төсөв 1.0	Сайн дурын ажлын хүрээнд нэг байгууллага нэг сайн дурын ажил, нэг залуу нэг санаачлага сайн дурын ажил уриан дор байгууллага аж ахуй нэгж, багийн залуучуудын салбар зөвлөлийг уриалан ажиллаж, 60 гаруй байгууллага, 22 багийн залуучуудын салбар зөвлөл нэгдэж, 80 гаруй сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж, бүтэн өнчин 19 настай хүүг амьдрах гэртэй болгож, гал голомтыг нь бадрааж, хашааны газрыг нь шийдэж, ажил орлоготой болгосон. -Залуучуудын ордны дэргэдэх Сайн дурынхны клуб Залуучуудын хөгжлийн төв-Залуучуудын ордны албан хаагчдтай хамтран Турк улсад эмчилгээнд орж байгаа иргэнд зориулсан 10 ширхэг хандивын хайрцгийг хийж ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгсөн. Мөн залуучуудад хэрэгцээт мэдээллийг хүргэх зорилгоор ЗХТ-Залуучуудын ордны цахим хаягийн	100%

											мэдээлэл бүхий QR кодыг багууд болон ЕБС-уудад байршуулах ажлыг тус тус зохион байгуулсан. -Орхон аймгийн залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх ""VU САЙН ДҮР""-ын бүлгэмийн VUTFLIX төсөл 3 үе шаттайгаар зохион байгуулагдсан. -Залуу малчин, тариаланчдад туслах залуучуудын санаачилгыг дэмжих замаар улс орны бүтээн байгуулалт, хөгжилд залуучуудын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, сурталчлах зорилготой "Шинэ цагийн илгээлтийн эзэд" малчин, тариаланчдад туслах сайн дурын ажлыг зохион байгуулж Жаргалант сумын тариаланч залуу гэр бүлд туслан 20 цагийн сайн дурын ажил хийсэн. Үйл ажиллагаандаа идэвхтэй оролцдог 15 гишүүндээ "БАТЛАМЖ" 12 гишүүнд үнэмлэх гардуулж, "Чадах зүйлээрээ туслая" аяныг эхлүүлж өөрсдөө Лаа, саванг хийж борлуулалтын мөнгийг цуглуулж Дундговь аймгийн "Ид шидийн уут" аянд хандивласан. 2022 оны байдлаар дээрх болон бусад сайн дурын клубүүдтэй хамтран 6 арга хэмжээг зохион байгуулж, амжилттай ажилласан.		
48		"Өндөр ёс зүйтэй-өөдрөг иргэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	ГБХЗ ХГ	Орон нутгийн төсөв	30.0	Хөтөлбөр ийн хэрэгжилт 65%	Хөтөлбөрий н хэрэгжилт 100%	Батлагд сан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 30.0	"Өндөр ёс зүйтэй өөдрөг Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Олон улсын мэргэжлийн хөгжлийн институттэй хамтран "Чадварлаг Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд "Оюуны элч" манлайлагчдыг бэлтгэх эхлэлийг тавих суурь хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлсэн. "Оюуны элч" манлайлагчид нь салбар бүртээ зөв хандлага, ур чадвараараа бусдыгаа уриалж, Эрдэнэт хотын хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулах зорилготой. "Оюуны элч" манлайлагч бэлтгэх урт хугацааны хөтөлбөрт боловсролын салбарын багш, ажилтнууд, иргэдийн төлөөлөл, анхдагчдын холбоо болон ахмадын холбооны ахмадууд, Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, багуудын хэсгийн ахлагч нар, Баян-Өндөр сумын багийн Засаг дарга нар, багуудын Залуучуудын салбар зөвлөлийн төлөөлөл зэрэг нийт 500 хүнд хувь хүний хөгжил, ёс зүй, манлайлал, бүтээмж, бүтээлч байдлын чиглэлээр "Идэвхжүүлэх" сургалтыг Олон Улсын NCS стандартын сургалтын агуулгын хөтөлбөр, хувь хүний ур чадварын сургалтын 3 сэдвийг Олон улсын мэргэжлийн хөгжлийн институтын "Олон улсад мөрдөгддөг суурь ур чадварын стандарт" суурилан боловсруулсан агуулгын дагуу зохион явуулсан. Мөн нийт оролцогчдод "Хувь хүний хөгжил". "Аз жаргалтай	100%

											гэр бүл", "Хувь хүний хөгжлөөс-Улсын хөгжил", "Эрүүл мэнд-Эрүүл дадал", "Хог хаягдал, тогтвортой хөгжил", "Зохист хэрэглээ", "Боловсрол" сэдвээр орон нутгийн удирдах албан тушаалтнууд, холбогдох албаны хүмүүс, харилцааны урлагийн чиглүүлэх багш нар илтгэл танилцуулж, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, нийгмийн бусад салбарт тулгамдаж буй асуудлыг танилцуулж, түүнийг шийдвэрлэх аргачлалын талаар шаталсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.		
49	2.1.4.Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, төсөл хэрэгжүүлнэ.	“Ач санах” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	Аймгийн ахмадын хороо	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хэрэгжилтийн хувь 60%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 70,0	Ахмад настны “Ач санах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ахмадын хороотой хамтран Мөрдөстэй ахмадууд, Буянт ээж, Дуулах өдөр дуун цэнгүүн, Софт воллейбол, шатар, теннис, гарбөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 2500 гаруй ахмадыг хамруулсан. Ахмад настны өдрийн үйлчилгээг аймгийн улаанзагалмайн хороотой хамтран зохион байгуулж 45 ахмад хамрагдсан. Мөн Цагаанчулуут, Хүрэнбулаг багуудын үйл ажиллагаанд хөтөлбөрийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажилласан. “Буурлын чагнуур” ТББ-тай хамтран хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хүрээнд Оюуны элч бэлтгэх идэвхижүүлэх хөтөлбөрт багуудын ахмадын төлөөлөл 100 иргэнийг 2 өдрийн сургалтанд хамруулсан. Сар шинийн баярыг тохиолдуулан аймгийн хэмжээнд 70 ба түүнээс дээш настай 2750 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн. Мөн хийн дасгалаар хичээллэж буй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг тус тус зохион байгуулсан.	100%
50		“Анхдагч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	ТББ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хэрэгжилтийн хувь 60%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв - 40,0	“Анхдагч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 27,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус дэмжлэгийн хүрээнд хүнсний багц 100, хэвтрийн өвчтэй хүмүүст гэр эргэлт 80, тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг 4 удаа 250 гаруй анхдагчийг тус тус хамруулсан. Мөн номын баяр,бүх нийтийн цэвэрлэгээ,мод тарих зэрэг үйл	70%

												ажиллагаанд 300 гаруй анхдагч илгээлтийн эзэд хамрагдсан.	
51	2.1.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх	2021-2023	ГБХЗ ХГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хөтөлбөрийн хэрэгжилт 20%	Хөтөлбөрийн хэрэгжилт 70%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 50,0	"Жендэрт суурилсан хүний эрхийг хүндэтгэе" 5 сарын аяныг 3-6 дугаар сар хүртэл зохион байгуулсан. Аяны хүрээнд "Эрчүүд нийгмийн хөгжилд", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо", "Бүх хайраа гэр бүлдээ" зэрэг зөвлөгөөн зохион байгуулж 1358 хүн, "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийн нээлт, эмэгтэйчүүдийн сургалт, уулзалтуудад 150 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж, нийгэмд үлгэр жишээ үзүүлж байгаа 5 аавыг алдаршуулсан. Орхон аймгийн Засаг даргын захирамжаар сар бүрийн 4 дэх долоо хоногийн Бямба гарагийг гэр бүлийн хөгжлийн өдөр болгон зарлаж, "Гэр бүлийн өдөр"-тэй болсон. Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Гэр бүлийн хөгжил оролцоо аян"-ы хүрээнд "Гэр бүлийн өдөрлөг"-ийг Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнд өртөөчилсөн тоглолт, уралдаан тэмцээн байдлаар зохион байгуулж, өдөрлөгийн үйл ажиллагаанд нийт 1500 гаруй хүн хамрагдсан. Амарын талбайд Орхон аймгийн Цагдаагийн байгууллагын 5 хос, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн 3 хосын хуримыг аймгийн Гэр бүлийн ордноос нийгмийн хариуцлагын хүрээнд ёсчлон батламжилсан. "Бүх хайраа гэр бүлдээ" сэтгэл зүйн нээлттэй өдөрлөг зохион байгуулж, 1800 гаруй иргэд хамрагдлаа. Нийт 10 гаруй төрлийн үйл ажиллагаанд 12000 иргэн хамрагдсан байна. 9 дүгээр сард "Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл, Орхон аймгийн "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн шийдвэр гаргах түвшинд болон бодлого тодорхойлох түвшинд ажиллаж байгаа төрийн албан хаагч эмэгтэйчүүд, улс төр, бизнес, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодууд зэрэг салбар бүртээ манлайлан ажиллаж байгаа эмэгтэйчүүдээ дэмжих, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах, удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих зорилготой "Эмэгтэйчүүдийн манлайлал" сургалтыг 18-21 өдрүүдэд зохион байгуулж, нийт 120 гаруй эмэгтэйчүүд хамрагдсан.	100%

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ												
2.2.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.												
52	2.2.1.Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулна.	Нийгмийн халамжийн үйлчилгээг ehalamj системд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	10%	60%	Батлагдсан төсвийн хүрээнд	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 08 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь ehalamj.mn цахим системд үе шаттайгаар шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26 төрлийн үйлчилгээ системд шилжсэн бол 2022 онд 40 үйлчилгээг нэмж цахимд шилжүүлснээр нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ 100% цахимжсан. Цахим үйлчилгээг нэвтрүүлснээр нийгмийн халамжийн бүх үйлчилгээг нэг дороос шуурхай чирэгдэлгүй авах нөхцөл бүрдсэн.	100%
53	2.2.2.Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг үзүүлэх	2020-2024	ХХҮГ	-	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	40000 /давхардсан тоогоор/	41000 /давхардсан тоогоор/	Батлагдсан төсвийн хүрээнд	улсын төсөв 15700.0	100%
54	2.2.3.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.	Орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, /5 төрөл/ олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг (8 төрөл) хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх	2020-2024	ХХҮГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	430 иргэн	470 иргэн	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 74.6	100%

												дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох үүднээс олон нийтийн оролцоонд түшиглэсэн бүлгийн 10 төсөл хэрэгжүүлж, 20 иргэнд 18,8 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Ахмадын өдрийн үйлчилгээг аймгийн Ахмадын хороогоор гэрээлэн гүйцэтгүүлж, 111 ахмад настанг хамруулж, 4,9 сая төгрөг зарцуулсан. "Хүмүүн бие даан амьдрах төв" ТББ-тэй хамтран сэтгэл зүйн зөвлөгөөг 33, өдрийн үйлчилгээг 47 иргэнд, сургалт 34 иргэнд үзүүлсэн. \	
2.2.4.Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.													
55	2.2.5.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	78 иргэн	85 иргэн	17.0	Улсын төсөв 22.4	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох сургалтыг Орхон МСҮТ, ХАА-н МСҮТ-тэй хамтран цахилгаанчин, гагнуурчин, үсчин, оёдол, тогооч зэрэг 5 мэргэжлээр зохион байгуулж, нийт 58 иргэн хамрагдаж чадамжийн гэрчилгээ олгов. Үүнээс тогооч, оёдолчин мэргэжлээр хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн суралцаж төгссөн. Иргэд мэргэжлийн сургалтад хамрагдаж суурь мэргэжил эзэмшснээр залуучууд хөдөлмөрийн харилцаанд орж, орлого олохоос гадна эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдсэн.	70%
56	2.2.6.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, ажил олоход хүндрэлтэй иргэдэд	2020-2024	ХХҮГ	БШУГ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн	1520 иргэн	1620 иргэн	13.7	Улсын төсөв 9.3	ЕБС-ийн ахлах ангийнханд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нь суралцагчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох. 12 дугаар анги	100%

	үйлчилгээ үзүүлнэ.	мэргэжил сонгох, ажилд ороход шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөх					хүрээнд					төгссөний дараа суралцах мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага болон их дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагаа юм. Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас эрх авсан "Эм эс девелопмент" консалтинг институт, "Урагшлах хүч" ТББ-ын дэргэдэх Хөдөлмөрийн биржтэй хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 813 сурагчид, ажил хайгч 15 иргэн, хорих ангид хүмүүжигч 30 иргэн нийт 858 иргэнд бүлгийн сургалтыг зохион байгуулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 762 иргэнд, нийт 1620 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг хүргэсэн. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулснаар хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдлэг олгож, эдийн засгийн хувьд идэвхтэй иргэн бэлтгэхэд нөлөө үзүүлж байна.	
57	2.2.7.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх, оюутны цагаар ажиллах арга хэмжээний хүрээнд сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг их, дээд сургууль, коллежийн оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдэд хүргүүлж холбогдох мэдээллээр хангах	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	81 төсөл	95 төсөл	437.0	Улсын төсөв 900,0	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг сургах, чадавхжуулах чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрт 28 арга хэмжээг хэрэгжүүлж 900.0 сая төгрөг зарцуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хамруулах ажилтай, орлоготой болгох, сургаж бэлтгэх үйл ажиллагааг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудтай уялдуулан зохион байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй иргэдийн материалыг багийн ажлын алба болон хэвлэл мэдээлэл, веб сайт, цахим хуудсаар нээлттэй зарлаж 146 иргэдийн материалыг хүлээн авч, 2 үе шаттайгаар сонгон шалгаруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 19, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 41, малжуулах арга хэмжээнд 6, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 20, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1, нийт 87 иргэний төсөлд 700,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 92 байнгын ажлын байр бий болсон.	100%

58	2.2.8.Аймгийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучилж, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажиллана.	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн сан баяжуулж, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	1000 иргэн	1000 иргэн	7.0	Улсын төсөв 6.2	Аймгийн Засаг даргын 2013 оны А/306 дугаар захирамж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан болох LMIS программд ажил хайгч иргэд, ажил олгогчдоос шинэ ажлын байрны мэдээллийг цуглуулж бүртгэх ажил тогтмол хийгдэж байна. Тайлант хугацаанд 2073 ажлын байр бий болсны 49,4 хувь буюу 1026 нь шинэ ажлын байр байна. Өмнөх оны мөн үеэс нийт бий болсон ажлын байр 0,7 хувиар, шинээр бий болсон ажлын байр 23.1 хувиар буурчээ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1376 хүн бүртгэлтэй байгаагийн 57.0 хувь нь эмэгтэйчүүд ба бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 33,1 хувиар буюу 683 хүнээр бага байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 37.7 хувь нь 25-34 насныхан, 32,3 хувь нь 35-44 насныхан, 22,0 хувь нь 45 ба түүнээс дээш насныхан, 7.8 хувь нь 15-24 насныхан байна. Орон нутагт хийгдэх бүтээн байгуулалттай холбоотой тендерийн ажилд оролцох хүсэлтэй 31 ажил олгогч байгууллагаас 448 иргэнийг түр ажлын байраар хангах, 52 албан хүсэлт ирснийг холбон зуучлах ажил зохион байгуулсан. Өмнөх оны мөн үеэс шинэ ажлын байр өссөн үзүүлэлттэй байна.	100%
59		Тогтвортой ажлын байрыг бий болгож, шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгох	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	11 аж ахуйн нэгж, байгууллага	13 аж ахуйн нэгж, байгууллага	Батлагдсан төсвийн хүрээнд		Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2021 онд гэрээ байгуулсан 5 ажил олгогчийн 12 ажлын байранд жилийн хугацаанд байгуулсан гэрээг дүгнэж урамшуулалыг олгосон. Шинээр 1 аж ахуй нэгжийн 2 ажлын байранд гэрээ байгуулж байна. Мөн хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 41 иргэнд нийт 400,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй хүүгүй, барьцаагүй зээлийг олгож, өрхийн үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжин ажиллаж байна.	50%
60	2.2.9.Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, бодлого арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон ТББ, ААНБ, иргэдийн үйл ажиллагааг уялдуулах	2020-2024	ХХҮГ	ХАБЭА-н аймгийн салбар зөвлөл	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	20.0	-	-	Орон нутгийн төсөв 30.0	Нийгмийн түншлэлийн 3 талтын оролцоотой 3 зөвлөл аймгийн Засаг даргын дэргэд ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн хийгдэх ажлын хүрээнд хүсэлт ирүүлсэн 15 байгууллагын хамтын хэлэлцээрийг хуулийн хүрээнд хянан, бүртгэсэн. Мөн хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрүүдийн хэрэгжилт, ажлын зохион байгуулалтанд хяналт тавьж хамтран ажиллаж байна. Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлөөс "Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлэе"	100%

											уриан дор сарын аян зохион байгуулж, 14 үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан. Сарын аяны хүрээнд мэдээллийг хүргэх, аюулыг мэдээлэх гар утасны аппликейшныг сурталчлах, ХАБЭА-н зөвлөлийн НАВ.Erdenet.mn web сайтыг идэвхижүүлж мэдээллийг байршуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021- 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах зэрэг ажлуудыг хийсэн. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд ХАБЭА-н чиглэлээр 8 удаагийн сургалтыг сумдын ХАБЭА-н зөвлөл болон ААНБ-ын ҮОХХСБК-ын дарга, гишүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг дунд үйлдвэр эрхлэгч нийт 250 гаруй иргэнд, Хөдөлмөрийн тухай хуулийн 3 удаагийн сургалтыг 80 гаруй байгууллагын 200 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар Хөдөлмөрийн болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд улс, аймгийн үзлэг, шалгалтыг зохион байгуулсан. Үзлэг шалгалтад өмчийн хэлбэр харгалзахгүй эрүүл мэндийн 23 байгууллага, боловсролын 15 байгууллага нийт 38 байгууллага хамрагдаж нийт дүнгээр ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилт 68.5 хувь, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт 55.2 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн. Мөн зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах цахим сэтгүүл, нэвтрүүлэг, подкаст бэлтгэх зэрэг нөлөөллийн үйл ажиллагаа, хууль тогтоомж сурталчлах гарын авлага, плакат хэвлэх, оны шилдэг байгууллага шалгаруулах зэрэг олон талт үйл ажиллагааг хийсэн. Аймгийн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт салбар хороог шинээр байгуулж, нийгмийн түншлэлийн бүсийн зөвлөгөөн зохион байгуулж 6 аймгийн 400 гаруй төлөөлөгчид оролцож, зөвлөгөөний үеэр түншлэлийн үйл ажиллагааг сурталчлах, өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан.Аюулыг илрүүлж, 189 аюулыг арилгасан байна.	
ГУРАВ.БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛ												
БОЛОВСРОЛ												
61	3.1.Бүх шатны боловсролын байгууллагын багш суралцагчдын	Ерөнхий боловсролын 1, 2-р сургуулийн өргөтгөл, 16-р сургуулийн спорт	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС ААН	Улсын болон орон нутгийн төсөв	7.350.0	-	2 барилга байгууламж	2.500.0	Тайлант хугацаанд Согоот багийн 4 дүгээр цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилга, Яргуйт багийн 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгууд ашиглалтад орсон. 2022 онд улсын төсвийн 5,6 тэрбум төгрөгийн хөрөнгө	90%

	сурч хөгжих орчныг сайжруулж, иргэдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр зохион байгуулан, сургалтын чанарыг нэмэгдүүлнэ.	заалны барилга, Рашаант багийн 250 хүүхдийн сургууль, Согоот багийн 4-р цэцэрлэгийн өргөтгөл, Яргуйт багийн 150 хүүхдийн цэцэрлэг, ХАА-н Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрыг ашиглалтад оруулах									оруулалтаар 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулсан. Говил, Рашаант багийн 250 хүүхдийн сургууль, ХАА-н Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, 16 дугаар сургуулийн спорт заалны барилгын ажлууд 70-85 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба тодорхой шалтгаанаар барилгын ажил түр зогссон байна. Наран багийн 3 дугаар сургуулийн барилгыг буулгах ажил үргэлжилж байна		
62		Сургууль, цэцэрлэгийн барилгад засвар хийх ажлыг үе шаттайгаар хийж, боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС ААН	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	6 барилга байгууламж	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 1242,9	2021 онд 4 сургууль, 5 цэцэрлэгийн засварын ажилд 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орон нутгийн төсвөөс хийгдсэн байна.2022 онд орон нутгийн төсвөөс дараах 11 байгууллагад 1,2 тэрбум төгрөгийн засвар, үйлчилгээ хийгдсэн. Үүнд: ● Уртбулаг баг. Унага цэцэрлэгийн хана, цонхны засвар 77,0 сая төгрөг; ● Наран баг. 6-р цэцэрлэгийн гадна фасадны засвар 178,8 сая төгрөг; ● Шанд баг. 17 дугаар сургуулийн их засвар 339,1 сая төгрөг; ● Согоот баг. 14-р сургуулийн дээвэр, сантехникийн засвар 31.7сая төгрөг: ● Их залуу баг. 15-р сургуулийн авто зогсоолоос 23-р цэцэрлэгийн хажуугийн авто замтай холбох 270.0 сая төгрөг; ● Баянцагаан баг. 18 дугаар сургуулийн спорт заалны засвар /шал, бетон, хаяавч/ 47.1 сая төгрөг; ● Эрдэнэ баг. 11-р цэцэрлэгийн халаалт, дээврийн дулаалгын ажил 33.0 сая төгрөг;	100%

											- Урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын "Уран эгшиг" сургуулийн барилгын дотор засвар 99.7сая төгрөг; - Жаргалант сум. 3-р цэцэрлэгийн нүүрэн талын ангийн цонх солих, дотор засвар 86.6 сая төгрөг; - Жаргалант сум. сургуулийн А блокны дээвэр засвар 74.2 сая төгрөг; - Жаргалант сум. Сургуулийн эмчийн өрөөний засвар 5.4 сая төгрөг.	
63		СӨББ, ЕБС-ийн ачаалал, ээлжийн коэффициентийг бууруулж, анги дүүргэлтийг 35-аас хэтрүүлэхгүй байх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	-	-	Ээлжийн коэффициент-1.8 Хамран сургалт-91.1%	Ээлжийн коэффициент-1.7 Хамран сургалт-92%	-	2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 20, хувийн хэвшлийн 5, нийт 25 сургуулийн 781 бүлэгт 24751 хүүхэд суралцаж байна. - Бүлэг дүүргэлт 31.6. Үүнээс төрийн өмчийн сургуулиуд 32.9 байгаагаас бага ангид 35.3 байна. - Ээлжийн коэффициент 1.3. Үүнээс төрийн өмчийн сургуулиуд 1.5 байгаа ба аймгийн дунджаас 5 сургууль (1, 4, 5, 8, 14-р сургууль) 0.7-аар өндөр байна. СӨББ-ын хамран сургалт: 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 31, төрийн бус өмчийн 8, нийт 39 цэцэрлэгт 8768 хүүхэд үндсэн сургалтад хамрагдаж байна. Хамран сургалт 92,2 хувь байгаа нь өмнөх оноос буураагүй бөгөөд улсын дунжаас 11.3 хувиар дээгүүр байна. - Согоот багийн 4-р цэцэрлэгийн өргөтгөл, Яргүйт багийн 28-р цэцэрлэг бүрэн ашиглалтад орсноор аймгийн хэмжээнд бүлэг дүүргэлт 27 болсон бөгөөд энэ нь өмнөх оноос 1.8 хувиар буурсан үзүүлэлт юм.	100%
64		"Сургуулийн автобус"-ын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	2022-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	8	Чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуульд 1, Баян-Өндөр сумын сургуулиудад 6 автобус, 7 чиглэлд 15 сургуулийн 1600 орчим хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна. 7 автобусны 3 нь Даваат, Шанд, Уртын гол, Яргүйт, Наран, Рашаант, Цагаанчулуут багийн хүүхдүүдийг харьяаллын сургуульд нь хүргэх, мөн хотын төвийн сургуульд суралцдаг хүүхдүүдийг сургуульд нь хүргэж үйлчилдэг. Тайлант хугацаанд 3 автобусны буудлын тоог 2-оор нэмэгдүүлж, сурагчид гэрийн ойроос үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн. 4 автобус нь харьяа багийн сургуулийн хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлж байна.	100%

												3-р сургуулийн хичээлийн байрыг буулгаж сурагчдыг өөр байранд шилжүүлсэнтэй холбогдуулан Наран, Шанд багаас 3-р сургуулийн дунд ахлах ангийн 68 хүүхдийг тус хичээлийн байранд хүргэж өгдөг байхаар автобусны маршрутыг батлуулсан. Ингэснээр алслагдсан багийн хүүхдүүд сургуульдаа автобусаар зорчих боломж бүрдсэн.	
65		Өмчийн бүх хэлбэрийн ЕБС, СӨББ-ын сургалтын чанарыг сайжруулж, ЭЕШ-ын чанарыг ахиулах	2020-2024	БШУГ	ЕБС СӨББ	-	-	Сургалтын чанар-80.5% ЭЕШ-507	Сургалтын чанар-83.0%, ЭЕШ-515	-		Элсэлтийн ерөнхий шалгалт - Монгол хэл, бичгийн шалгалтад 1039 сурагч хамрагдаж, гүйцэтгэлийн хувь 67,2 хувьтай шалгагдсан нь улсын дунджаас 2,6 хувиар дээгүүр үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтээр улсын хэмжээнд 5-р байранд эрэмбэлэгдсэн бөгөөд ЭЕШ-ын Монгол хэл, бичгийн шалгалтад 3 сурагч 800 оноо авсан байна. 2022 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын 10 судлагдахууны хэмжээст онооны аймгийн дундаж 550.33 үнэлэгдсэн бөгөөд энэ нь улсын дунджаас 21.13 оноогоор өндөр байна. Хэмжээст онооны дундаж өмнөх оныхтой харьцуулахад 2.78 оноогоор өссөн. 4 судлагдахууны төрлөөр 11 сурагч 800 оноог авч, аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хамрагдсан. Сургалтын чанар - Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан сургуульд суурилсан оношлох үнэлгээний шалгалтад ерөнхий боловсролын 24 сургуулийн сурагчдын 88,9 хувь нь хамрагдсан. Аймгийн сурлагын дундаж 47,7 хувь, үүнээс хүн орчин хичээл 63,5 хувьтай хамгийн өндөр, физикийн хичээл 36,3 хувьтай хамгийн бага үнэлгээтэй шалгагдсан. - Анги дэвших болон улсын шалгалтын нэгтгэлээр 79,9 хувьтай үнэлэгдлээ. Тухайлбал, 3,4-р ангийн анги дэвших шалгалтын аймгийн дундаж гүйцэтгэлийн хувь 88,4 хувь, 6,7,8,10,11-р ангийн дундаж гүйцэтгэлийн хувь 76,2 хувьтай тус тус үнэлэгдлээ. Энэ нь ковидын өмнөх буюу 2018-2019 оны хичээлийн жилийн анги дэвших шалгалтын дүнтэй харьцуулахад 1,2-1,8 хувиар доогуур байна. 5,9,12-р ангийн анги дэвших улсын шалгалтын дундаж гүйцэтгэлийн хувь 76,4-82,6 хувьтай үнэлэгдсэн. Энэ нь ковидын өмнөх буюу 2018-2019 оны хичээлийн жилийн анги дэвших шалгалтын дүнтэй харьцуулахад 1,6-1,9 хувиар доогуур байна.	100%

66		СӨББ-д бүтээмж дээшлүүлэх хөтөлбөр, ЕБС-иудад чанарын удирдлагын системийг нэвтрүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	-	-	5 цэцэрлэг, 4 сургууль	8 цэцэрлэг, 6 сургууль	-	Тайлант хугацаанд төрийн өмчийн 15 цэцэрлэг буюу нийт цэцэрлэгийн 51.7 хувь нь бүтээмж дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж, харилцан суралцах, туршлага солилцох ажлыг зохион байгуулсан. ЕБС-ийн 4,5,14,15 дугаар сургуулиуд "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төсөлд хамрагдаж, төслийн хүрээнд чанарын удирдлагын симтемийг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх чиглэлээр Удирдлагын академийн багш нараас зохион байгуулсан цуврал сургалтуудад хамрагдсан. Эдгээр сургуулиуд "Сургууль бүхлээрээ ажиллах, арга хандлагад суралцаж, хамт олны үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэн ажиллаж байна. 5-р сургууль байгууллагын төлөвлөлт менежментэд олон улсын PDCA /ТӨЛӨВЛӨ-ХИЙ-ҮНЭЛ-САЙЖРУУЛ/ загварыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба энэ арга зүйгээ аймгийн ЕБС-ийн захирлуудад танилцуулах, сурталчилах ажлыг зохион байгуулсан. Мөн 5, 7, 8, 9, 15, 19, 22, 27, 28 дугаар цэцэрлэгүүд үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах "Бүтээмжийн хөтөлбөр"-ийг доорх чиглэлээр хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах "5 S"- ийн арга 2. Ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх чанарын дугуйлан, багийн үйл ажиллагаа 3. Кайзен хандлага, саналын тогтолцоог хэрэгжүүлэх Дээрх цэцэрлэгүүд 7 хоног бүрийн баасан гаригийг "5S" хэрэгжүүлэх "Эмх цэгцийн өдөр" болгон ажиллаж хэвшсэн. Ерөнхий боловсролын 6 сургууль олон улсын PDCA менежментийн загварыг хэрэгжүүлэн ажиллаж, өөрийн байгууллагын үйл ажиллагааг ЕБС-ийн захирлуудад танилцуулах сурталчилах ажлыг зохион байгуулсан.	100%	
67		Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, МСҮТ-үүдэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах	2022-2024	БШУГ	Их, дээд сургууль МСҮТ	Орон нутгийн төсөв	60.0	-	Дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.	20.0	Орон нутгийн төсөв 65.0	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хуучнаар МУИС-ийн "Эрдэнэт" сургуультай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Гэрээний хүрээнд ЕБС-ийн гадаад хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх аргазүйн сургалт, семинар, ЕБС-ийн багш нарт эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичих, судалгааны ажил хийх аргазүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагын нягтлан бодогчдод мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтыг зохион	100%

											байгуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Мөн гэрээний хүрээнд 1. Аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өнөөгийн байдлыг салбар бүрээр тодорхойлох судалгаа 2. Аймгийн өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт ба түүнд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ, дүгнэлт, санал, зөвлөмж 3. Аймгийн Хөдөө аж ахуйн салбарын хөгжил, түүнд нөлөөлөгч болон хязгаарлагч хүчин зүйлийн шинжилгээ, дүгнэлт, санал, зөвлөмж 4. Ковид-19-ын Орхон аймаг дахь нөлөөллийн судалгаа, дүгнэлт, санал, зөвлөмжийг хийж гүйцэтгэсэн байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт" цогцолбор дээд сургуультай хамтран ЕБС, СӨББ-уудад "Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо-MNS ISO 21001-2021" стандарт нэвтрүүлэх, танилцуулах 3 модуль зохион байгуулж 325 багш, ажилтныг хамруулсан байна. Үүний үр дүнд аймгийн боловсролын байгууллагуудад дээрх стандартыг нэвтрүүлэх, дараагийн шатны үнэлгээнд хамрагдаж баталгаажуулалтын гэрчилгээ авах нөхцлийг бүрдүүлсэн байна.		
68		Багшийн мэргэжил дээшлүүлэх Институтын "Хамтдаа хөгжье" хөтөлбөрт 3 цэцэрлэг, ерөнхий боловсролын 3 сургуулийг хамруулах	2021-2024	БШУГ БМДИ	СӨББ ЕБС	Орон нутгийн болон байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	9.0	-	1 сургууль, 1 цэцэрлэг	2.0	орон нутгийн төсөв 4.0	"Хамтдаа хөгжье" хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн 2-4, 6-9 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулсан "Эрдэнэтийн чадварлаг багш" орон нутгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж өмчийн бүх хэлбэрийн сургууль, цэцэрлэгийг хамруулах боломжийг бүрдүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 8 төрлийн сургалтыг зохион байгуулж, 1-4, 6-9 дэх жилдээ ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн 24 сургууль, 40 цэцэрлэгийн 486 багшийг хамруулж, мэргэжил арга зүйг дээшлүүлсэн.	100%
69	3.1.1.Суралцагчдыг бие даан бүтээлчээр суралцах боломж олгох, дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшихэд бэлтгэх зорилготой уян хатан сургалтын	ЕБС-иудын ахлах ангийн суралцагчдад инженерийн боловсрол, ажил мэргэжлийн баримжаа олгох сургалтыг орон нутгийн их, дээд сургуулиудыг түшиглэн зохион байгуулах	2021-2024	БШУГ	Их, дээд сургуулиуд	Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Сургалт үйл ажиллагааг зохион байгуулна.	2.0		Тайлант хугацаанд 6-9-р ангийн сурагчдад өөрийгөө таньж мэдэх, ирээдүйн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, 10-12-р ангийн сурагчдын мэргэжил сонголт, их дээд сургуульд элсэх бэлтгэлийг хангах зорилгоор "Мэргэжил сонгох хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчид, оюутан залуучуудад "ТЭТГЭЛЭГ ЗАЛУУС БИДНИЙ АМЬДРАЛД" ЦАХИМ АЯН-2021" үйл ажиллагааг зохион байгуулж 10-12-р ангийн сурагчид болон их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудыг	100%

	хөтөлбөрийг сурагчдад сонголт хийх боломжтойгоор хэрэгжүүлнэ.										хамруулан мэргэжлээ хэрхэн сонгох талаар, гадаадын 7 улсын Засгийн газрын тэтгэлэг, түүнд хамрагдах боломжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2022 оны II улиралд БШУГ, "Эрдэнэт" цогцолбор дээд сургууль хамтран сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг "Инженерийн чиглэлийн мэргэжил сурталчлах хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулсан. Уг үйл ажиллагааны хүрээнд: - 9-р ангийн 1089 сурагчийг тус сургуулийн лаборатори, инженерийн ажлын байруудтай танилцуулж, инженерийн чиглэлээр суралцах боломж, ирээдүйн мэргэжлээ хэрхэн сонгох талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн. - 12-р ангийн инженер болох хүсэлтэй 343 сурагчийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үйл ажиллагаатай танилцуулж, инженерийн ажлын байрны давуу тал, тавигдах шаардлагын талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.		
70		ЕБС-иудын ахлах ангиудад байгалийн ухаан, математик, гадаад хэл, техник технологи, спорт, эрүүл мэнд, ёс зүй, урлагийн боловсрол олгох сургалтыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2.0	Орон нутгийн төсөв 700,0	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын захирамжаар "Уран эгшиг" урлагийн төрөлжсөн сургалттай сургуулийг байгуулж, орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хичээлийн байрны асуудлыг шийдвэрлэж, шаардлагатай техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангасан. Тус сургуульд ятга, шанз, ёочин, хуучир, морин хуур, лимбэ, төгөлдөр хуур, уран нугаралт, уран зураг, дизайн, драм зэрэг урлагийн 13 хөтөлбөрөөр 1-12-р ангийн 350 сурагч хичээллэж байна. Мөн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр "Эрүүл хүүхэд", спорт, техник технологи, урлагийн боловсрол олгох чиглэлээр "Хүүхдийн хөгжил", хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр "Тэгш боломж" төслүүдийг боловсруулан батлуулж, уг төслүүдийн хүрээнд хичээл заах, дугуйлан секц, клуб хичээллүүлэх багш нарыг Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаа, сургалтуудад үе шаттайгаар хамруулсан. "Тэгш боломж" төслийн хүрээнд 1,7,20 дугаар сургуулиудад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв", "Эрүүл хүүхэд" төслийн хүрээнд 4 дүгээр сургуульд "Эрүүл мэндийг дэмжих төв" байгуулагдаж, "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд ерөнхий	100%

												боловсролын 7 сургуульд хөгжим, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнүүд нийлүүлсэн байна.	
71		Залуучуудын ордныг түшиглэн “Залуу зохион бүтээгчдийн төв” байгуулах	2022-2024	ГБХЗ ХГ БШУГ	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ “Эрдэ нэт цогцолбор” сургууль “ШУТ П”	Орон нутгийн болон байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Төвийг байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд		Аймгийн ГБХЗХГ-ын В1 давхрын 211м2 талбайд “Ирээдүйг бүтээгч” зохион бүтээх техник, технологийн танхим байгуулах 44.0 сая төгрөгийн төслийг боловсруулж НҮБ-ын Хүүхдийн санд танилцуулсан. Мөн аймгийн БТСГ, БШУГ, ГБХЗХГ-ууд хамтран техник, спортын хөтөлбөр боловсруулсан. Хөтөлбөрт тусгагдсаны дагуу леги робот, шүүхрийн сургалтуудыг хүүхэд, залуучуудын дунд зохион байгуулна.	30%
72	3.1.2.Бүх шатны боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлнэ.	ЕБС, СӨББ-ыг “Тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага” болоход дэмжлэг үзүүлж “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх	2020-2024	БШУГ	БШУЯ БОАЖ Я	Орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр	48.0	-	4 сургууль, 4 цэцэрлэг	16.0	Орон нутгийн төсөв 28.0	БОАЖЯ, БШУЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Байгаль орчин сургалт мэдээллийн төвтэй хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөл аймгийн хэмжээнд 4 сургуульд үргэлжлэн хэрэгжиж байна. Үүнд : • 4-р сургууль “Ардын ёс заншил” төсөл; • 5-р сургууль “Дотоод агаарын чанар” төсөл; • 14-р сургууль “Цахилгааны хэмнэлт” төсөл; • 15-р сургууль “Байгалийн ухаан” төсөл. Дээрх 4 сургуулиас олон улсын “Эко сургууль”-ийн алтан гэрэг, ногоон тугийн болзлыг 14, 15-р сургуулиуд, хүрэл гэрэгний болзлыг 4, 5-р сургуулиуд тус тус хангасан. Тус 4 сургуульд төслийн үргэлжлэх хугацааг 1 жилээр сунгаж, 3 дэд төслийг хэрэгжүүлэх шийдвэрлэсэн. Уг 3 дэд төслийг хэрэгжүүлснээр сургууль тус бүрд 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, суралцагчдад экологийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтвортой үргэлжилнэ. Тайлант хугацаанд олон улсын “Эко сургууль, цэцэрлэг” хөтөлбөрт 4, 15, 26-р цэцэрлэг, Орхон МСҮТ хамрагдан эхний шатны сургалтуудыг зохион байгуулсан.	70%
73		Ерөнхий боловсролын сургуулиудад “Цахим сургууль” программыг нэвтрүүлж, сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох	2020-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	-	-	3 сургууль	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 12.6	Тайлант хугацаанд цахим систем нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлууд хийгдлээ. Үүнд: 2020-2021 оны хичээлийн жилд 1, 7, лаборатори 8-р сургуулиуд “Moodle систем”, 5, 13-р сургуулиуд “Их нүүдэл” системийг нэвтрүүлэн цахим сургалтын технологийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд багш нар цахим хичээл бэлтгэн байршуулж, сурагчийн хичээлийн оролцоо нэмэгдэж, хичээл сургалтын	100%

		цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулах									үйл ажиллагаан дахь эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоо сайжирсан. Боловсролын үйлчилгээг цахимжуулах, оновчтой төлөвлөлт, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Боловсролын мэдээллийн технологийн төв"-ийн esis.edu.mn үндсэн системд төрийн болон төрийн бус өмчийн 25 сургууль, 39 цэцэрлэгийг статистик мэдээллийн баазад нэгтгэж, сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж байна.		
74		ЕБС, СӨББ-ыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлоор хангаж сургалтын орчныг сайжруулах	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	4 сургууль, 4 цэцэрлэг	Батлагдсан төсвийн хүрээнд	улсын төсөв 1700,0 орон нутгийн төсөв 1270,3	Тайлант хугацаанд улсын төсвөөс сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хэрэгцээнд 425 зөөврийн компьютер, 1135 таблет нийлүүлэхэд нийт 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж багш нарт хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвөөс: • Сургууль, цэцэрлэгийн дотор камержуулалтад 396,5 сая төгрөг; • "Цахим Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд ЕБС, МСҮТ-үүдэд ухаалаг дэлгэц худалдан авахад 280,0 сая төгрөг; • "Тэгш боломж" төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн автобус худалдан авахад 130,0 сая төгрөг; • - "Тэгш боломж" төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад 140,0 сая төгрөг; • "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд сургуулийн биеийн тамир, технологи, урлагийн боловсрол олгох кабинет байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад 210,0 сая төгрөг; • "Эрдэнэтийн эрүүл хүүхэд" төслийн хүрээнд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төв байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад 40,0 сая төгрөг; • Орхон МСҮТ-ийн тогооч бэлтгэх сургалтын тоног төхөөрөмж худалдан авахад 73,8 сая төгрөг тус тус батлагдаж нийлүүлэлт хийгдсэн байна.	100%
75	3.1.3.Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх.	Хүүхдийн "Хөдөлмөр зуслан" байгуулах ажлыг	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв,	Батлагдсан төсвийн	-	Санаачилгыг дэмжинэ.	Батлагдсан		Эрдэнэ багт байрлах "Ёс заншлын өргөө"-ний дэргэдэх Хөдөлмөр зусланд 50 хүүхэд амарч амьдрах ухаан, Монгол ахуйн чиглэлээр тус	70%

	хүмүүжил төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах агуулга бүхий орон нутгийн онцлогт тохирсон төслийг төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	санаачлан хэрэгжүүлж буй төрийн болон ТББ, ААН, иргэнийг дэмжиж хамтарч ажиллах				төсөл хөтөлбөр	йн хүрээнд			төсвийн хүрээнд		зуслангаас зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх "Энэрэл" хөдөлмөр зусланд тус төвийн 53 хүүхэд амарч хүүхдүүдийг жимс, хүнсний ногоо тарих аргад сургах ажлыг зохион байгуулсан байна. Булган аймгийн Бугат сумын нутагт баригдаж буй "Эрдмийн Сан" сургуулийн дэргэдэх хөдөлмөр зуслангийн бүтээн байгуулалтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 2023 оны II улиралд багтаан зуслангийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байгаа ба ингэснээр сурагчид анги хамт олноороо амарч амьдрах арга ухаан, хөдөлмөр, ёс заншил, өв уламжлалаасаа суралцах боломж бүрдэнэ.	
76		"Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	20.0	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	5.0	Орон нутгийн төсөв 33.0	Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 84,6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 31 үйл ажиллагаатайгаар батлуулж, "Монгол хэлний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагын үүрэг оролцоо" уулзалт, зөвлөгөөн, төрийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад зориулсан "Албан хэргийг хос бичгээр үйлдэх стандарт, монгол бичгээр эх бэлтгэх арга зүй" сургалт, "Үндэсний бичиг үсгийн өдөр"-ийн арга хэмжээ, аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтарсан захиалгат сургалтууд, 6-12 дугаар ангийн сурагчдын анги нийтийн чанарын уралдаан зэрэг ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.	100%
77		Олон улс, улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцох багш, сурагчдад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Дэмжлэг үзүүлж, урамшуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд		Тайлант хугацаанд "Ковид-19" цар тахлын улмаас улс, олон улсын олимпиадын сорилгууд цахим хэлбэрээр явагдаж, математикийн хичээлээр 2, физикийн хичээлээр 1, химийн хичээлээр 1 сурагч шалгарч олон улсын олимпиадын нэгдсэн бэлтгэлд хамрагдсан. Улсын математикийн олимпиадаас 2 сурагч мөнгө, хүрэл медаль хүртсэн. 2022 онд улсын төрөлжсөн олимпиадын II даваанд сурагчийн төрөлд 9 судлагдахууны 20 төрлөөр 509 сурагч, багшийн төрөлд 9 судлагдахууны 9 төрлөөр 278 багш оролцлоо. Багийн дүнгээр 14, Эрдмийн	100%

											сан, 4 дүгээр сургуулиуд эхний байранд шалгарсан.Олимпиадын II даваанд эхний 3 байрт шалгарсан 61 сурагч, 27 багшийг орон нутгийн төсвөөс 4,2 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Олимпиадын III даваанд 9 судлагдахуунаар 24 сурагч, 10 багш оролцсноос 1 алт, 7 хүрэл, нийт 8 медаль хүртсэн байна. Олон улс, улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон багш, сурагчдыг аймгийн Засаг даргын 2015 онд баталсан журмын дагуу 2023 оны I улиралд урамшуулна.		
78		Үндэсний ёс заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах агуулга бүхий цахим контентыг хийх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Цахим контент хийнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Олон улсын эко сургууль төсөлд хамрагдаж буй 4, 5, 14, 15 дугаар сургуулиуд өөрийн онцлогтой ардын зан заншил, байгаль экологийн боловсрол олгох, амьдрах арга ухаанд сургах хөтөлбөртэй болж, аймаг, улсын хэмжээнд туршлагаа түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна. Дээрх 4 сургуульд хэрэгжүүлж буй "Ардын ёс заншил", "Дотоод агаарын чанар", "Цахилгааны хэмнэлт", "Байгалийн ухаан" төслийн хүрээнд БОАЖЯ, БШУЯ, Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв, Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран цахим контент хийж олон нийтийн хүртээл болгосон бөгөөд БОАЖЯ-ны төлөөллийг оролцуулан аймгийн хэмжээнд үзүүлэх ажил зохион байгуулсан.	100%	
79		Боловсролын чиглэлээр улс, бүсийн чанартай 1-ээс доошгүй арга хэмжээг жил бүр орон нутагтаа зохион байгуулах (Олимпиад, уралдаан, тэмцээн, хурал, зөвлөгөөн)	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	1 арга хэмжээ зохион байгуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 39.5	Нийгмийн ухааны хичээлийн улсын XXIV олимпиадыг орон нутагтаа зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн 30 багш, 30 сурагч оролцлоо. Олимпиадыг Боловсрол, шинжлэх ухааны яам, аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Монгол улсын Боловсролын их сургууль, 14-р сургууль хамтран зохион байгуулсан бөгөөд 14-р сургуулийн багш 3-р байранд шалгарсан. Олимпиадын зардалд орон нутгийн төсвөөс 39,5 сая төгрөг зарцуулсан.	100%
80		ЕБС-иудад Хүүхдийн хөгжил, төлөвшлийн ажилтнуудыг үргэлжлүүлэн ажиллуулж, сэтгэл зүйч мэргэжилтэй боловсон хүчнээр хангах	2020-2024	БШУГ	ЕБС	-	-	17	Сэтгэл зүйч ажиллуулах 2 сургуульд	-		Аймгийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 17 хүүхдийн хөгжил төлөвшлийн ажилтан ажиллаж байна. Мөн төрийн өмчийн 15, хувийн хэвшлийн 2, нийт 17 сургуульд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж байгаа бөгөөд 7 сэтгэл зүйч нь БШУЯ-ны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж "Боловсролын сэтгэл зүйч" мэргэжил эзэмшсэн байна. Сургуулийн сэтгэл зүйчид 2022-2023 оны хичээлийн жилд сэтгэл зүйн гарааны үнэлгээг 2601	100%

											сурагч,170 эцэг эх, асран хамгаалагч, 306 багш, 21 удирдах ажилтанд, сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 1421 сурагч, сэтгэл зүйн бүлгийн сургалтыг 17000 гаруй сурагч, 1334 багш, 68 удирдах ажилтанд явуулж сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн ЕБС-ийн сэтгэл зүйчид "Сонсьё, Хайрлая, Мэдэрье" сэтгэл зүйн өдөрлөгийг цувралаар зохион байгуулж, иргэд олон нийтэд сэтгэл зүйн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан.	
81		Хүүхдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим хэрэглээний зохист байдлыг бий болгох сургалтуудыг ЕБС-ийн хэмжээнд тогтмол зохион байгуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв,байгууллагын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	ЕБС-уидад жилд 2 удаа	Батлагдсан төсвийн хүрээнд	Тайлант хугацаанд БШУГ, ГБХЗХГ хамтран "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийг эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд сурталчилж, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, постер, шторк бэлтгэн цахимаар олон нийтэд хүргэсэн. Мөн ЕБС-ийн сэтгэл зүйчид хамтран хүүхдийг цахим гэмт хэргийн золиос болох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг хийж, хөл хорионы үеийн нийгэм, сэтгэл зүйн айдсыг даван туулах зөвлөмж бүхий 15 хичээлийг цахим орчинд байршуулж 1669 хүнд хүргэсэн байна. 2022 онд уг ажлын хүрээнд 2 сургалт, 2 нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Үүнд: • 01-р сард "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээний хүрээнд ГБХЗХГ, ЦГ-тай хамтран "Цахим орчны зохистой хэрэглээ-донтолт" уулзалтыг зохион байгуулж, дунд болон ахлах ангийн 130 сурагч хамрагдсан. • 02-р сард ЕБС-иуд АУБ, эцэг эх, асран хамгаалагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр танхимын сургалтыг хийж, 15674 багш, эцэг эх хамрагдсан. • Цахим орчны зөв хэрэглээ, дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ЕБС-иудын хүүхэд хамгааллын баг нийт 57 зурагт хуудсыг цахим орчинд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна. Боловсрол, шинжлэх ухааны газраас 2022 оны 09,10 дугаар сарыг "Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг бууруулах сар" болгон зарлаж сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.	100%

82	3.1.4.Бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх, урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.	“Багш” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих	2021-2024	БШУГ	СӨББ, ЕБС, Их, дэд сургууль, МСҮТ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 50%-д хүргэнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 68.1	Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Ээлжит бус II хуралдааны 06 дугаар тогтоолоор "Багш" хөтөлбөрийг хүрээнд 3 зорилт 17 арга хэмжээ, 20 үйл ажиллагаатай баталж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, анги удирдсан багшийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, багш, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг олон шинэлэг арга хэмжээг тусган хэрэгжүүлж хөтөлбөрийн 2021 хэрэгжилт 88.2 хувьтай үнэлэгдсэн. 2022 онд "Багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагаатайгаар төлөвлөн батлуулж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх, анги удирдсан багш нарыг чадавхижуулах, багшийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.	90%
83		Орон нутгийн онцлогт тохируулан сургууль, цэцэрлэг, багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх аргачлал боловсруулан хэрэгжүүлж, сургалтын чанар ажлын үр дүнгээр шалгарсан багш нарыг урамшуулах	2021-2024	БШУГ	СӨББ, ЕБС	Орон нутгийн төсөв	40.0	20 багш	20 багш ажилтан	10.0	Орон нутгийн төсөв 12,6	Багшийн ажлын үр дүнг үнэлж, дүгнэх аргачлалыг боловсруулан хэрэгжүүлж байна. Уг аргачлалын дагуу сургалтын чанарыг дээшлүүлсэн 35 багш, эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд тэргүүлсэн 12 удирдах ажилтан, амжилт гаргаж ажилласан 56 багш, 9 байгууллагыг шагнаж урамшуулсан. Мөн 2021 оны ЭЕШ-д сурагчид нь 800 оноо авсан 9 багшийг тус бүр 500.0 төгрөгөөр шагнаж, "Батламж" гардуулсан. 2022 онд ажлын үр дүнгээр шалгарсан болон ЭЕШ, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн 30 багш, удирдах ажилтан, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжин ажилласан төрийн болон төрийн бус 6 байгууллагыг шагнаж урамшуулахад орон нутгийн төсвөөс 12.6 сая төгрөг зарцуулсан байна.	100%
84	3.1.5.Бүх шатны боловсролын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг	“Багш” хөтөлбөрийн хүрээнд бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтны нийгмийн асуудлыг	2021-2024	БШУГ	СӨББ, ЕБС	Орон нутгийн төсөв	-	60 багш, ажилтан	Жилд 60 багш, ажилтан	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвөөр	Орон нутгийн төсөв - 11.0	2021 онд "Багш" хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын 39 багш, ажилтанд 5 чиглэлээр 300,0-500,0 мянган төгрөгийн буюу нийт 16.7 сая төгрөгийн дэмжлэг олгосон. 2022 онд журмын дагуу 19 багш, ажилтанд 11.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.	100%

	шийдвэрлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх											
85		Шаардлагатай цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллуулна	Батлагдсан төсвийн хүрээнд		2022 оны 3-р сарын 1-ний өдрөөс ачаалал ихтэй 10 цэцэрлэгийн 84 бүлэгт ээлжийн 42 багш ажиллаж эхэлсэн. Ээлжийн багш ажиллаж буй 10 цэцэрлэг өглөө 07:00 цагаас орой 19:00 цаг хүртэл 12 цагаар үйл ажиллагаагаа явуулж байгаа нь эцэг, эхчүүд ажил, хөдөлмөрөө тайван эрхлэх боломжийг бүрдүүлж, 40 гаруй ажлын байр шинээр бий болсон.	100%
86	3.1.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн жирийн ангид шилжин суралцах боломжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн үзүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.	Багш, ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	4.0	-	2 багш	1.0	Орон нутгийн төсөв 220.0	Тайлант хугацаанд 7 дугаар сургуулийн дэргэд хичээллэдэг тусгай хэрэгцээт боловсролын 4 ангийн 47 хүүхдэд хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй 4 багшийг 9 удаагийн мэргэшүүлэх цахим сургалтад хамруулсан. Мөн Багшийн мэргэжил дээшлүүлэх Институттэй хамтран зохион байгуулсан "Хамтдаа хөгжье" хөтөлбөрийн хүрээнд СӨББ, ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан "Дэмжлэгийн баг"-ийн чадавхжуулах сургалтад 50 багш, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх Институтээс зохион байгуулсан сургалтад бага ангийн 314 багш, БШУЯ, "Койка" олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг чадваржуулах 3 удаагийн сургалтад 15 сургуулийн 15 багш тус тус хамрагдсан. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамруулах, шаардлагатай хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Боловсролын хүрээлэн, Боловсролын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан сургалтад 400 гаруй багшийг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн "Дэмжлэгийн баг"-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг аймгийн ЗДТГ, ХХҮГ-тай хамтран зохион байгуулж 5 сургууль, 2 цэцэрлэгийн 35 багш, ажилтан хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах "Тэгш боломж" төслийн хүрээнд 4 удаагийн сургалтад СӨБ, ЕБС-ийн 162 багш, төслийн хүрээнд Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаанд ЕБС-ийн сургалтын менежер, СӨБ-ын арга зүйчдийг хамруулсан байна. Мөн уг төслийн хүрээнд 1, 7, 20 дугаар сургуулиудад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих танхим"-	100%

												ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан. Тайлант хугацаанд 240 багш, ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн.	
87		Жаргалант сумын сургууль, 7-р сургууль, 27-р цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөөх дунд оврын автобустай болгох	2022-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	1 автобус	1 автобус	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 130.0	"Тэгш боломж" төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчлэх бага оврын автобус авахад зориулан 130.0 сая төгрөгийг төсөвлөж, тендер сонгон шалгаруулалт 2 удаа зарлагдсан боловч хил гааль, үнийн өсөлтийн улмаас шийдвэрлэгдээгүй байна.	50%
88	3.1.7.Бүх нийтийн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар менежментийг дээшлүүлж, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэн "Насан туршийн боловсрол төв"-ийг хүн амын насан туршийн боловсролыг дэмжигч, мэдээлэл түгээгч байх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	Иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бизнес амьдрах ухаан, ёс суртахуун төлөвшил, гоо зүй, гэр бүлийн, байгаль орчны, иргэний боловсрол олгох гэсэн чиглэлээр сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, ардын уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр шавь сургалтыг иргэдийн дунд зохион байгуулах	2021-2024	БШУГ	НТБТ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	15.0	-	Хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5.0		Тайлант хугацаанд аймгийн Насан туршийн боловсролын төвөөс иргэний боловсролын чиглэлээр 7, гэр бүлийн боловсролын чиглэлээр 3, амьдрах ухааны чиглэлээр 2, ёс суртахуун, төлөвшлийн чиглэлээр 3, нийт 15 сургалтын хөтөлбөр шинээр боловсруулсан. Боловсруулсан хөтөлбөрийн хүрээнд үндсэн 6 чиглэлээр зайн сургалтыг зохион байгуулж 70 гаруй аж ахуй нэгж, байгууллагын 2000 орчим иргэнийг хамруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох оёдол эсгүүрийн 120 цагийн шавь сургалтад 16 иргэнийг амжилттай сургаж өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдүүлсэн байна. 2022 онд Насан туршийн боловсрол төв 5 агуулгын хүрээнд 82 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, 70 гаруй аж ахуй нэгж, байгууллагын 4249 хүнд сургалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлж, 11757 орчим иргэнийг нөлөөллийн ажилд хамруулсан байна. Мөн "Үндэсний хувцас оёж, эсгэх" оёдол эсгүүрийн 120 цагийн сургалт 3 удаа явагдсан. Уг сургалт нь онол 20 хувь, дадлага 80 хувь бүхий шавь сургалт бөгөөд 31 иргэн хамрагдсан. Сургалт бүрийн төгсгөлд бүтээлийн үзэсгэлэн гаргаж суралцагчдад гэрчилгээ гардуулсан бөгөөд сургалтад хамрагдсан иргэд цаашид өрхийн үйлдвэрлэл эрхэлж орлогоо нэмэгдүүлэх чадварыг эзэмшсэн. Мөн оёдол эсгүүрийн сургалтад хамрагдсан иргэдтэй хамтран "Уран үйл" клубыг байгуулан эргэх холбоотой ажиллаж байна.	100%
89		Насан туршийн боловсролын төвд бүх насны иргэд	2021-2024	БШУГ	НТБТ	Орон нутгийн төсөв,	18.0	-	Шаардлагатай тоног	6.0	улсын төсөв 18.5	Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яам, Насан туршийн боловсролын үндэсний төв, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Ажил	100%

		ашиглах боломжтой цахим сургалтын кабинетыг бий болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах				төсөл хөтөлбөр			төхөөрөмжөөр хангана.			мэргэжлийн чиг баримжаа олгох" төслийн хүрээнд 18,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цахим сургалтын кабинетын хэрэглэгдэхүүнийг аймгийн Насан туршийн боловсролын төвд нийлүүлсэн.	
СОЁЛ УРЛАГ													
90	3.2.Эрдэнэтийн өв соёлыг хадгалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, соёл урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг дэмжиж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.	Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Жилд 2-3 уран бүтээлч	1.5	Орон нутгийн төсөв 11.6	Тайлант хугацаанд: - Соёлын яам болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран зохион байгуулсан соёлын байгууллагуудын удирдах ажилтан, дотоод хяналтын ажилтнуудын сургалт, "Бүтээлч үйлдвэрлэл-2021" цахим сургалт, семинар, "Музейн ирээдүй: Сэргээе, Шинээр төсөөлье" сэдэвт цахим сургалт, хэлэлцүүлэг, "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2021" эрдэм шинжилгээ, онол практикийн хурал зэрэг улсын хэмжээнд зохион байгуулагдсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор соёл, урлагийн салбарын нийт 200 орчим удирдах ажилтан, уран бүтээлчид хамрагдсан байна. Мөн Соёлын яамнаас аймгийн соёлын салбарын албан хаагчдад чиглэл тус бүрээр мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах цахим сертификатын сургалтыг явуулж, 90 гаруй албан хаагч хамрагдсан байна. 2022 онд Музейн ажилтнуудын Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх сургалт, Номын төв, сургуулийн номын санчдад зориулсан "Орчин цагийн номын сангийн хөгжлийн чиг хандлага" сургалт, бүжгийн багш бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж 9,3 сая төгрөг зарцуулсан байна. Мөн "Соёлыг түгээе" аяны хүрээнд СУИС-тай хамтран аймгийн соёл, урлагийн байгууллагын ажилтнууд, уран бүтээлчид, соёлын төв, ЕБС, СӨББ-ын байгууллагын багш нарыг чадавхижуулах 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 100 гаруй ажилтан, албан хаагчийг хамруулсан.	100%
91		Аймгийн номын төвийн өргөтгөл, Номын өргөө бүхий цогцолбор барилга, Даваат, Наран	2020-2024	БШУГ	СУБ	Улсын болон орон нутгийн төсөв	-	-	1 барилгын өргөтгөлийг ашиглалтад авч, 1 барилгын	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 4300.0	Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даваат багийн соёлын төвийн барилгыг 2021 оны 01 сард ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 4,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй "Номын өргөө бүхий	70%

		багуудын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулах, соёл, урлагийн байгууллагын барилгыг өргөтгөх, шинээр барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах							ажил үргэлжилнэ.			цогцолбор"- ын барилгын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2023 оны II улиралд ашиглалтад хүлээн авахаар төлөвлөж байна. -Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Наран багийн соёлын төвийн барилгын ажил 82%-ийн гүйцэтгэлтэй, нэмэлт санхүүжилт батлагдаагүй тул барилгын ажил зогссон байна.	
92		Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хувцас хэрэглэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	БШУГ	СУБ	Улсын болон орон нутгийн төсөв	165.0	-	Тоног төхөөрөмжөөр хангана.	50.0	Орон нутгийн төсөв 40,9	2021 онд соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангахад зориулж, орон нутгийн төсвөөс 32.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд: • Хүүхэд залуучуудын театрт шаардлагатай тоног төхөөрөмж авах (17.0 сая) • Аймгийн музейн шаардлагатай тоног төхөөрөмж авах (15.0 сая) Мөн соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулахад зориулж аймгийн Музейн засвар (7.5 сая), номын төвийн засвар (49.9 сая), номын төвийн дээврийн засварын (21.7 сая) ажлууд тус тус хийгдсэн байна. 2022 онд соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангахад 40.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд: -Соёл, урлагийн газарт 18.3 сая, Аялгуу соёлын төвд 17.8 сая, Номын төвд 6.8 сая төгрөгний тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Хүүхэд, залуучуудын театрт 1.6 сая төгрөгний зөөврийн компьютер тус тус олгосон.	100%
93		Хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	2020-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	80.0	-	Дэмжлэг үзүүлнэ.	20.0	Орон нутгийн төсөв 20.8	Тайлант хугацаанд аймгийн Телевизүүдийн холбоотой хамтран сар шинийн баярын нэвтрүүлэг,"Colorfilm" студитэй хамтран эх үрсийн баярын нэвтрүүлэг, цахим тоглолтыг бэлтгэн иргэдийн хүртээл болгосон. Мөн "Номин" телевизтэй хамтран шилдэг 15 өвлөн уламжлагчийн "Эрдэнэтийн өв соёл" видео контентыг хийж иргэдийн хүртээл болгосон байна. "Соёлыг түгээе" аяны хүрээнд "Номын ертөнц" ТББ, "Аз хур" номын дэлгүүртэй хамтарсан Номын баяр, хямдралтай, гарын үсэгтэй номын худалдаа, зохиолчдын салбар зөвлөлтэй хамтран "Woman 45", "Түүхэнд мөнхөрсөн он жилүүд", "Тод-Анир-3"	100%

											номын нээлтүүд, хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад зориулсан "Үйлчилгээний соёл ба хотын соёл" богино хэмжээний цуврал сургалтууд, гэрэл зураг сонирхогчдын "Мэлмий" бүлгэмтэй хамтран "Эрдэнэтийн инээмсэглэл" гэрэл зургийн үзэсгэлэн, "Хотын соёл" зохиомжит гэрэр зургийн уралдаан зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. 2022 онд "Эрдэнэт" ДБЧ-ын дуучин Д.Нямсүрэнгийн "Хайрламаар сайхан" бие даасан тоглолтод 4.8 сая, "Таван эгшиг" төгөлдөр хуурын сургалтын төвийн багш сурагчдын "Piano lovers" улсын уралдаанд оролцох замын зардалд 1.5 сая, "Тод анир" зохиолчдын салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Дэлхийн яруу найргийн өдөр", Монголын зохиолчдын чуулга уулзалт, Сэлэнгэ, Дархан, Булган, Орхон аймгийн зохиолчдын уулзалтын арга хэмжээнд 3,5 сая төгрөг, "Эрдэнэт" ДБЧ-ын дуучин Х.Мөнхбаярын "Хүндэтгэл" бие даасан тоглолтод 5.0 сая төгрөг, дуучин Б.Нямдэлгэрийн "Үүрд хамтдаа" бие даасан тоглолтод 5.0 сая төгрөг, 14 дүгээр сургуулийн сурагч Э.Энхсэлэнгийн "Баярлалаа" тоглолтод 1.0 сая төгрөг нийт 20.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.		
94	3.2.1.Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, гадаад харилцааг өргөжүүлж, соёл, урлагийн үйлчилгээг аялал жуулчлалтай холбон сурталчлах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудыг гадаад улс орнуудад туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах	2022-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	75.0	-	10 уран бүтээлч	25.0	Орон нутгийн төсөв 4,1	2022 онд Япон улсын Нигата хотод зохион байгуулагдсан Тайшо-Кото хөгжмийн уралдаанд сурагчдын хамт оролцсон 1 дүгээр сургуулийн дуу хөгжмийн багш Г.Дашзэвэгт 2.1 сая төгрөг, Болгар улсын Пловдив хотод зохион байгуулагдсан олон улсын дуурийн дуу дуулаачдын уралдаанд оролцсон дуучин Д.Дагвадоржид 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.	70%
95		Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага болон бусад уран бүтээлчдийг шинэ уран бүтээл гаргахад нь дэмжлэг үзүүлэх	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	110.0	-	Дэмжлэг үзүүлнэ.	30.0	Орон нутгийн төсөв 20.8	2021 онд Согоот багийн иргэн Б.Мажинбуугийн санаачилсан "Марканд мөнхөрсөн Монгол минь" зөөврийн музей байгуулах төсөл, Эрдэнэ багийн иргэн, уртын дууч Д.Пүрэвдрагчаагийн "Жороо баахан улаан" дууг дүрсжүүлэх, "Бачата" бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох Орхон аймгийн "Өсөх ирээдүй" бүжгийн спортын клубын бүжигчдийн замын зардалд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. 2022 онд "Эрдэнэт" ДБЧ-ын дуучин Д.Нямсүрэнгийн "Хайрламаар сайхан" бие даасан тоглолт, "Таван эгшиг" төгөлдөр хуурын сургалтын төвийн багш сурагчдын "Piano lovers" улсын уралдаанд оролцоход, "Тод анир" зохиолчдын	100%

											салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Дэлхийн яруу найргийн өдөр", Монголын зохиолчдын чуулга уулзалт, Сэлэнгэ, Дархан, Булган, Орхон аймгийн зохиолчдын уулзалтын арга хэмжээнд, "Эрдэнэт" ДБЧ-ын дуучин Х.Мөнхбаярын "Хүндэтгэл" бие даасан тоглолтод, дуучин Б.Нямдэлгэрийн "Үүрд хамтдаа" бие даасан тоглолтод, 14 дүгээр сургуулийн сурагч Э.Энхсэлэнгийн "Баярлалаа" тоглолтод орон нутгийн төсвөөс нийт 20.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.		
96		Орон нутагт гадаад дотоодын аялал жуулчлалыг татах зорилгоор улс, бүсийн чанартай соёл, урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	80.0	-	2 арга хэмжээ зохион байгуулна.	20.0	Орон нутгийн төсөв 166.1	Аймгийн Соёл, урлагийн газар, Орхон аймгийн Бүжгийн холбоод хамтран "Бүжин наадъя" бүжгийн фестивалийг зохион байгуулан 13 аймгийн 1300 гаруй бүжигчид оролцож орон нутгийн төсвөөс 6.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Соёлын яамнаас зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол" фестивалд аймгийн соёл, урлагийн салбраас 60 гаруй хүн амжилттай оролцож, орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөг зарцуулсан байна. Орхон, Булган аймгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд "Хангинахын шугуйн шагайн тойром" соёл, спортын үйл ажиллагааг Булган аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан. 2022 онд "Соёлыг түгээе" аяныг "Хувийн соёл-Байгууллагын соёл-Хотын соёл" уриатайгаар зохион байгуулж боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүүхэд залуучууд, соёл, спорт, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ, худалдаа үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад чиглэсэн 40 гаруй арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан байна.	100%
97		Улсын хэмжээний шилдэг уран бүтээлийг орон нутгийн иргэдийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх	2022-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	1 уран бүтээл	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 20,0	УДЭТ-ын уран бүтээл "Анна каренина" жүжгийг аймгийн иргэдийн хүртээл болгоход орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан байна.	100%
98	3.2.2.Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, сурталчлах ажлын чанарыг нэмэгдүүлэн,	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж иргэд олон нийтийн хяналт оролцоог сайжруулах	2021-2024	БШУГ	Аймгийн Музей	Орон нутгийн төсөв	12.0	11 өрх	Гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж 20 өрхөд урамшуулал олгоно.	4.0	Орон нутгийн төсөв 4.0	Аймгийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хамгаалж буй 12 айл өрхтэй гэрээг шинэчлэн байгуулж, гэрээгээр хамгаалах бүсчлэлийг шинэчилсэн. 2022 оноос гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын А/227 дугаар захирамжаар Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 363 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулсан.	100%

99	иргэд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.	Айргийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн хийж аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулах	2023-2024	БШУГ	Аймгийн Музей	Орон нутгийн төсөв	60.0	-	-	-	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу малтлага, судалгааны ажлыг 2023 оноос эхлүүлэхээр орон нутгийн төсөвт 30.0 сая төгрөг батлуулсан.	үнэлэ эгүй
100		Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлах ажлыг техник, технологийн шийдлийг ашиглан шинэлэг хэлбэрээр зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв	40.0	-	Сурталчилгах ажлыг зохион байгуулна.	10.0	Орон нутгийн төсөв 34,0	Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлах, алдаршуулах ажлын хүрээнд өв тээгчдийн судалгааг шинэчилж, 120 өвлөн уламжлагчийг цахим орчинд сурталчилсан. Мөн "Номин" телевизтэй хамтран шилдэг 15 өвлөн уламжлагчаар "Эрдэнэтийн өв соёл" видео контентыг хийж иргэдийн хүртээл болгоход 4.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ нь иргэд, хүүхэд багачуудад уламжлал, өв соёлыг таниулах, түгээн дэлгэрүүлэх чухал нөлөө үзүүлсэн томоохон ажил болсон. Соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, бүртгэлийн www.ich.mongoluv.mn сайтад 198 хүний бүртгэлийг хийж, нийт өв тээгчдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр байна. Соёлын яамнаас зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол" фестивалд аймгийн биет бус өв тээгч, өвлөн уламжлагчид оролцоход орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ												
3.3.Шинэ технологи нэвтрүүлэх, инновацыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.												
101	3.3.1.Аймгийн онцлог, давуу талд тулгуурлан катодын зэс боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэх	2021-2022	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	167.3	-	Төслийг ажлын явцыг 100%-д хүргэнэ. Төсөл бүрэн хэрэгжиж дуусна.	83.7	Үйлдвэрийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын тендерт "Майнинг шорт лонг терм" ХХК шалгаран, 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/91 дүгээр тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Эрдэнэтийн овоо зэс молибдены ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. Гүйцэтгэгч компани нь 2023 оны 3 дугаар сар хүртэл гэрээт ажлын хугацааг сунгах хүсэлт ирүүлсэн. Мөн байгаль орчны үнэлгээ хийх ажлыг 2023 онд шилжүүлэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санал оруулсан. 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хуралдсан Ерөнхий захирлын өргөтгөсөн	30%

											зөвлөлийн хурлаар тус компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Үйлдвэрийн техникийн зөвлөлөөр болон УУХҮЯ-ын ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, гэрээг сунгаж ажиллах, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг дахин авч хэлэлцэхийг ажлын хэсэгт үүрэг болгосон байна. Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 2022 онд дуусгаж, үйлдвэрийг 2023 оноос барихаар төлөвлөж байна.	
102		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэх	2021-2024	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	1628.4	-	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 69%-д хүргэнэ.	690.7	Тасралтгүй үйл ажиллагаатай SKS технологитой зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэр барьж байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан. Элементийн хүхэр үйлдвэрлэх технологийн үйлдвэрлэлийн туршилтын ажлын үр дүнгээр ТЭЗҮ-д тодотгол хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/103 дугаар тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл”-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ China ENFI Engineering компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны Эрдэс баялаг металлургийн зөвлөлөөр 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцүүлэн дэмжигдэн 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэйгээр батлагдсан. ТЭЗҮ-д үндэслэн “Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах” ажлын техникийн даалгаврыг боловсруулж, Худалдан авах ажиллагааны газарт хүлээлгэн өгсөн. Үнэлгээний хороо байгуулагдан, тендер зарлахаар ажиллаж байна. Мөн Эрдэс баялаг металлургийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу “Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж, үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ” авах ажлын техникийн даалгаврыг боловсруулж, үнэлгээний хороог байгуулан, тендерийг зарлаад байна. Элементийн хүхэр үйлдвэрлэх технологийн үйлдвэрлэлийн	70%

											туршилтын ажлын үр дүнгээр ТЭЗҮ-д тодотгол хийгдэх тул ажил удааширч байна. Элементийн хүхрийн үйлдвэрлэлийн туршилтын ажил хуваарийн дагуу хийгдэж байгаа ба 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар Үйлдвэрлэлийн туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 98.0 хувьтай байна. Тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалтын ажил 96.0 хувийн гүйцэтгэлтэй, үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн. Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн хяналт шалгалтуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба үйлдвэрлэгчийн агуулахад тээвэрлэхэд бэлэн болсон байдалтай байна. Цар тахлын хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх боломжгүй байна. 2023 оны 6-р сард туршилтын үр дүн гарах төлөвтэй байна.		
103		Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төслүүдийг хэрэгжүүлэх	2021-2024	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г ҮТП “ШУТ П”	“Эрдэнэ т үйлдвэр ” ТӨҮГ	1495.1	-	Төслийн ажлын явц 50%. Төслийн ажлыг үргэлжлүүл нэ.	424.8		Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл: Өөрөө нунтаглах хэсэгт жилд 6 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 4 дүгээр шинэ шугам барих өргөтгөлийн ажлыг 2022 оны 08 дугаар сард, Нунтаглан баяжуулах хэсэгт хам баяжуулалтын хуучин секцийг барих ажил дуусаж хүлээн авч ашиглалтад оруулсан. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр жилд 6сая тонн хүдэр нэмэлтээр боловсруулж, 100 мянган тонн зэсийн баяжмал, 1100 тонн молибдены баяжмал үйлдвэрлэх боломжтой болсон. Мөчлөг Урсгалын Тээврийн Технологи: Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 95,0 хувь, металл хийцийн тээвэрлэлт 70,0 хувь, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт 30,0 хувьтай байна. Үйлдвэрийн зүгээс туузан дамжуулгын, бутлуурын талбайг бэлтгэх ажил гүйцэтгэж байна. Төсөл 60,0, хувийн гүйцэтгэлтэй байна. Эмульсийн Тэсрэх Бодисын Үйлдвэр: Инженерийн шугам сүлжээний ажил 75,0 хувь, барилгын угсралт 85,0 хувь, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт 75,0 хувийн гүйцэтгэлтэй байна.	70%
104	3.3.2.Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн	Их, дээд сургууль, МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг	2021-2024	ХБТХ ОХ “ШУТ П”	ХХАА Г ХХҮГ	Орон нутгийн төсөв,	35.0	Гарааны 5 төслийг дэмжсэн.	Гарааны 5 бизнес санааг	10.0	Орон нутгийн төсөв 10.0	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэргэдэх “Эрдэнэт” цогцолбор дээд сургуулийн оюутнуудад инноваци, гарааны компанийн сургалт явуулж 3 оюутны бизнес санааг багш нартай	100%

	боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгон, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ.	хамруулсан гарааны бизнесийг дэмжин хөгжүүлэх		Хувийн хэвшил	Сумдын ЗДТГ	төсөл хөтөлбөр			дэмжин хөгжүүлнэ.			хамтран хөгжүүлж байна."Боломжоос өөрчлөлт рүү" шинэ санаа, шилдэг технологийн уралдаан, гарааны бизнесийн сургалт зохион байгуулснаар нийт 20 гаруй гарааны бизнесийн санаа бүртгэгдэж, үүнээс 5 төслийг шалгаруулан тус бүр 400,0 мянган төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн Бизнес хөгжлийн төвөөр дамжуулан холбогдох сургалт, зөвлөгөө өгч чадавхжуулж байна.	
105		Бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээг үе шаттай хүргэх, чадавхжуулах	2021-2024	ХБТХ ОХ "ШУТ П" Хувийн хэвшил	ХХААГ ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	35.0	10 бизнес эрхлэгч	10 бизнес эрхлэгчийг чадавхжуулна.	10.0	Орон нутгийн төсөв 10.0	Бизнес ширээгээр дамжуулан 10 бизнес эрхлэгчийг анхан шатны зөвлөх үйлчилгээ болох аж ахуйн нэгж хэрхэн байгуулахаас эхлээд ахисан шатны зөвлөх үйлчилгээ болох оюуны өмч, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэн гадаад, дотоод төсөл хөтөлбөрт хамруулан чадавхжуулан ажиллаж байна. "Баяжуулагч одод" ХХК, "Хос луу баян" ХХК, "Идэрбаялаг" ХХК, "Агдир бүтэмж" ХХК, "Эко инфинити солюшинс" ХХК, "Өндөрлөг" брэнд, "Анир Ялдам" ХХК, "Эрдэнэт Дакс" ХХК, Баян-Өндөр чацаргана жүүс, Гишүүгэнэ ундаа төсөл нь дотоодын "NEXT GEN", "MON X" болон гадаадын "GIZ" "PROGRES" төсөлд хамрагдсан.	100%
106	3.3.3.Инновацийн төсөл хэрэгжүүлэх хүрээнд технологийн парк, технологи дамжуулах төв, гарааны бизнесийг хөгжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гадаад, дотоодын зах зээлд гаргах, тэлэх, нээлттэй болоход нь дэмжлэг үзүүлнэ.	"Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-ын дэргэд технологи дамжуулах төв байгуулах	2021	"ШУТ П" ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ ХХААГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	2.0	-	-	-		"Эрдэнэт Шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-ын дэргэд Технологи дамжуулах төв 2021 онд байгуулагдаж 2022 оноос төв хариуцсан мэргэжилтэн, гадаад харилцаа, судалгааны ажилтан, эрдэм шинжилгээний ажилтан гэсэн 3 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Тус цогцолбор ашиглалтад орсноор судалгаа, шинжилгээ, туршилтын суурь бааз болж, гарааны бизнесүүд ажлын байраар хангагдах боломжтой болж байна."Эрдэнэт 2022-Инноваци, технологийн өдрүүд" үзэсгэлэн зохион байгуулж, 15 бизнес технологийн зөвлөгөө өгч, түлш үйлдвэрлэх, яс боловсруулж нохойн хоол үйлдвэрлэх, арьс шир боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх 3 инновацийн төсөл шалгаруулж дэмжлэг үзүүлсэн.	100% 2021 онд бүрэн хэрэгжиж дууссан
107		Бизнес эрхлэгчдэд инновацийн төслийн ТЭЗҮ боловсруулах,	2021-2024	"ШУТ П" ХБТХ ОХ	ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв,	34	1 бизнес эрхлэгчид технологи	3 бизнес эрхлэгчийг дэмжинэ.	10.0	Орон нутгийн төсөв 10.0	Цаас, хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж түлш үйлдвэрлэх төсөл буюу "Агдир бүтэмж" ХХК, яс дахин боловсруулж нохойн хоол үйлдвэрлэх "Хос луу баян" ХХК, арьс шир боловсруулж	100%

		бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зах зээлд гаргах, хөгжүүлэхийг дэмжих				төсөл хөтөлбөр		дамжуулсан.				"Handmade" бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Өндөрлөг" брэнд зэрэг 3 бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний технологийн хөгжүүлэлт, зах зээлд гаргах дээр бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж дэмжин ажилласан.	
ДӨРӨВ.ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ													
ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ													
4.1.Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдол, аюулыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.													
108		Гэр хорооллын үерийн хамгаалалтын далан сувгийн бэлэн байдлыг ханган ахуйн хог цэвэрлэгээг улирал бүр зохин байгуулах	2021-2024	ХЗА	ХТГ ОБГ ХХҮГ	Орон нутгийн төсөв	60.0	Хотын хэмжээнд	100%	15.0		2022 онд гэр хорооллын үерийн хамгаалалтын далан сувгийн ашиглалтын хэвийн байдлыг хангах ажлын хүрээнд 3-4 дүгээр саруудад Хотын захирагчийн алба, Хот тохижуулах газар, Онцгой байдлын газартай хамтран үзлэг хийсэн. Хотын их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж, үерийн сувгийн хог хаягдлыг цэвэрлэх ажилд тодорхой эрхэлсэн ажилгүй 87 иргэнийг ажиллуулж, төрийн болон хувийн хэвшлийн 431 аж ахуй нэгж, байгууллагын 2869 иргэдийн оролцоотойгоор 90413 м.кв талбайд цэвэрлэгээ зохион байгуулж 1156 м.куб хог хаягдлыг ачиж тээвэрлэн дарж устгаад байна.	100%
109	4.1.1.Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, үүсэж болзошгүй аваар ослыг бууруулна.	Гэр хорооллын шороон үерийн хамгаалалтын суваг шинээр татах	2021-2024	ХЗА ОБГ	ХТГ	Орон нутгийн төсөв	100.0	Хотын хэмжээнд	85%	20.0		Аймгийн хэмжээнд 72,8 км шороон үерийн суваг байгаагаас инженерийн хийцлэлтэй 10,2 км, далд 11,0 км, 51,6 км нь байгалийн гуу жалга болон авто замын ус зайлуулах хаялага байна. 2022 оны 6 дугаар сард 9.1 сая төгрөгөөр гэр хорооллын 6.0 км шороон үерийн сувгийг сэргээх ажлыг Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Хот тохижуулах газартай хамтран гүйцэтгэсэн. 9 дүгээр сард үзлэг хийхэд гэр хорооллын шороон суваг хэвийн ус урсах боломжтой бөглөрөл үүсээгүй байна.	70%
110		Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбай, тохижилтын нэгдсэн мэдээллийн сан байгуулж болзошгүй аваарыг түргэн шуурхай илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЗА	ХЗА ОНӨГ ОБГ СТСХ	Батлагдсан төсвийн хүрээнд	80.0	-	Аюул эрсдэлийг бууруулна.	Батлагдсан төсвийн хүрээнд		2022 онд "Аюулыг мэдээлэх аппликейшн"-ыг шинээр нэвтрүүлж тогтмол ажиллуулж, ирсэн мэдээллийн дагуу холбогдох газруудтай хамтран газар дээр нь үзлэг шалгалт хийж болзошгүй гэмтэл эвдрэлийг илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд 10 дугаар сарын байдлаар уг аппликейшнд 523 аюул ослыг мэдээлэх мэдээ ирж, шийдвэрлэлт 67.0 хувьтай байна.	90%

111	4.1.2.Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх, дэд бүтэц барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх	2021-2024	ХЗА БОАЖ Г	Баян-Өндөр сумын ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	50 өрх	Төсөв болон Хувийн зардал	Гэр хорооллын Цагаанчулуут багийн 47 дугаар гудамж 6 тоотын өрхөд нарны эрчим хүч хураах 4 панель ашиглаж, өрхийнхөө цахилгааны хэрэглээ болон нам даралтын цахилгаан халаагуурыг халаан ашиглаж байна. НҮБ байгууллагын Хүүхдийн сан, Байгаль орчны яам, ЗДТГазар хамтран гэр дулаалах CHIP багцыг гэрт амьдардаг 50 өрхөд олгогоод байна.	90%
112	4.1.2.Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх, дэд бүтэц барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй барилга, гэрэлтүүлэг шинээр барих (Нарны болон салхины эрчим хүч)	2021-2024	ХЗА ХБТХ ОХ	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ	Төсөл хөтөлбөр Иргэдийн оролцоо	500.0	-	25 өрх	Төсөв болон Хувийн зардал	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын HISENSE VRF группийн “Сэргээгдэх эрчим хүчний нарны халуун агаарын үлээлтийн системийн танилцуулга” төслийг турших үйл ажиллагааг эхлүүлээд байна. Төсөл санаачлагчтай хамтран 28кв болон 630кв цахилгаан халаалт бүхий 2 тоноглолыг Эрдэнэ багийн 11-р цэцэрлэг, Шанд багийн гудамжны айл өрхүүдэд суурилуулж туршилтыг эхлүүлсэн. Туршилтын үр дүнгээр Азийн хөгжлийн банкны Сэргээгдэх эрчим хүчний TA9608 төслийн хүрээнд “Жишиг ногоон гэр хороолол” төслийг эхлүүлэхээр харилцан санал солилцон төсөл боловсруулж байна.	30%
113	4.1.3.Хотын доторх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг стандартын түвшинд хүргэж, шинэчилнэ.	“Ногоон-Эрдэнэт” төслийг боловсруулан хэрэгжүүлэх	2021-2024	ХЗА	БОАЖ Г ЦНБ	Орон нутгийн төсөв	1000	-	Төслийн хэрэгжилт 25%	Төлөвлөгөө биелэгдсэн байна.	Орон нутгийн төсөв 200.0 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Нэгдүгээр зорилтын хүрээнд 1.3 сая ширхэг мод тарьж, шинээр 31 га талбайд мод үржүүлгийн газруудыг байгуулж аймгийн хэмжээнд нийт 2.5 сая ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүллээ. Хоёрдугаар зорилтын хүрээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлаар Баян-Өндөр сумын Хүрэн булгийн аманд Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн, Цагаанчулуутын ам, Чимээгүй хотын баруун талын ойн зурвас, Тарлан толгойн хойд энгэр, Монгол ёс заншлын өргөө, Сархиа уулын хойд энгэр, баруун салаа зэрэг газруудад олон нийтийн оролцоотой 35000 ширхэг мод тарьж, хотын ногоон байгууламжийг 22.7 га талбайгаар нэмэгдүүллээ. Гуравдугаар зорилтын хүрээнд 17 иргэн ААНБ-ыг урамшуулж, “Ногоон-Эрдэнэт” хөтөлбөрийн 2022	100%

											оны жилийн ажлын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн.		
114		Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг иргэд аж ахуй нэгж, байгууллагуудын оролцоотойгоор нэмэгдүүлэх	2021-2024	ХЗА	Сумын ЗДТГ	Байгууллагын зардал	ААНБ н зардал	20 ААНБ	25 ААНБ	Хувийн зардал	"Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд 5, 10 дугаар саруудад бүх нийтийн мод тарилтыг зохион байгуулсан. 2022 онд хотын доторх ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил 3 хэсгээс бүрдсэн бөгөөд ажлыг гүйцэтгэж дууссан. Үүнд: - Улсын болон Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй 3 ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж талбайд 2360 ширхэг мод бут. - Хотын ногоон байгууламжийг нөхөн сэргээх ажлын хүрээнд 7840 м2 зүлэгжүүлэлт, 5300 ширхэг мод бут. Олон нийтийн оролцоотойгоор Баян-Өндөр сумын хэмжээнд 2 удаагийн мод тарилтаар 383 аж ахуй нэгж, байгууллагын 8573 иргэдийн оролцоотой 11646 ширхэг мод, бут сөөгийг тарьж цэнэг усалгааг хийлээ.	100%	
115	4.1.4.Гэр хороололд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх,	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г ХЗА	Сумын ЗДТГ	БОХАХ 3 болон улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр	800.0	500 ш	200 ш	200.0	улсын төсөв 2200,0 орон нутгийн төсөв 200,0	Стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийн урамшуулал олгох 2022 оны ажлыг орон нутгийн хөрөнгөөр 200.0 сая төгрөгөөр "Их хурдатгал" ХХК гүйцэтгэж, 78 өрхөд эко 00-ийн суурийн байгууламжийг суурилуулаад байна. БОАЖА-ны 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр ОББҮХ/2022-124 тоот гэрээний дагуу Баян-Өндөр сумын Даваат, Шанд багуудад нийт 1000 ш иж бүрэн эко ариун цэврийн байгууламж баригдахаас газар шорооны болон кольцо, таг суулгалтын ажил бүрэн дууссан бөгөөд бүхээгийг гэрээний хугацаанд буюу 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гүйцэтгэж дуусгахаар ажиллаж байна.	100%
116	усны зөв хэрэглээний талаар бүх нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	Усны хэрэглээний талаар зөв мэдлэг, хандлага, дадлыг бий болгох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г МХГ СГСГ 3	Сумын ЗДТГ "ЭУДТ С" ОНӨХ К	БОХАХ 3	4.0	16 удаа	4 удаа	1.0	Орон нутгийн төсөв 1.0	Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2022 оны Дэлхийн усны өдрийг "Газрын доорх ус" сэдвийн доор бидний нүдэнд үл харагдах далд баялаг болох газрын доорх усыг судлах, үнэ, цэнийг таниулах, бохирдол, хомстлоос хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, нөөцийг зохистой ашиглах оновчтой менежмент хийхэд улс орнуудыг хамтран ажиллахыг уриалсан бөгөөд аймгийн хэмжээнд тус өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын удирдамж, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагууд хамтран боловсруулж, аймгийн Засаг даргаар батлууллаа. Төлөвлөгөөний дагуу мэргэжлийн байгууллагууд хамтран дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:	100%

											"Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" ОНӨХК нь "Усны үнэ цэнэ" сэдвийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудын дунд нээлттэй зөвлөгөөнийг 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Залуучуудын ордонд зохион байгуулав. - Унд усны эрүүл ахуйн чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэхээр Эрүүл мэндийн газар, багуудын ажлын албатай хамтран ажиллалаа. "Нүдэнд үл харагдах усыг таниулья" сэдэвт 1 цагийн хичээл бэлтгэж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цуврал сургалт зохион байгуулах ажлыг Насан туршийн боловсролын төв хариуцан гүйцэтгэлээ. - Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн цэцэрлэгийн дунд, ахлах бүлгийн хүүхдүүдэд зориулан байгаль орчин, танин мэдэхүйн цагаар мэдээлэл хүргэх ажлыг Сэлэнгэ голын сав газрын захиргаатай хамтран тус тус зохион байгууллаа. Дэлхийн усны өдөрт зориулан мэргэжлийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан "Усны үнэ цэн" сэдэвт зөвлөгөөнд Хууль, эрх зүйн орчин, төрөөс баримталж буй бодлого, аймгийн хэмжээнд байгаа гүний худгуудын судалгаа, ашиглалтын байдлын талаар мэдээлэл бэлтгэн хамтран оролцлоо. Дэлхийн усны өдөрт зориулсан 1.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий анонс, гарын авлага, тараах материалын эхийг боловсруулж, хэвлүүлэн Сэлэнгэ голын сав газрын захиргаа, Эрүүл мэндийн газрууд хамтран цэцэрлэг, сургууль, багуудын ажлын албадаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэн ажилласан.		
117	4.1.5.Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологийг	Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, бохирдлыг бууруулах	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г ХЗА Сумд ын ЗДТГ	ААНБ	БОХАХ 3 болон улсын төсөв	330.0	Рm10- ст-с 1.4 дахин давсан	MNS4585:200 ст-ын түвшин	100.0	Орон нутгийн төсөв 30.0	Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд: Аймгийн Засаг даргын 2021 оны А/22 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 13466 айл өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 28 уурын зуух (хүчин чадлаар ялгаатай), 21600 авто тээврийн хэрэгслийг хамруулан зохион байгууллаа. 2021-2022 оны өвлийн улиралд 57574 м.куб мод, 791685	100%

	бодлогоор дэмжинэ.											тонн нүүрс түлсэн байна.Тооллогын хүрээнд нийт 15 удаагийн сургалтыг баг тус бүрд зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллалаа. ● Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрдэнэт хотод хэрэгжиж байгаа "Агаарын чанарыг сайжруулах мэдлэг үйл ажиллагааг бэхжүүлэх-ТА9608" төслийн хэрэгжих хугацаа 2023 оны 12 сар хүртэл сунгагдаж, агаарын бохирдлыг бууруулахад оролцогч талуудын хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг Орхон аймагт 5 удаа зохион байгуулж, төслийн багаас "Эрдэнэт хотын Цэвэр агаарын төлөвлөгөө"-г боловсруулсан. ● Байгаль орчин аялал жуулчлалын газар, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны санхүүжилтээр агаарын бохирдлын түвшинг тодорхойлох автомат анализатор (SO2, NO2-NO-NOx, PM2.5, PM10, CO)-ыг мэдээлэл дамжуулах программ хангамж, сорьц дамжуулах системийн хамт суурилуулахаар шийдвэрлэж, Эрдэнэт хотын агаарын чанарын мониторинги хэмжилтийн харуулын цэгийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлээ. ● Эрдэнэт хотын агаарын чанарын хэмжилт судалгааг өдөр тутам батлагдсан хөтөлбөрийн дагуу хийж, рm2.5-ийн дүн мэдээг MNS 4585-2007 стандарттай харьцуулан үзэхэд сарын дундаж агууламж стандартаас даваагүй боловч хүйтний улиралд стандартаас 1.1-ээс 3.6 дахин давсан байна. /рm10-ийн багаж эвдэрсэн/ ● "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн далан дээр байрлуулсан тоосны 2 ширхэг суурин станцын мэдээллийг улсын нэгдсэн сүлжээнд холбох талаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба, Үндэсний дата төв, www.agaar.mn цахим хуудас, орон нутгийн мэргэжлийн байгууллагууд, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг оролцуулан ажлын хэсэг байгуулж, тоосны автомат станцыг цагаан тоосны нөлөөллийн бүс буюу Говил багийн 2-р цэцэрлэгийн хашаанд нүүлгэн шилжүүлэхээр шийдвэрлэж, дүн мэдээг www.agaar.mn цахим хуудсанд байршуулж эхлээд байна.	
118		Байгальд ээлтэй газрын хэрэглээ болон бусад үр ашигтай дэвшилтэт	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г	ХЗА Сумд ын ЗДТГ	БОХАХ 3 болон улсын төсөв	300.0	Хийн хөдөлгүүртэй тээврийн	Хийн хөдөлгүүртэй тээврийн	100.0		Эрдэнэт хотын хэмжээнд ахуйн болон тээврийн хэрэгслийн зориулалтаар шингэрүүлсэн шатдаг хийн түлш түгээдэг 4 аж ахуйн нэгж, байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд	100%

		ногоон технологийг бодлогоор дэмжих						хэрэгсэл-1363 ш Хийн халаалтын систем-0	хэрэгсэл-1400 ш			"Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл"-ээр агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрийн тоо аймгийн хэмжээнд 21600 ширхэг авто тээврийн хэрэгсэл тоологдсон ба хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 2002, цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 3, хосолсон хөдөлгүүртэй 6510 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь 2020 оны суурь түвшинтэй харьцуулахад хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 46.9 хувиар өссөн байна.	
119	4.1.6.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.	Эрдэнэт хотын хатуу хог хаягдлын боловсруулах, татан зайлуулах менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	2021-2023	ХБТХ ОХ ХЗА	ХТГ	Гадаадын зээл	30150.0	-	Төслийн хэрэгжилт 90%	1507.5		Бүгд Найрамдах Польш улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хоорондын байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд "Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийг хамтран хэрэгжүүлж байна. Машин механизмууд болон үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материал, төмөр хийцлэл орж ирсэнтэй холбоотой үйлдвэрийн барилгын ажил үргэлжилж байна. Барилгын үйл явцад гүйцэтгэгч компани болон аймгийн ХББЗА-аас хяналтын инженер ажиллаж байна. 2022 онд 6 төрлийн 12 машин механизм нийлүүлэгдээд байна. Гэр хорооллын хог татан авалтыг оновчтой болгох зорилгоор хөдөлгөөнт чингэлэг, тээвэрлэх авто машинуудыг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээ. Ингэснээр гэр хорооллын айл өрхүүдээс 5 дахь удаагийн хог татан авалтыг хийж орон сууцны болон гэр хороололын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, барилга, эзэнгүй дүүрэг, нийтийн эзэмшлийн зам талбайн нийт 154336м3 хог хаягдал ачиж тээвэрлэн хог хаягдлын нэгдсэн цэгт дарж устгалаа.	70%
120		Олон нийтэд хог хаягдлын талаар боловсрол олгох, үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах	2021-2024	ХЗА	БОАЖГ Баян-Өндөр сумын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлсэн байна.	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлнэ.	5.0	Орон нутгийн төсөв 140.0	2022 онд Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд олон нийтэд хог хаягдлын талаар боловсрол олгох, үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараахи ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: 1. Хог хаягдлын Алтан дүрэм буюу Хогийг хогийн саванд 3R зарчмыг нийт 80 төрийн болон төрийн бус байгууллагуудын 330 ажилтан алба хаагч нарт танилцуулж, дадал болгох ажлыг зохион байгуулсан. 2. БОАЖЯ-ны сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 15-	100%

												ны өдрийн 06БҮХ/2022-35 тоот "Цагаан тоосонцор бууруулах, доройтсон ойг нөхөн сэргээж зориудаар ойжуулах ажилд дэмжлэг үзүүлэх ажлын гэрээний дагуу Орхон аймгийн Цагаан тоосжилтын эх үүсвэрийн бүс буюу өндөр тархалттай байршилд байрлах хог хаягдлын нэгдсэн цэгийн хөрсний доройтлыг бууруулах цагаан тоосжилтийн эх үүсвэрийг багасгах, тархсан хог хаягдлыг хумих, зогсоох, далан байгуулах, нөхөн сэргээлт хийх, ногоон зурвас бий болгох, ойжуулалтын ажил хийгдсэн. Үүнд 30 гаруй төрийн байгууллагын 486 төрийн албан хаагчид, Хот тохижуулах газрын 118 ажилтан алба хаагч нар салхиар тархсан хогийн цэгийн орчмын 104,8 га талбайн түүвэр хог хаягдлыг цэвэрлэн, хог хаягдлын алтан дүрэм нөлөөллийн сургалтанд хамрагдсан. 3."Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд иргэдэд соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлыг хийх сургагч багш бэлдэж, "Соёлоороо ялгарцгааа" сургалт хэлэлцүүлэгийг эхлүүлсэн. Орхон МСҮТ-ийн багш, ажилчид, Эрүүл мэндийн газар, Баянцагаан, Булаг, Эрдэнэ, Уртын гол багийн иргэд, Даниста худалдааны төвийн худалдаа эрхлэгчид, 15-р сургуулийн багш, ажилчид, Баян-Өндөр сумын багуудын Засаг дарга нар, зохион байгуулагч, нийгмийн ажилчид, хэсгийн ахлагч нар нийт 2560 хүн сургалтанд хамрагдсан. 4. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг сурталчилах, иргэдэд соён гэгээрүүлэх, зөв хандлагыг бий болгох зорилгоор богино хэмжээний бичлэг, шторк бэлдэх, цаг үеийн мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх зорилготойгоор ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн сошиал хаягаар дамжуулан телевиз, сайтуудаар видео бичлэг, 32 мэдээ, Хотын захирагчийн алба болон ХТГ-ын фэйж хуудсаар 60 ширхэг шторк, контент, бичлэгийг иргэдэд хүргэж ажилласан. 5. Орхон аймаг, НҮБ-тай хамтран ЯЛГАЖ САЛГАЯ нөлөөллийн аяныг эхлүүлээд байна. Иргэд хогийг дахин боловсруулах замаар эргэлтэнд оруулж бүтээгдэхүүн болгох, эдийн засгийн ашиг тус хүртэж, эх дэлхийгээ хамгаалах боломжийг эрэлхийлдэг болсон. Тус аянд Тээвэр ложистикийн туршилтын ажил хийгдэж байгаа Уурхайчин СӨХ, Уртын гол багийн баянзам, Данистай төвийн худалдаа эрхлэгч нар нь хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөлөөллийн аяныг	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

												хэрэгжүүлсэн. Уг ажлын хүрээнд 900 өрхийн 2700 иргэд хамрагдсан. 6. Орхон аймгийн хөршийн холбоо гудамжны ахлагч нарыг чадавхижуулах тэднээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэн нөлөөллийн ажлын хүрээнд нийт 1050 иргэнийг сургалтанд хамруулан ажиллахаар төлөвлөн ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр Орхон аймгийн хэмжээнд 12700 орчим иргэд буюу хүн амын 12%-д хог хаягдлын талаар ойлголт, мэдээ мэдээлэллийг хүргээд байна.	
121		Хот тохижуулах газарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг үе шаттай хийх	2021-2024	ХЗА ХТГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	Тухайн төсвийн хүрээнд	Парк шинэчлэлт 5%	Парк шинэчлэлт 40%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 1400,0	Хот тохижуулах газрын парк шинэчлэлтэнд орон нутгийн 1.4 тэрбум төгрөгөөр гэр хорооллын хог татан авалтыг оновчтой байдлаар шийдвэрлэх зорилгоор машин, техник хэрэгсэл төлөвлөн батлуулсан. Үүнд - Хөдөлгөөнт чингэлэг тээвэрлэх 4 автомашин, - Хөдөлгөөнт 40 ширхэг чингэлэгийг Сэлбэ сэрвис ХХК нийлүүлээд байна. Мөн орон нутгийн 405 сая төгрөгийн хөрөнгөөр авто зам цэвэрлэх зориулалт бүхий тусгай зориулалтын 3 машин худалдан авахаар тендерийн сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч шалгараад байна. 2022 онд Хот тохижуулах газарт 7 ширхэг шинэ машин нийлүүлэгдснээр парк шинэчлэлт 63% хүрч байна.	90%
122	4.1.7.Гүний усны ашиглалтын хязгаарлан, гадаргын усны хуримтлал бий болгож, усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, аймгийн цэвэр усны хангамжийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.	Гадаргын усны чанарын хяналт, мониторингийг тогтмол, хуваарийн дагуу хийж мэдээллээр хангах	2021-2024	УЦУО ШТ	БОАЖ Г МХГ	Улсын төсөв	-	-	MNS 4586:98 Стандартын түвшин	-		Орхон аймгийн УЦУОШТ-ийн БОШЛ нь Хангал, Эрдэнэт, Орхон голуудаас жилийн эцсийн байдлаар 77 сорьц авч 23 үзүүлэлтээр нийт 1771 удаагийн давталттай чанарын хяналт-шинжилгээ MNS 4586:1998 усан орчны чанарын үзүүлэлт ерөнхий шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр Хангал голын эрдэсжилт 767-1352мг/л, аммоны азот Хангал-Эрдэнэт доод цэг дээр 1.1-8.6 дахин буюу нийт хэмжилтийн 50%-д нь, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 2,4,5,9 саруудад хүчилтөрөгчийн горим алдагдаж 1.2-38.7 дахин хүлцэх агууламжаас давсан байна. Хангал-Улаантолгой цэг дээр биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 5,9 саруудад хүлцэх агууламжаас 1.4-1.5 дахин давсан байна. Хангал-Эрдэнэт дээд, Хангал-Хангал өртөө цэгүүдэд усны чанар хэвийн горимд байна. Хангал гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой түвшинд байна. Орхон-Хангал дээд цэгийн эрдэсжилт 138.8-372.7мг/л хооронд хэлбэлзэж ХА-аас давсан үзүүлэлт байхгүй байна. Орхон-Хангал доод цэгийн эрдэсжилт 382.3-582мг/л хооронд хэлбэлзэж,	100%

											умбуур бодисын агууламж Хангал голын нөлөөгөөр ихэссэн байна. Аммоны азотын агууламж 8 сард ХА-аас 1.1 дахин давсан байна. Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр гэсэн ангилалд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон БОХЗТЛабораторит сарын бүрийн 5-ны дотор дамжуулж Орхон аймгийн УЦУОШТ-ийн http://orkhon.tsag-agaar.gov.mn/ сайтан дээр сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна.		
123		Бохирдуулагч эх үүсвэрүүдийн технологийн хяналтыг сайжруулж, сөрөг нөлөөллийг бууруулах	2021-2024	МХГ БОАЖ Г	УЦУО ШТ	ААНБ- ын өөрийн зардлаа р	-	-	-	-	улсын төсөв 1000.0	Аймгийн хэмжээнд хөрс, усны бохирдуулагч эх үүсвэрүүдийн судалгааг 2022 оны 03 дугаар сарын 9-11-ний өдрүүдэд тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, голын голдирол дагуу 38 цэг байршилд хуримтлагдсан 885 м.куб хуурай хог хаягдал, 300 м.куб шингэн хөлдүүс хаягдал бохир ус байгааг илрүүлж, нийт 50 эх үүсвэрийг тогтоож, таслан зогсоож, цэвэрлүүлж, бохирдлыг бууруулан ажиллалаа. Эрдэнэт хивс ХХК-ийн хивс цардах процессоос үүсэх латексын шугам гэмтэж, борооны ус зайлуулах шугамруу нийлснээс Далиу булаг орчимд үерийн жалгаар бохир ус урсаж байсныг зогсоож, эх үүсвэрийг тогтоож, бохирдсон хөрсийг цэвэрлүүллээ. Жаргалант сумын бохирын худгийг засварлуулж, шороон далан байгуулж, бохирыг технологийн карт руу цуглуулах арга хэмжээг авч ажиллалаа. Эрдэнэт хотын хог хаягдлын нэгдсэн цэгийн тэлэлтийг хумих, бохирдлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, ОББҮХ-той хамтран 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн төрийн байгууллагууд, ААН-үүд, иргэдийн оролцоотойгоор нийт 155.5 га талбайн 1283м3 хог хаягдлыг хумьж, 120м урт, 4м өндөр хамгаалалтын далан байгуулж, 1000ш улиас, 700ш хайлаас, 300ш шар хуйс тарьж ойн зурвас байгуулж, хөрсний бохирдлыг буурууллаа. Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагуудын MNS 4943:2015 Хүрээлэн буй орчин, Усны чанар, Хаягдал ус, Ерөнхий шаардлагын дагуу болон MNS6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны ерөнхий шаардлагын дагуу хяналт шинжилгээ хийж гүйцэтгэж байна. Жилийн эцсийн байдлаар цэвэрлэх байгууламжийн 48 дээж, хяналтын цооногын 183, гадаргын усны 12, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлж байгаа	100%

											хаягдал ус 22, гүний худгийн 7, крантны 1 дээжинд гэрээнд заасан үзүүлэлтүүдээр тус тус хяналт шинжилгээ хийсэн.		
124		Хөв цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалж, тохижуулах	2021-2024	ХЗА БОАЖ Г	Сумд ын ЗДТГ	БОХАХ 3	252.0	Хөв цөөрөм 1ш , булаг шанд 3	Хөв цөөрөм 1ш, булаг шанд 3	129.0	Орон нутгийн төсөв 10,5	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2022 оны 10.5 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын Алтан булаг, Жаргалант сумын Дулаан-Уул багт байрлах Дарштын булаг, Жаргалантын аман дахь булгийн эхийг иж бүрэн хамгаалж тохижуулах ажлыг гүйцэтгүүлж, тухайн газар оршин суугчдын хэрэгцээнд хүлээлгэн өгөөд байна. Булаг шандын эхийг хамгаалах ач холбогдлын талаар бүх нийтэд зориулсан сурталчилгааны мэдээллийн самбарыг сэргээн засварлаж байрлууллаа.	90%
125		Айл өрхүүдийн хашаанд гаргасан ундны усны худгуудаас дээж авч шинжилгээнд хамруулан дүгнэлт гаргаж мэдээллээр хангах	2021-2024	БОАЖ Г	МХГ	БОХАХ 3	20.0	Шинжилгэ энд хамруулсан худгийн тоо 11	Шинжилгээ нд хамрагдах худгийн тоо 60	5.0	Орон нутгийн төсөв 5.0	Орхон аймгийн хүн амын нэгдсэн усан хангамжийн 62 цэгээс дээж авч шинжилгээнд хамруулсан. Жаргалант сумын өрх бүрээс ус хангамж, ариун цэврийн байгууламжийн судалгаа авсан бөгөөд судалгаанд 571 өрхийн 1914 иргэн оролцож, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн үнэлгээг 3 баг, сумын хэмжээнд тус тус боловсруулж, судалгааны ажлын үр дүнгээр мэдээллийн сан үүсгэлээ. Жаргалант сумын шаардлага хангасан ус хангамжийн хүртээмж 80.37 хувь байна. Сумын нийт хүн амын 18.36 хувь нь төвлөрсөн ус хангамжийн системтэй, 0.43 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас, 54.06 хувь нь хамгаалагдсан худгаас, 7.52 хувь нь хамгаалагдсан булгаас усаа авдаг. Сумын нийт хүн амын 19.27 хувь нь шаардлага хангаагүй ундны усны эх үүсвэрийг хэрэглэж байна.	100%
126		Гадаргын болон газрын доорх усны чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөх, ус бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	2021-2024	БОАЖ Г Татварын хэлтэс	МХГ СГСГ 3	БОАЖЯ , БОХАХ 3	70.0	Мониторингийн цооног тоноглох, 2 ш Ус бохирдуулагч эх үүсвэр,10 %	1 багц	35.0	Орон нутгийн төсөв 35.0	Баян-Өндөр сумын Дэнж багийн нутаг дэвсгэрт байрлах унд ахуйн усны эх үүсвэрийн цооногийг бүрэн автомат /Online/ төхөөрөмжөөр тоноглох ажлын даалгаврын дагуу CTD-Driver Datalogger, range 100 meter /даталоггер бичлэгийн төхөөрөмж/, Power supply equipment буюу цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийг худалдан авахаар Виматек ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус цооногийг тоноглон улсын сүлжээнд холбож, автоматжуулах ажил үнийн өсөлттэй холбоотойгоор санхүүжилт хүрэлцээгүй учраас 2023 онд хийгдэнэ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.3 дахь хэсэгт "Төлбөрийн орлогыг Байгаль орчин,	100%

											уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-иас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна" гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд аймгийн хэмжээнд ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 3 цэвэрлэх байгууламжийн судалгаа, мэдээллийг нэгтгэж хүргүүлэв. 2022 онд орон нутгийн төсөвт ус бохирдуулсны төлбөрөөр 1,272.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.		
127	4.1.8.Хот орчмын орон нутгийн хамгаалалтай газарт таримал ойн төгөл, ногоон зурвас байгуулж, жилд ойжуулах талбайг хэмжээг нэмэгдүүлж, тарьц, суулгацын нөөц бүрдүүлнэ.	Эрдэнэт хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар мод тарьж, ойн төгөл, зурвас байгуулах	2021-2024	БОАЖ Г ХЗА	“Эрдэ нэт үйлдвэр”ТӨ ҮГ	БОХАХ 3, дүйцүүлэн хамгаалах зардал	352.0	1 га	14 га	50.0	Орон нутгийн төсөв 50,0	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулж, Чимээгүй хотын хамгаалалтын ойн зурвас, Цагаан чулуутын ам, А1001 авто зам дагуух ойн зурвас, Эрдэнэт хаалга, зэрэг газруудад таримал 11500 ширхэг навчит болон шилмүүст мод, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн орчимд цагаан тоосны дэгдэлтийг сааруулах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг 50 га талбайд 100.0 мянган ширхэг мод тарих зэрэг ажлуудыг 261.0 сая төгрөгийн санхүүжилтээр олон нийтийн оролцоотой зохион байгуулж, 56 га талбайгаар нэмэгдүүлсэн.	100%
128		Жилд ойжуулах талбайн хэмжээг 25 га-д хүргэх, хэрэгцээтэй тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх	2021-2024	БОАЖ Г	СДОА	БОХАХ 3	137.5	14 га	22	24.2	Орон нутгийн төсөв 24.2	Жаргалант сумын Хөндлөнгийн амны ойн санд 19,5 сая төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлыг ойн мэргэжлийн байгууллага Хөвөнтөн ой ХХК-аар гүйцэтгүүлж, ойжуулсан талбайг 18 га талбайгаар нэмэгдүүлж 62 га талбайд хүргэлээ. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудад тарьц, суулгацын, үрийн нэгдсэн тооллогыг зохион байгуулж 4 төрлийн шилмүүст модны 0.4 сая ширхэг, 20 төрлийн навчит модны 2 сая ширхэг тарьц, суулгацын нөөцтэйг тогтоогоод байна.	72%
129	4.1.9.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж	Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын уулын ажлын төлөвлөгөө	2021-2024	БОАЖ Г МХГ ЦГ	Сумын ЗДТГ	Ашигт малтмалын тусгай	Ашигт малтмалын тусгай	1190.24 га	3 га	-		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хаягдлын аж ахуйд хамгаалалтын ногоон зурвас хийж 4 төрлийн 936.9 мянган ширхэг навчит болон шилмүүст модыг 50.0 га-д, Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг	100%

	ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны улмаас болон хууль бус үйл ажиллагаанаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүн, хариуцлагыг дээшлүүлнэ.	болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жилд 1 га доошгүй техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх				зөвшөөрөлтэй ААНБ-уудын өөрсдийн зардлаар	зөвшөөрөлтэй ААНБ-уудын өөрсдийн зардлаар				дэвсгэр дэх гурван замын ногоон зурваст "Ачит-Ихт" ХХК 1600 ширхэг хайлаас, "Эрдмин" ХХК 1000 ширхэг улиас, "Гал сэнтий" ХХК 1000 ширхэг улиас модыг тус тус тариалж, намрын цэнэг усалгаа, арчилгааг нь гүйцэтгэн нийт 66.0 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг гүйцэтгүүлээ. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ 2022 оны уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусгуулан батлуулсны дагуу 3-р овоолго дээр 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлсэн. Мөн "Очир төв" ХХК Хангал гол дагуу 500 ширхэг улиас модыг 0.5 га-д, "Зэс эрдэнийн хувь" ХХК үйлдвэрийнхээ замын ногоон зурвасыг шинээр хийж 500 ширхэг улиас, 200 ширхэг шинэс модыг тус тус тарьж арчлан ургуулж байна.		
130		Аймгийн хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон газруудын нөхөн сэргээлтийг үе шаттайгаар гүйцэтгүүлж нийтийн эзэмшилд шилжүүлэх	2021-2024	БОАЖГ МХГ ЦГ	Сумын ЗДТГ	БОХАХ 3	47.5	10	2 га	9.5	Орон нутгийн төсөв 9.5	Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт элэгдэж эвдэрч эзэнгүй орхигдсон 2.0 га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллага болох "Вондер вон" ХХК-тай гэрээ байгуулан БОНХАЖС-ын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэлийг газар дээр нь аймгийн Засаг даргын 2020 оны А/540 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг шалгаж, танилцан актаар хүлээн авч тус талбайд дахин эзэнгүй хог хаягдал асгуулахгүй, эвдэрсэн газар шинээр бий болгохгүй байх чиглэлээр Жаргалант сумын ЗДТГ-ын байгаль орчны хэсэг, Дулаан-Уул багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нарт даалгаж ажиллалаа.	100%
131	4.1.10.Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, цагаан тоосны дэгдэлтийг	Аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, сөрөг нөлөөллийг бууруулах	2021-2024	МХГ БОАЖГ	МХГ БОАЖГ	ААНБ-ын өөрийн зардлаар	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдсан ААНБ-ын тоо 32	ААНБ-ын тоо 5	ААНБ-ын өөрийн зардлаар	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг E-Mongolia цахим системд шилжүүлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар шинээр хэрэгжих болон хэрэгжиж буй нийт 36 төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, тус төслүүдийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим мэдээллийн санд оруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллалаа.	100%	

132	бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах богино хугацааны хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	ААНБ-ын өөрийн зардлаар	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ-ын зардлаар	10%	50%	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зардлаар	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан "Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр, төлөвлөгөө", Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: Хаягдлын аж ахуйн тоос идэвхитэй дэгддэг 800 га талбайд технологийн 3 аргыг хослуулан тоос дарах ажлыг зохион байгуулж, нийт хуурайшилттай 1000 га талбайн 80%-ийг дарж, тоосны дэгдэлтийг бууруулсан.	70%	
ЭРҮҮЛ ХҮНС													
133	4.2.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.	“Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хүн амын хүнсний хэрэгцээт мах, төмс, гурилыг бүрэн, хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангах	2021-2023	ХХАА Г ХБТХ ОХ	МХГ ЭМГ Сумын ЗДТГ СХЗХ	Орон нутгийн төсөв	75.0	Хэрэгжилтийн хувь 30%	Хэрэгжилтийн хувь 70%	25.0	Орон нутгийн төсөв 24.3	"Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн" хөтөлбөр нь 2020-2021 онд 5 зорилтын хүрээнд 85.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. 2022 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход: Малын мах-3714.4 тн, сүү-4952.6 тн, цагаан идээ-5571.6 тн, гурил-3095.3 тн, гурилан бүтээгдэхүүн-5571.6 тн, төмс-3714.4 тн, хүнсний ногоо-8047.9 тн, жимс-6190.7 тн, өндөг-619.0 тн хэрэгцээтэйгээс малын махны 92.7 хувь, гурил-0 хувь, гурилан бүтээгдэхүүний 34.5 хувь, жимс, жимсгэний 0.3, төмсийг 86.5 хувь, хүнсний ногооны 72 хувь, өндөгний 2.3 хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа бол шингэн сүүний 2.7 хувь, цагаан идээний 5.4 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангаж байна.	100%
134		Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумын ЗДТГ	Орон нутгийн төсөв	184.0	Хэрэгжилтийн дундаж хувь 85%	Хэрэгжилтийн хувь 95%	46.0	Орон нутгийн төсөв 29.6	"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 104 дүгээр тогтоол нь Улсын Их Хурлын 2021 оны 11 сарын 12-ны өдрийн "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай" 89 дүгээр тогтоолын 9 дэх заалтаар хүчингүй болсон. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр нь 2017-2021 онд 94.9 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжсэн.	99%
135		Хаврын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор махны нөөц бүрдүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Хувийн хэвшил	Орон нутгийн төсөв	2.200.0	Хаврын хэрэгцээт махны 25%-ийг хангасан.	50-аас доошгүй хувийг хангана.	600.0	Орон нутгийн төсөв 305.9	Аймгийн хүн амын 2022 оны хаврын хэрэгцээнд нийт 150 тонн үхэр, хонь, ямааны мах бэлтгэх, хадгалах, худалдаанд нийлүүлэх гэрээг аймгийн Засаг даргын Тамгын газраас "Эрдэнэт мах маркет" ХХК-тай байгуулсан. Тус гэрээний дагуу энэ оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 05-ны	100%

											өдрийг хүртэл хугацаанд ангилан савласан 1 кг үхрийн мах 7800 төгрөг, хонины мах 1 кг нь 6800 төгрөг, ямааны мах 1 кг нь 5800 төгрөгөөр буюу нийт 31 цэгээр борлуулсан. Нөөцийн мах нь орон нутгийн зах зээлийн махны үнээс үхрийн мах 5700, хонины мах 5200, ямааны мах 4200, Нийслэлийн нөөцийн махны үнээс үхрийн мах 1100, хонины мах 1500, ямааны мах 1300 төгрөгөөр хямд борлуулагдсан.	
136	4.3.Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.	Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийн хэрэгжилтийг ханган ажиллах	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	ЭМГ МХГ	Орон нутгийн төсөв	15.0	Бүтээгдэх үүний давсны агууламж 47.9 хувиар буурсан.	Бүтээгдэхүү ний давсны агууламж 50.0 хувиар буурна.	5.0	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар дамжуулан хүн амын хоол хүнсний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, давсны хэрэглээг бууруулах мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол хийж хэвшсэн. Эрүүл мэндийн газраас сургууль, цэцэрлэг, эмнэлэг сувиллын байгууллагуудын эмч, хоол зүйч нарт давс, сахар чихрийн хэрэглээг бууруулах, хэрэглэгчдэд эрүүл шим тэжээллэг хүнс, хоол олгох, хэвшил болгох талаар 3 удаагийн сургалтыг үе шаттай зохион байгуулж, нийт 84 мэргэжилтнийг хамруулсан. Хүн амд хоол тэжээлийн боловсрол олгох сургагч багшаар 152 хүнийг бэлтгээд байна."Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээнд хиа, талх, нарийн боов, үйлдвэрийн ажилчдын хоол үйлдвэрлэгч, эмчилгээ сувилал, сургуулийн хоол үйлдвэрлэл, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл зэрэг нийт 22 аж ахуйн нэгж, байгууллага 88 төрлийн бүтээгдэхүүнээр өөрсдийн хүсэлтээр оролцож, Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид 3 шатны лабораторийн шинжилгээг хийхэд 88 төрлийн бүтээгдэхүүнээс буураагүй 8 бүтээгдэхүүн, 20 хүртэл хувь буурсан 2 бүтээгдэхүүн, 21-30 хувь буурсан 15 бүтээгдэхүүн, 31-40 хувь буурсан 5 бүтээгдэхүүн, 41 хувиас дээш 58 бүтээгдэхүүн буюу дунджаар бүтээгдэхүүний давсны агууламж 53.8 хувиар буурсан дүнтэй байна.	100%
137		Хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартын талаар үйлдвэрлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх	2022-2024	СХЗХ ХБТХ ОХ	ХХАА Г	Орон нутгийн төсөв	6.0	20 үйлдвэрлэл эрхлэгч	20 үйлдвэрлэл эрхлэгч	2.0	Орон нутгийн төсөв 2.0	Тайлант онд бялуу, бялуун бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 10 байгууллагын 12 хүнд техникийн зохицуулалт болон Олон Улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, эгзэгтэй цэгийн хяналт НАССР-ийн талаар, "Эрдэнэт мах маркет" ХХК-ийн махны үйлдвэрийн давхардсан тоогоор 202 инженер техникийн болон үйлдвэрийн ажиллагсад Олон Улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 22000 сургалтад хамруулж

											мэдлэгийг дээшлүүлсэн бөгөөд хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын 10 удаагийн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлаар давхардсан тоогоор 31 аж ахуйн нэгжийн 246 хүн хамрагдаж, 32 ажилтан гэрчилгээжсэн.	
138		Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	2022-2024	CX3X	ХБТХ ОХ ХХАА Г	Орон нутгийн төсөв	9.0	Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 0%	Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 3%	3.0	Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох зорилгоор 3 удаагийн сургалтаар 23 үйлдвэрлэгчийг, аюулгүйн тэмдгийн талаарх мэдлэг ойлголтыг 237 хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд өгч, нийтэд сурталчилсан.2022 оны байдлаар Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын орон тооны бус зөвлөл"-ийн шийдвэрээр "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдгийг талх, нарийн боов, бялуун бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 2 үйлдвэрийн 29 нэрийн бүтээгдэхүүн, мал төхөөрөх мах боловсруулах 2 үйлдвэрийн 4 нэрийн бүтээгдэхүүн, нийт 4 үйлдвэрийн 33 бүтээгдэхүүн эзэмшиж байна. Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох зорилгоор холбогдох техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллах тухай "Баталгаажуулалтын мэдэгдэл" -ийг сүү, сүүн бүтээгдэхүүн, бялуу, бялуун бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 11 аж ахуйн нэгжид хүргүүлснээр нэг аж ахуйн нэгж тохирлын баталгаажуулалтад хамрагдаж, аюулгүйн тэмдгийг бялуун бүтээгдэхүүнд хэрэглэх эрхийг авч нийт бүтээгдэхүүний 2,9 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна.	96.6%
139		Хүнсний аюулгүй байдлыг хангах (НАССР) болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2022-2024	CX3X ХБТХ ОХ	Хамтарсан багууд	Орон нутгийн төсөв	7.5	Хамрагдсан үйлдвэрийн тоо 5	Хамрагдсан үйлдвэрийн тоо 10	2.5	"Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах шаардлага, эрх зүйн зохицуулалт" сэдэвт нэг өдрийн гэрчилгээт сургалтыг 2 удаа зохион байгуулж "Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" ISO:22000 стандарт, (НАССР)-ыг хэрэгжүүлэх стандарт болох "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим "(олон улсын зөвлөмж) MNS CAC/ RCP 1:2003 стандартыг нийт хүнс үйлдвэрлэгч 16 аж ахуйн нэгж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 15 аж ахуйн нэгжийг хамруулан хүнсний үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх зохистой дадал болон дээрх стандартуудыг хэрэгжүүлэх арга замыг таниулсан.	70%

											Аймгийн хэмжээнд нийт 4 аж ахуйн нэгж, байгууллагын 7 үйлдвэрлэл, үйлчилгээнд стандартыг хэрэгжүүлэх ажил хийгдэж байгаагаас 2021 онд "Хаан хүнс картеринг" ХХК, "Эрдмийт" ХХК Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 /HACCP/ стандартаар, "Жаргалант мах маркет" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК, "Эрдмийт" ХХК MNS CAC /RCP 1:2003 (HACCP) стандартаар тус тус гэрчилгээжсэн байна.		
140	4.4.Мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж нийтийн эрүүл мэндийг хамгаална.	Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Улсын болон орон нутгийн төсөв	210.0	Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 126.9 мянган толгой мал хамрагдсан.	120.0 мянган толгой мал хамруулна.	50.0	Улсын төсөв 38,0 сая Орон нутгийн төсөв 33.5	Мал, амьтны архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр 7 мал эмнэлэг үйлчилгээний нэгж, сумдын Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 112.2 мянган толгой мал, амьтныг халдварт, архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 11 төрлийн вакцин тарилгад хамруулахаас 100.1 мянган толгой мал, амьтныг хамруулж гүйцэтгэл 89.3 хувьтай хэрэгжиж байна. Тус арга хэмжээний санхүүжилтэд улсын төсвөөс 21.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 19.3 сая төгрөгийг тусган ажилласан. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтад нийт 46.7 мянган мал, амьтныг хамруулж 95,0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 192.0 мянган мал, амьтан хамрагдахаас угаалгад 82.2 мянган, туулгалтад 62.2 мянга, боловсруулалтад 55.4 мянган мал, амьтан хамрагдаж 100.0 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн.	100%
141		Малын бруцеллөз, лейкоз, адууны халдварт цус багадалт, ям өвчнүүд болон архаг халдварт өвчнүүдтэй тэмцэх	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Улсын болон орон нутгийн төсөв	95.0	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тандалт судалгаанд 3.4 мянган толгой мал хамрагдсан.	7.0 мянган толгой мал хамруулна.	25.0	Улсын төсөв 3.8	Баян-Өндөр, Жаргалант сумдын 142 өрхийн 978 хээлтүүлэгч малд бруцеллөзын тандалт шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Үүнд 157 бух, 445 хуц, 376 ухны цуснаас дээж авч шинжилгээ хийхэд нийт бухын 2.5 хувь, хуцын 0.2 хувь нь буюу нийт 978 хээлтүүлэгч малын 0.5 хувь нь халдвартай байна. Хээлтүүлэгч малд бруцеллөзын тандалт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр тухайн өвчний халдварлалт, тархалтыг сумдын түвшинд тогтоож, газар зүйн судалгааны тоон мэдээлэлтэй болж, үр дүнд суурилсан арга хэмжээг төлөвлөх нөхцөл бүрдсэн. Шинжилгээгээр эерэг буюу өвчтэй гарсан (бух-4, хуц-1) хээлтэгч малыг засах, хөнгөлөх арга хэмжээг авсан. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 6945 тугал, хурга 13080, ишиг 10835, нийт 30860 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 99.5 хувь хэрэгжсэн.	100%

142		Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, антибиотек, пестицитийн үлдэгдлийг тодорхойлох, малын эмийн зохистой хэрэглээг хангах	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	160.0	124 дээжид антибиотек, пестицидийн үлдэгдлийг тодорхойлсон.	350 дээжийг шинжилгээнд хамруулна.	40.0	Аймгийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж буй мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний 569 дээжид мал эмнэлгийн магадлан шинжилгээг хийж гүйцэтгэсэн. 3 аж ахуйн нэгж, 14 иргэний нийт 22 сүүний дээжид эмийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийхэд 1 иргэний сүүний дээжид эмийн үлдэгдэл илэрсэн. "Эрдмийт" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК, "Жаргалант мах импекс" ХХК-ийн махны үйлдвэрүүд, "Хүлэг" худалдааны төв, "Цах маркет" худалдааны төвүүдэд худалдаалж буй болон амралт сувиллын газарт мах нийлүүлж байгаа 79 аж ахуйн нэгж, 54 иргэний 186 махны дээжид эмийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээг хийж гүйцэтгэхэд хонины махны 2 дээж, тахианы махны 2 дээж, үхрийн махны 2 дээж, нийт 6 махны дээж эерэг урвал үзүүлсэн бөгөөд шинжилгээгээр эмийн үлдэгдэл илэрсэн 96 кг махыг Мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтан дор тусгай зориулалтын устгалын цэгт устгасан.	100%
143		Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	24.0	221.0 мянган м/кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн.	200.0 мянган м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийнэ.	6.0	Орон нутгийн төсөв 12.7 Малаас хүнд халдварладаг халдварт өвчнүүдийн эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газартай "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг байгуулан ажиллаж байна. Салбар дундын үйл ажиллагааг идэвхжүүлэх, аливаа гамшиг осол, халдварт өвчний үед хамтран ажиллах, мэдээллийг шуурхай солилцож байх, зоонозын халдварын тэргүүлэх чиглэлийн өвчнүүд болох шувууны томуу, боом, хачигт халдвар, галзуу, бруцеллёзын тандалтын хариу арга хэмжээний мэдээлэл солилцох зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газартай хамтран ажиллаж байна. Мал аж ахуй эрхэлдэг хуулийн этгээд болон аж, ахуйн нэгж, байгууллагуудад нэг урсгалаар мэдээлэл өгч, зоонозын халдварт өвчин болон хүнсний аюулгүй байдлын сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх тогтолцоо, мэдлэг хандлагыг сайжруулах сургалтыг аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж, нийт 90 иргэн хамрагдаж мэдээлэл авсан.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 171 мал, амьтны сэг зэмийг цуглуулан зөөвөрлөж, хогийн төвлөрсөн цэгт зориулалтын нүхэнд булж устгасан. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйтгэлийг бэлчээрийн 3520 мкв, устгалын	100%

											цэгийн 800 мкв, худаг уст цэгийн 450 мкв, агуулах зоорь, түүхий эдийн цэг 8000 мкв, 24 багийн 129 малтай өрхийн өтөг бууцны халдваргүйтгэлд 3200 мкв, хашаа хороо 28100 мкв, нийтийн эзэмшлийн 405703 мкв, нийт 449773 мкв талбайд суперкилл, хайкоп, ханконс, хлорын шохой зэрэг ариутгалын бодисоор үелүүлэн цацах аргаар хийж гүйцэтгэсэн.		
ТАВ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ													
ГАЗРЫН ХАРИЛЦАА, ХОТ БАЙГУУЛАЛТ													
5.1.Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.													
144	5.1.1.Орхон аймгийн газар зохион байгуулалтын 2021-2037 он хүртэлх 16 жилийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын дагуу мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авах	2021-2024	Аймгийн ЗДТГ ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	85.0	-	Төлөвлөгөөний 10%-ийг хэрэгжүүлсэн байна.	-	Орон нутгийн төсөв 85,0	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад Монгол улсын урт болон дунд хугацааны үзэл баримтлал, хүн амын өсөлт, үйлдвэрлэл нэмэгдэхтэй тулгуурлан боловсруулсан. Одоогийн хот суурины эдэлбэр газар доторх ашиглагдаагүй байгаа 11200.0 га газар буюу нөөц газарт газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийж үзэхэд 4013.3 га нь тохиромжтой, 3760.0 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 3426.7 га нь тохиромжгүй ангилалд байна. Жаргалант сум нь хүн амын төвлөрөл Баян-Өндөр сумтай харьцуулахад харьцангуй бага бөгөөд тус сумын хот суурингийн эдэлбэр газрын хэмжээг тэлэх боломжтой талбайг Хот тосгон, бусад суурин газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний ангиллаар илэрхийлбэл хот суурины эдэлбэр дэх суурьшил бүхий газраас 2км хүртэлх радиус дотор тохиромжтой 4078.0 га газар, хязгаарлагдмал тохиромжтой 363.1 га газар, 2-5 км радиус дотор тохиромжтой 5536.9 га газар, хязгаарлагдмал тохиромжтой 1740.9 га газар тус тус байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад 85.0 сая.төг батлагдсан. Сонгон шалгаруулалтаар “Ланд овнер” ХХК шалгаран ажиллаж аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн XI хуралдаанаар хэлэлцүүлж, нэмэлт мэдээллийг тусган ээлжит аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 22 өдрийн ээлжит XII хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан.	100%
145		Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймгийн газар зохион	2021-2024	ГХБХ БГ Сумдын ЗДТГ	БОАЖ Г ХХАА Г	-	-	84517 га	Төлөвлөгөөний 10%-ийг хэрэгжүүлсэн байна.	-		Баян-Өндөр сумын 2022 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор батлуулан цахим системд бүртгэн баталгаажуулсан. Төлөвлөгөөний дагуу төмс хүнсний ногооны зориулалтаар 9 иргэнд 6.5га	90%

		байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үе шаттай зохион байгуулах									газрыг эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 9 иргэнд 6.5га газрыг, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 130 иргэнд шинээр газар олгохоор төлөвлөснөөс төлөвлөгөөний дагуу 130 иргэнд газар олгож, 767 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 652 иргэнд 43.5 га газрыг сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн. Жаргалант сумын 2022 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулан цахим системд бүртгэн баталгаажуулсан. Төлөвлөгөөний дагуу төмс хүнсний ногооны зориулалтаар 81 иргэнд 101.23 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 55 иргэнд 52.32 га газрыг, өвөлжөө хаваржааны зориулалтаар 9 иргэнд 3.20 га эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 8 иргэнд 3.05 га газрыг, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 17 иргэнд 1.12 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 17 иргэнд 1.12 га газрыг, эзэмшүүлэх зуслангийн зориулалтаар 92 иргэнд 5.24 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 76 иргэнд 4.09 га газрыг, мод үржүүлгийн зориулалтаар 4 иргэн, аж ахуйн нэгж газарт 49.99 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 1 иргэн, аж ахуйн нэгж газарт 5 га газрыг сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн.	
146	5.1.2.Эрдэнэт хотод гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг батлагдсан стандартын дагуу хэрэгжүүлнэ.	Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж, батлуулах	2021-2024	ХБТХ ОХ ГХБХ БГ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	-	-	Хотын төвийн багуудад хаягжуулсан байна. 30%	Батлагдсан төсвийн хүрээнд	Хот суурин газрын гудамж, талбайд нэр өгөх өөрчлөх, нэрэмжит болгох саналыг боловсруулах комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2021 оны А/620 дугаар захирамжаар шинэчлэн баталсан. Комиссын бүрэлдэхүүн 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр хуралдаж Залуучуудын гудамжийг Ш.Отгонбилэгийн гудамжтай, Нацагдоржийн гудамжийг Тюряковын гудамжтай, Сүхбаатарын гудамжийг Орхоны гудамжтай, Ханддоржийн гудамжийг Кувейтын гудамжтай, Баян-Өндөрийн гудамжийг Эрээний гудамжтай нэгтгэн нэг тууш гудамж болгон нэрлэх, Эрдэнэт Булган А1001,1002 нэрийг Монгол улсын авто замын сүлжээнд зааснаар Дархан Эрдэнэтийн А1001, Эрдэнэт Булганы А1002 замын нэршлээр нь салган нэрлэх санал, хотын хэмжээнд 35 байршилд шинээр нэршил олгох, Эрдэнэт үйлдвэрийн бүс доторх зам гудамжийг нэрлэх 22 байршлыг хэлэлцэн баталсан.	50%

147		Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын ажлыг иргэд, олон нийтэд сурталчилж, зохион байгуулах	2021-2024	ХБТХ ОХ ХББЗ А ГХБХ БГ	ХЗА Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	-	-	5 багт сурталчилна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Баян-Өндөр сумын 22 багийн Засаг дарга нарт хаягжуулалтын журам болон хаягийн системийн талаар танилцуулга хийсэн. Эрдэнэт хотын гудамж, талбайн нэрийн шторкыг орон нутгийн "ETV" телевиз, www.erdenetgazar.mn цахим хуудас болон www.facebook.com/erdenetgazar олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлан ажилласан.	100%
148		Суурьшлын бүсэд газрын төлөв байдал чанарын хянан баталгааны дүгнэлт гаргах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авах	2021-2024	Аймгийн ЗДТГ ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	50.0	-	Жил бүр 5-10 га	Батлагдсан төсвийн хүрээнд	Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий 20 аж ахуйн нэгжээс 2022 онд 900 захиалгат чанарын хянан баталгааны ажил ирүүлснээс 771 иргэн аж ахуйн нэгжийн 1185,7 га газрын захиалгат хянан баталгааны тайланг баталгаажуулан 59 тайланг хянан буцаасан. https://egazar.gov.mn/ сайтад газрын цахим бүртгэл хийгддэг болсонтой холбоотой газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо өмнөх жилүүдээс өссөн байна.	100%
149	5.1.3.Газар ашиглалт, газрын төлөв байдал чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжинэ.	Газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын цэгийг сайжруулах, нэмэгдүүлэх	2021-2024	ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	-	-	7 цэг	Жилд 1-ээр нэмэгдүүлнэ.	-	Аймгийн хэмжээнд фотомониторингийн нийт 7 цэг байдгаас Баян-Өндөр суманд байрлах фотомониторингийн 2 цэг нь шинээр суурьшлын бүс үүссэний улмаас судалгааны зориулалтаар ашиглах боломжгүй болсон тул Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт ГХБХБГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 65 дугаарт албан бичгээр хүргүүлэн сүлжээнээс хасуулсан. Орхон аймгийн хувьд газар нутаг багатай учир газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын цэгийг нэмэх боломжгүй юм. Жаргалант суманд шинээр 3 цэгийг байгуулж нийт 8 мониторингийн байнгын ажиглалтын сүлжээний цэгийг байгуулаад байна. Дээрх цэгүүд нь нийт 28008.8 га бэлчээрийн газрыг хамарч байгаа бөгөөд 2022 оны 08 дугаар сарын 01-10-ны өдрүүдийн хооронд мониторингийн хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын тайланг гаргасан.	100%
150		Газар хамгаалах, нөхөн сэргээсэн ажлын гүйцэтгэлийг цахим мэдээллийн санд бүртгэх	2021-2024	ГХБХ БГ БОАЖ Г	Сумдын ЗДТГ МХГ	-	-	-	Жил бүр 5 га	-	Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт элэгдэж эвдэрч эзэнгүй орхигдсон 2.0 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж, талбайн солбицлыг байгаль орчны нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн. Жаргалант суманд 11865.5 га өвөл хаврын бэлчээрийг чөлөөлсөн мөн 482 га бэлчээрийг хашиж хамгаалж байна. Улсын төсвийн хөрөнгө	100%

											оруулалтаар Жаргалант сумын Жаргалантын энгэрт 468 га бэлчээр, Хөндлөн намгийн хойно 630 га бэлчээрийн газрыг усжуулах 2 худаг байгуулсан. Эдгээр нөхөн сэргээсэн талбай нь байгаль орчны нэгдсэн мэдээллийн санд бүртгэх шаардлагагүй талбай байна. Газар хамгаалах нөхөн сэргээх ажлыг зохион байгуулан ажиллах тухай зөвлөмжийг Жаргалант сумын ЗДТГ-т ГХБХБГ-ын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 465 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.	
151	5.1.4.Геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байр зүйн зургийг үе шаттай бий болгоно.	Геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийж, гэмтсэн болон устсан цэгүүдийн судалгааг гаргаж, нөхөн сэргээх, шинээр байгуулсан цэг тэмдэгтийг хүлээн авах	2021-2024	ГХБХ БГ	Сумд ын ЗДТГ	-	-	116 цэг	Жил бүр 2 цэг нэмэгдүүлнэ.	-	Геодезийн цэгийн үзлэг тооллогыг 2022 оны 09 дүгээр сарын 12-23-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Тооллогоор нийт 109 цэг тоолсноос 1 цэг гэмтэж, 1 цэг устсан байна. Цэг тэмдэгт гэмтээсэн болон устгасан 2 аж ахуйн нэгж байгууллагуудад нөхөн сэргээх албан бичиг хүргүүллээ. 2022 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Тэгш хэм" ХХК-аар 33 геодезийн цэгийг шинээр байгуулах ажлыг хүлээн авахаар холбогдох материалыг шалгаж өгөгдлийг геопорталд холбож бүртгэх ажил хийгдсэн. Мөн цэг тэмдэг устгасантай холбоотойгоор улсын болон орон нутгийн төсөл арга хэмжээгээр хийгдэж буй бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд ажлын зөвшөөрөл олгодог Баян-Өндөр, Жаргалант сум, Хотын захирагчийн алба, Хот байгуулалт барилга Захиалагчийн албанд цаашид анхааран, хамтран ажиллах талаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 423 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Геопортал цахим системд 116 цэг тэмдэгтийг оруулж зөвшөөрсөн төлөвт шилжүүлж, геопортал цахим системд 2 сумын 166 газар зүйн нэрийн мэдээллийг засан оруулсан байна.	100%
152		Шинэ болон хуучин суурьшлын бүсэд бага, том масштабтай байр зүйн зурагт тодруулах хийх	2021-2024	ГХБХ БГ	Сумд ын ЗДТГ ХББЗ А	Орон нутгийн төсөв	-	-	5 га	Батлагдсан төсвийн хүрээнд	Зуслангийн газрын зориулалтаар суурьшлын бүс үүсээд байгаа Баян-Өндөр сумын Баянцагаан багийн Ар булаг болон Жаргалант сумын Цагаан хустын аманд М1:1000 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг боловсруулах ажлын хүрээнд 1359 га газрын 187.0 сая төгрөгийн үнэлгээг тооцсон боловч төсвийн хэмнэлтийн хуулиар хойшлогдсон.	70%
153	5.1.5.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, газрын үнэлгээ, төлбөр, татварын системийг цахим системд хамруулах	2021-2024	ГХБХ БГ Сумд ын ЗДТГ	Татварын хэлтэс	-	-	12800 Нэгж талбар	21800	-	Газрын кадастрын программ хангамжид бүртгэгдсэн Баян-Өндөр сумын 3887 нэгж талбарт 22,751 сая төгрөгийн ногдуулалт хийж 4727 нэхэмжлэх, Жаргалант сумын 694 нэгж талбарт 51,53 сая төгрөгийн ногдуулалт хийж 696 нэхэмжлэхийг тус тус үүсгэн татварын нэгдсэн системд илгээгээд байна.	69%

	ажиллагааг нь эхлүүлнэ.											Тайлант онд орон нутгийн төсөвт газрын төлбөрийн орлогоос 21.0 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсан ба газрын төлбөрийн орлогоос хүлээгдэж буй гүйцэтгэлээр 21,957 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Дээрх төлбөрийн орлогын 187,65 сая төгрөг нь газрын төлбөрийн өр барагдуулах ажлын хүрээнд орлого төвлөрүүлсэн. Газрын үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулах ажлын хүрээнд 2022 онд 15061 нэгж талбарт газрын татварын бодолтыг хийж, Баян-Өндөр суманд 14750 иргэнд 25 сая төгрөг, Жаргалант суманд 311 иргэнд 96 мянган төгрөгийн ногдуулалт хийж нэхэмжлэх үүсгэлээ.	
154		Газрын биржийн үнийн судалгааг жил бүр гаргаж цахим системд хамруулах	2021-2024	ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	-	-	2300	3500	-		2022 онд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ шилжүүлсэн 920 нэгж талбарын үнийн мэдээг Газрын биржийн www.mle.mn цахим программд бүртгээд байна. Бүртгэсэн үнийн мэдээнд дүн шинжилгээ хийхэд Орхон аймагт гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ 7757 төг, худалдаа үйлчилгээний газрын дундаж үнэ 212028 төг, ХАА-н үйлдвэрлэлийн газрын дундаж үнэ 4184 төг байна. Цуглуулсан үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний газар 83,8 хувь нь, худалдаа үйлчилгээний газар 4,6 хувь, ХААН-н үйлдвэрлэлийн газар 3,7 хувийг тус тус эзэлж байна	100%
155	5.1.6.Гэр хорооллын багуудад "Миний гудамж-Бидний гэр", орон сууцны хорооллын багуудад "Миний орц-Бидний байшин" төслүүдийг хэрэгжүүлж зам талбай, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, камержуулалтыг үе шаттайгаар үргэлжлүүлэн шийдвэрлэнэ.	"Хашаандаа хаус" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын багуудад "Миний гудамж-Бидний гэр" төслийн хүрээнд төвлөрсөн шугам барих, ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ХББЗ А ГХБХ БГ	Орон нутгийн төсөв	8.600.0	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 431	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 180	2.800.0	Орон нутгийн төсөв 618,0	2021-2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын 7 багт инженерийн шугам сүлжээний ажил хийсэн. Булаг багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 0.9 км, цэвэр усны 0.9 км, бохирын 0.5 км, Рашаант багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 1.6 км, цэвэр усны 1.6 км, Наран багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 1.1 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.5 км, Цагаанчулуут багт бохир усны 0.8 км, Баянцагаан багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 1.0 км, Дэнж багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 0.9 км, цэвэр усны 0.9 км, бохир усны 0.3 км, Говил багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 2.2 км, нийт 14.3 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Үүний үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэж байгаа бөгөөд 113 өрх бүрэн холбогдсон.	100%
156		Орон сууцны хорооллын багуудад "Миний	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ГХБХ БГ СӨХ	Орон нутгийн төсөв	147.9	-	Аюулгүй, тохилог	Батлагдсан		Эрдэнэт ШУТП-тай хамтран "Миний орц Бидний байшин" төслийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн	30%

		орц-Бидний байшин" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх							орчин бүрдэнэ.	төсвийн хүрээнд		хурлаар хэлэлцүүлсэн. Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд төсөлд тусгасан ажилд техникийн шийдлийг тодорхойлон батлуулахаар ажиллаж байна.	
157		Орон сууц болон гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	"ЭУДТ С" ОНӨХ К	Орон нутгийн төсөв	1.550.0	9700 ш гэрэлтүүлэг	Жилд 500 ш гэрэлтүүлэг	500.0	орон нутгийн төсөв - 2250,0	2022 онд орон нутгийн 2250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 15 ажил хийгдэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл 100.0 хувьтай хэрэгжиж байна. Уг ажлын хүрээнд 279 гэрэлтүүлэг шинээр хийгдэж, 1482 ширхэг гэрэлтүүлгийн толгойг шинэчлэх, 1480 ширхэг гэрэлтүүлгийн тэжээлийн блок солих, 0.4кв-ын 70874 метр СИП кабель шинээр татах ажлыг гүйцэтгээд байна.	90%
158		Хотын камержуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ХТГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	2.000.0	30%	Нийт талбайн 40%	150.0	Орон нутгийн төсөв 407,2	Аймгийн хэмжээнд 2022 онд Баян-Өндөр сумын "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн"-д 58.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 ширхэг камер суурилуулах ажлыг "ТМ ЭТТЭ" ХХК, 4,5-р сургууль, 2, 19, 21, 7, 24, 27, Бялзуухай, Унага цэцэрлэгийг камержуулах ажлыг "Би инженеринг" ХХК 349.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 50.0 хувьтай байна.	70%
159	5.1.7.Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ.	Нарны эрчим хүчээр халдаг халаалтын систем нэвтрүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх	2021-2024	Төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоо	ХЗА Сумдын ЗДТГ	Төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	Батлагдсан төсвийн хүрээнд		Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын HISENSE VRF группийн "Сэргээгдэх эрчим хүчний нарны халуун агааран үлээлтийн системийн танилцуулга" төслийг турших үйл ажиллагааг эхлүүлээд байна. Төсөл санаачлагчтай хамтран 28кв болон 630кв цахилгаан халаалт бүхий 2 тоноглолыг Эрдэнэ багийн 11 дүгээр цэцэрлэг, Шанд багийн гудамжны айл өрхүүдэд суурилуулж туршилтыг эхлүүлсэн. Туршилтын үр дүнгээр Азийн хөгжлийн банкны Сэргээгдэх эрчим хүчний ТА9608 төслийн хүрээнд "Жишиг ногоон гэр хороолол" төслийг эхлүүлэхээр харилцан санал солилцон төсөл боловсруулж байна.	30%
160	5.2."Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040"-г шинэчлэн боловсруулж батлуулна.	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, зургийн даалгаварт санал өгөх орон нутгийн ажлын хэсгийг байгуулах	2021-2024	ХБТХ ОХ	ГХБХ БГ ХББЗ А	Улсын төсөв	-	-	Боловсруулалтын ажлын суурь судалгаа, бэлтгэл ажил хийгдсэн байна.	Улсын төсөв		"Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар"-ыг боловсруулах ажилд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас саналыг авч тусгуулан 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 2021/68 дугаартай ажлын даалгавар батлагдсан. Энэ онд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгийг улсын төсөвт тусгагдаагүй.	0%
161		Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий	2021-2024	ГХБХ БГ ХББЗ А	ХБТХ ОХ ХЗА	Орон нутгийн төсөв	15.0	-	Шинэчлэн батлагдсан багийн төлөвлөлтий	5.0		2022 онд Баян-Өндөр болон Жаргалант сумдад зохион байгуулсан 2 удаагийн "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгөөр Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Жаргалант сумын хэсэгчилсэн	100%

		төлөвлөгөөг үе шаттай сурталчлах ажлыг зохион байгуулах							йг сурталчилсан байна.			ерөнхий төлөвлөгөөний зурагт хуудас, самбарыг дэлгэн сурталчилж 520 гаруй иргэнд мэдээлэл сурталчилсан. Цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг байршуулж 2150 гаруй иргэнд мэдээллийг хүргэсэн.	
162	5.3.Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцны хорооллуудыг барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ГХБХ БГ ХББЗ А	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	-	Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцанд амьдардаг өрхийн тоо 13180 айл	Шинээр 250 айл	-	Улсын төсөв 798,3 Орон нутгийн төсөв 501,7	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Их залуу, Уртын гол багт орон сууцны цогцолбор хороолол барих аймгийн Засаг даргын шийдвэр, Цагаан чулуут багийн 49-53 дугаар гудамжийг дахин төлөвлөлтөд оруулах аймгийн ИТХ-ын шийдвэрүүд гарсны дагуу дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: - Уртын гол багт дахин төлөвлөлтөөр баригдаж байгаа 260 айлын нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усан хангамжаар хангах ус дулаан дамжуулах төвийн барилгыг гадна инженерийн шугам сүлжээний хамт барих зураг төслийг захиалан боловсруулж, улсын магадлалаар батлуулснаар орон нутгийн төсвөөс 501.7 сая төгрөг, дэд өртөө барихад 700.0 сая төгрөгийг батлан, угсралтын ажлууд гүйцэтгэж байна. - Их залуу багт дахин төлөвлөлтөөр барих нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усан хангамжаар хангах ус дулаан дамжуулах төвийн барилгыг гадна инженерийн шугам сүлжээний хамт барих зураг төслийг захиалан боловсруулж, улсын магадлалаар батлуулснаар улсын төсвөөс 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө шийдвэрлэн БХБЯ-наас хөрөнгө шийдвэрлэн гүйцэтгэгчээр “Эрингүрэн” ХХК шалгарч гэрээ байгуулсан. - Цагаанчулуут багийн 49-53 дугаар гудамжийг дахин төлөвлөлтөөр барих нийтийн орон сууцыг дулаан цэвэр усан хангамжаар хангах ус дулаан дамжуулах төвийн барилгыг гадна инженерийн шугам сүлжээний хамт барих ажилд 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай байгаагаас 2021 онд орон нутгийн төсвөөс 618.6 сая төгрөгийн дүнтэй хөрөнгийг баталж угсралтын ажлыг гүйцэтгэж байна. 2022 онд хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалтаар нийт 539 айлын орон сууц шинээр ашиглалтад орсон байна.	100%
163		Орон сууцны хорооллуудын	2021-2024	ХББЗ А	“ЭУДТ С”	Улсын болон	1.000.0	123.7км	20%	200.0	Орон нутгийн	Хотын нийтийн орон сууцууд болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг төвлөрсөн дулаан	70%

		ИШС-г үе шаттайгаар шинэчлэх		ХЗА	ОНӨХ К	орон нутгийн төсөв					төсөв 996,3	хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф700 мм-ын шугамаар өргөтгөн барихаар 2022 оны улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлын тендер сонгон шалгаруулалтаар "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан ба 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 677.0 сая төгрөг батлагдаад байна. Гэрээ байгуулах ажил хийгдсэн бөгөөд одоогоор материал татан авалт хийгдэж байна. 2022 онд орон нутгийн 117.1 сая төгрөгийн хөрөнгөөр оруулалтаар Согоот багийн УДТТ 6-4, 6-3 дугаар байрны цэвэр усны шугам шинэчлэлийн ажил хийгдэж байна. Болзошгүй аваарийн 77.2 сая төгрөгийн хөрөнгөөр Хүрэнбулаг багийн 1 дүгээр хороолол, Сөүл кастель хотхоны 3-3-р байрны халуун усны шугам, 3-2 дугаар байрны дулаан, цэвэр усны шугамын ажил хийгдлээ. "ЭУДТС" ОНӨХК байгууллагын 41.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 дугаар хорооллын 7-р байрны ИШС-г шинэчлэх ажил, 84.0 сая төгрөгийн хөрөнгөөр Төгөл гарден хотхоны гадна шугамыг шинэчлэх ажил тус тус хийгдсэн. Нийт 2022 онд орон сууцны хорооллуудын ИШС-г үе шаттайгаар шинэчлэх ажлын хүрээнд 5 ажил хийгдэж нийт 996.3 сая төгрөг зарцуулагдсан байна.	
5.4.Гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.													
164	5.4.1.Хотын бүх айл өрхийг цахилгааны 2 тарифт тоолуурт шилжүүлэн иргэдэд цахилгааны хөнгөлөлт үзүүлэх	Гэр хорооллын айл өрхүүдэд 2 тарифт тоолуур нэвтрүүлэх	2021-2023	ХЗА	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ "ЭУДТС" ОНӨХ К	Орон нутгийн төсөв	196.0	Гэр хорооллын айл өрх	-	-		2022 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн ажлын хүрээнд гэр хорооллын 9000 айл өрхүүдэд ухаалаг тоолуур угсрахад бэлэн болж одоогоор хүчний тоног төхөөрөмжийг угсарч байна.Уг төсөл 2023 оны 06 дугаар сар хүртэл хэрэгжүүлнэ.	30%
165		Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх	2021-2022	"ЭБЦТС" ТӨХК	ХЗА "ЭУДТС" ОНӨХ К	Гадаадын зээл, Улсын төсөв	1.548.620 ам.доллар	2 тарифт тоолуур-24000 ш	-	-		2021 оноос он дамжин хийгдэж байгаа Орхон аймагт Дэлхийн банкны 1.5 сая ам долларын санхүүжилтээр Баян-Өндөр сумын хэмжээнд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх ажил 55.8 хувийн гүйцэтгэлтэй байна. 2022 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн ажлын хүрээнд орон сууцны 4834 айл өрхэд 2 тарифт ухаалаг тоолуур суурилуулсан. Төслийн хүрээнд графикайн дагуу нийт 23000 тоолуурыг суурилуулна.	30%

166	5.5.Гэр хорооллын багуудын дахин төлөвлөлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам (халаалт, цэвэр бохир)-д холбож барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Дахин төлөвлөх үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ГХБХ БГ ХББЗ А	-	-	-	Төсөл хэрэгжих бэлтгэл үе шат хангагдсан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 618,6	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан. Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлт хийх тогтоол гарсан. Тус тогтоолын хэрэгжүүлэх дахин төлөвлөн барилгажуулах ажлын даалгаврыг боловсруулсан. Цагаанчулуут багийн 49-53 дугаар гудамжийг дахин төлөвлөлтөд оруулахтай холбогдуулан төлөвлөлтөөр барих нийтийн орон сууцыг дулаан цэвэр усан хангамжаар хангах УДДТөвийн барилгыг гадна ИШС-ний хамт төлөвлөн байршлын схемийг батлуулж, ажлын зураг төсөл боловсруулах техникийн баримт бичгийг боловсруулж бүрдүүллээ. Уг ажлыг гүйцэтгэхэд нийт 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай байгаагаас 2021 онд орон нутгийн төсвөөс 618.6 сая төгрөгийн дүнтэй хөрөнгийг зарцуулаад байна. Мөн Уртын гол багт дахин төлөвлөлтөөр нийтийн орон сууц барьж эхэлсэнтэй холбогдуулан дулаан цэвэр усан хангамжаар хангах УДДТөвийн барилгыг гадна ИШС-ний хамт төлөвлөн байршлын схемийг батлуулж, ажлын зураг төсөл боловсруулах техникийн баримт бичгийг боловсруулж бүрдүүлэн, ажлыг зураг төслийг захиалж улсын магадлалаар хянуулж баталгаажуулсан. Уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж шалгаруулан, ажлыг гэрээний дагуу гүйцэтгэж байна. Тус ажилд 2021 онд орон нутгийн төсвөөс 501.7 сая төгрөгийн дүнтэй хөрөнгийг зарцуулаад байна.	70%
167		Гэр хорооллын багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ГХБХ БГ ХББЗ А	Улсын төсөв	12000.0	-	3.1 км	Улсын төсөв	Улсын төсөв 1900.0 Орон нутгийн төсөв 3000.0	2021 оны орон нутгийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Миний гудамж-бидний гэр" төслийн хүрээнд Булаг багт 882м 5 хос, Зүүн дэнжид 834м 5хос, Наран багт 1160м 5хос, Цагаанчулуут багт 1972м 5хос, Баянцагаан багт 700м 5 хос, Рашаант, Баянбулаг багуудад тус бүр 1 УДХТ барих ажлууд бүгд 2022 он дамжин хийгдэж байна. Нийт гүйцэтгэл 90.0 хувьтай. Ингэснээр гэр хорооллын 972 айл өрх төвлөрсөн ИШС-д холбогдох нөхцөл бүрдэж байна. 2022 онд гэр хороололд төвлөрсөн цэвэр усны шугамд 6 айл өрх, 5 ААНБ, бохирын шугамд 1 айл өрх, 3 ААНБ техникийн нөхцөлийн дагуу холбогдсон байна.	90%
168		Баян-Өндөр сумын гэр хорооллын ус	2021-2024	ХБТХ ОХ	"ЭУДТ С"	Улс болон	3.458.8	0 өрх	20 өрх	Иргэн айл	Улсын төсөв	2022 оны орон нутгийн 878.9 сая төгрөгийн хөрөнгөөр Рашаант багт 480м 3хос, 555.0 сая	90%

		хангамж, ариутгах татуургын сүлжээг байгуулах		ХЗА БОАЖ Г ЭМГ	ОНӨХ К Сумд ын ЗДТГ	орон нутгийн төсөв				өрхийн зардлаа р	1300.0 Орон нутгийн төсөв 2800.0	төгрөгийн хөрөнгөөр Уртын гол багт 1253м 5 хос, Говил багт 1705м 5 хос, 501.7 сая төгрөгийн хөрөнгөөр Уртын гол багт 1 ширхэг УДХТ, 618.6 сая төгрөгийн хөрөнгөөр Цагаанчулуут багт УДХТ барих нийт 2.5 тэрбум төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байна. 2022 онд Барилга хот байгуулалтын яамны 2,7 тэрбум төгрөгийн хүрээнд “Түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр Ариутгах татуурга 3-р коллекторын төв шугам татах” ажлыг “Компорт импекс”ХХХ гүйцэтгэж байна. Уг ажлын нийт төсөвт өртөг 19,9 тэрбум ба Ф600мм-ийн голчтой 6,3км шугам, салбар шугам 2,5км хийгдэхээс зураг төслийн дагуу Ф600мм-ийн голчтой ариутгах татуургын шугам 3,1км-ийг угсарч, 76ш бохирын худгийг хийсэн байна. 2022 оны ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100% хэрэгжсэн. Нийт ажлын гүйцэтгэл 38%-тай хэрэгжиж байна	
169	5.6.Хотын инженерийн шугам сүлжээний дэд бүтцэд гамшгийн эрсдэлийн үнэлгээг үе шаттайгаар хийж, гэмтэл доголдол аваарыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах бодлогыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлнэ.	35/6кВ-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2х10000кВА-иар өргөтгөж цахилгааны найдвартай ажиллагааг хангах	2021-2024	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА	Улсын төсөв	3.200.0	-	35/6 кВ-ын 2х10000КВ А дэд станц	3.200.0	Ороннут гийн төсөв 2500,0	2022 онд орон нутгийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 35/6кВ-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2х10000кВА-иар өргөтгөх ажлыг “Орхон тек” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил дуусаж, тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж дууссан. Улсын комисс ажиллаж үүрэг даалгавар өгсөн тул хавар 4 сард сүлжээнд залгахаар холбогдох ажлыг зохион байгуулж байна.	90%
		Хотын гэр хорооллын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эрдэнэ багийн хабитатын хэсэгт 35кВ-ын ЦДАШ, 35/6 кВ-ын дэд станц шинээр барих	2022-2024	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА	Улсын төсөв	900.0	-	35/6 кВ-ын 2х6300КВА-н дэд станц, 35кВ-ын ЦДАШ	900.0	Орон нутгийн төсөв- 494,0	Эрдэнэ багийн Хабитатын хэсэгт 35кВ-ын ЦДАШ, 35/6 кВ-ын дэд станц шинээр барих ажлын зураг төсөл 2021 онд боловсруулагдсан. 2022 онд “ЭБЦТС” ТӨХК 370.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ багийн 35кВ-ын шугамыг барих ажлыг эхлүүлэн төмөр бетонон шон босгох ажил хийгдсэн. 2023 онд үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна. Мөн Орон нутгийн 124.0 сая төгрөгийн хөрөнгөөр хотыг 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тойруу схемд шилжүүлэх ажлын зураг төсөл боловсруулах ажлыг “Бодит чадал” ХХК гүйцэтгэж байна. Шугамын трассын нарийвчлан гаргаж зөвшилцөн холбогдогч байгууллагуудаар хянуулах ажил хийгдэж байна.	50%
171		Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дулааны шугам сүлжээнд горимын тооцоог тогтмол хийх	2021-2024	“ЭДЦ С” ТӨХК “ЭУДТ С” ОНӨХ К	ХЗА	“ЭДЦС” ТӨХК “ЭУДТС” ОНӨХК	Байгу улла гын дотоо д зохио н	-	100%	-	Орон нутгийн төсөв 95,0	2021 оны орон нутгийн 95,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хотын хэмжээнд байгаа дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийх зөвлөхөөр ШУТИС-ын судалгааны баг шалгарч ажлыг гүйцэтгэн горим тооцоог боловсруулан хүлээлгэн өгсөн. Мөн хангагч байгууллага “ЭДЦС” ТӨХК, “ЭУДТС” ОНӨХК хотын дулааны шугам сүлжээнд	100%

							байгуулалтар					жил бүр үзлэг шалгалт, горим тохируулга хийж, тухай бүр дулааны ачааллыг тооцон хэрэглэгчидэд техникийн нөхцлийг гарган ажиллаж байна. Мөн Диспетчерийн үндэсний төвөөс баталсан өвлийн их ачааллын болон хүйтэн сэрүүний улиралд мөрдөх сүлжээний усны 150/70-ын горимыг мөрдөн ажиллаж байна.	
172		Хотын шугам сүлжээнд эрсдэлийн үнэлгээг хийж цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг гаргах	2021-2024	"ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК	ОБГ	"ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК	Байгууллагын дотоод зохион байгуулалтар	-	30%	-		2021 оны орон нутгийн 95,0 сая төгрөгийн хөрөнгөөр ШУТИС-ын баг бүрэлдэхүүнээр хотын хэмжээнд байгаа дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийснээр эрсдлийн үнэлгээ хийх шаардлагагүй болж хотын дулааны шугамын насжилт, өргөтгөл шинэчлэлт хийх шаардлагатай шугам сүлжээнүүдийн тооцоо судалгаа гарсан. -Үүний дагуу 2022 онд эхний ээлжинд Дулааны цахилгаан станцаас 9 дүгээр цэг хүртэлх дулааны шугамыг /ф720 мм-ийн 3.5 км/ өргөтгөх ажлын зураг төсвийг 2021 онд "Асгат өргөө" ХХК-иар шинэчлэн батлуулсан. 2022 онд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлын тендер сонгон шалгаруулалтаар "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан ба 2022 оны улсын төсвөөс 677,0 сая төгрөг батлагдан 8 дугаар сард гэрээ байгуулж, материал татан авалт хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 30%. -Мөн Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн УДХТ хүртэлх 1,2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлын зураг төслийг "Монкузбас" ХХК гүйцэтгэсэн ба нийт төсөвт өртөг 4,3 тэрбум. Үүнээс 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 675,5 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэгчээр "Эрин гүрэн" ХХК шалгараад байна. Ажлын гүйцэтгэл 50%. Хотын хэмжээний инженерийн шугам сүлжээнд цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг хангагч байгууллага "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК тухай бүр гарган улсын төсөв, орон нутгийн төсөв, болзошгүй аваарийн зардал, өөрсдийн байгууллагын нөөц бололцоогоор шийдвэрлэн ажиллаж байна.	70%
5.7.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг салбар бүрд нэвтрүүлнэ.													
173	5.7.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн	"Ухаалаг-Эрдэнэт" төсөл хэрэгжүүлэх	2021-2022	Харилцаа холбоо,	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв	10.000.0	Шинээр эхлэх төсөл	Төслийн ажлын явц 100% . Төсөл	8.000.0		Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07-р сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан	70%

	дэвшлийг салбар бүрд нэвтрүүлнэ.			мэдээлэл технологийн газар				бүрэн хэрэгжиж дуусна.			Аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг 5 зорилт 17 арга хэмжээтэй баталсан. 2022 оны байдлаар 10 ажил хийхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 6 (Смарт Эрдэнэт платформ хийх, Баян-Өндөр сум www.bayanundur.mn , Жаргалант www.jargalant.gov.mn сумдын албан ёсны вебсайтыг хийх ажил, БОЭТ-ийн түргэн тусламжийн тасаг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч таблет нийлүүлэх ажил, Иргэдийг irgen.erdenet.mn -ээр дамжуулан санал хүсэлт, өргөдөл гомдол гаргах мөн төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл боломжоор хангах 9 багт суурин компьютер нийлүүлэх ажил, Цахим Эрдэнэт сервер нийлүүлэх ажил, Автомашины дугаар илрүүлэгчтэй камер нийлүүлэх) ажил, хэрэгжиж байгаа 3 (Эрдэнэт газар зүйн мэдээллийн системийг хийж гүйцэтгэх ажил 65 %, Шилэн кабель, худаг, сувагчлалын ашиглалтын судалгаа, топологи схем гаргах, засварлах өргөтгөх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил 40 %, Мэдээллийн аудит ажил 10%),	
174		“Цахим Эрдэнэт” хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, шинэ суурьшлын бүс захын хорооллын айл өрх, иргэдэд интернетийн үйлчилгээг ойртуулах	2021-2023	ХБТХ ОХ	“МЦХ” ХК “МХС” ХХК “МШ” ХК	Төрийн болон, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар	60.0	Суурьшлын бүс захын хорооллын айл өрх, иргэдэд интернетийн үйлчилгээ 35.9% байна.	Суурьшлын бүс захын хорооллын айл өрх, иргэдэд интернетийн үйлчилгээг 60%-д хүргэнэ.	25.0	“Монголын цахилгаан Холбоо” ХК нь Жаргалант суманд 6000 м, Говил багт 3000 м 12 корын шилэн кабель татаж ашиглалтад оруулж TV ROOM буюу гурвалсан үйлчилгээг нэвтрүүлсэн. Үүнд: Гэр хороололын, Дэнж, Говил, Баянцагаан багууд болон Жаргалант сумын нийт 593 айл өрхөд хосолсон, гурвалсан, интернэт, дан суурин гэсэн үйлчилгээг авч хэрэглэж байна. Мобинет ХХК нь Жаргалант сумын иргэдэд интернетийн voo+home үйлчилгээг нэвтрүүлж 123 айл өрх хамрагдсан. Univision ХХК-аас Баян-Өндөр сумын Баянцагаан, Уртын гол, Баянбулаг, Даваат, Дэнж багийн 3200 айл өрхөд гурвалсан үйлчилгээний сүлжээг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд А.Амарын талбайд 5G сүлжээний станцыг туршилтаар ажиллуулж эхлээд байна. “Эрд нетворк” ХХК-аас нийгмийн хариуцлагийн хүрээнд утасгүй интернетийн бүсийг үүсгэх WIFI төхөөрөмжийг А.Амарын талбайд байршуулан иргэдийг үнэ төлбөргүй интернетийн үйлчилгээг хүргэж байна. “Мобинет” ХХК нь 2022 онд Баян-Өндөр сумын 6 өрхийн эмнэлэг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрыг хөнгөлттэй нөхцлөөр интернет үйлчилгээнд холбосон. 2022 оны байдлаар суурьшлын бүс захын хорооллын айл, өрхийн 56,7 хувь нь интернет үйлчилгээг бүрэн авч байна.	95%

175	5.8.Барилга байгууламжийн ашиглалтын төлөв, газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг тодорхойлох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	2021-2024	ХБТХ ОХ МХГ	ХЗА ГХБХ БГ	Улсын болон орон нутгийн төсөв	-	Шинээр ашиглалт ад орсон 20 барилгыг паспортж уулж гэрчилгээ олгосон.	Ашиглалтад байгаа барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулах ажил эхэлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд		2022 онд шинээр ашиглалтад орсон 5 барилга байгууламжид Барилгын тухай хуулийн хүрээнд ногоон гэрчилгээ олгосон. Одоо ашиглагдаж байгаа хуучин барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, паспортжуулахад хөрөнгө шаардлагатай.	50%
ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ													
5.9.Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.													
176	5.9.1.Дэлхийн банкны төслөөр хэрэгжих Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх, гэр хорооллын багуудын гудамж хоорондын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих, цахилгааны шугамыг өргөтгөн шинэчилнэ.	Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх, гэр хорооллын багуудын гудамж хоорондын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих	2021-2022	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА “ЭУДТ С” ОНӨХ К	Гадаад ын зээл, Улсын төсөв	17.500 .0	0.4кВ-ын ЦДАШ-266.4км 2 тарифт тоолуур-24000ш Дэд станц -9 ш	-	-		2021 онд Орхон аймагт Дэлхийн банкны 1.5 сая ам долларын санхүүжилтээр Баян-Өндөр сумын хэмжээнд айл өрх, ААНБ-уудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын дагуу Суурилуулах ажил 55,8 хувьтай хийгдэж байна. Одоогоор ажлын графийн дагуу 4027ш айл өрхөд 2 тарифт ухаалаг тоолуур суурилуулсан. Мөн Дэлхийн банкны 6.98 сая долларын /19.5тэрбум/ санхүүжилтээр Баян-Өндөр сумын гэр хорооллын 16 багийн гудамж хоорондын 0.4кВ-ын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих ажлыг "РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ" ХХК гүйцэтгэж байна. Одоогоор 0,4кв-ын 6719ш бетонон шон, 144,78 км СИП кабель татагдаж,, 6/0,4кВ-ын 3ш дэд станц баригдсанаар нийт ажлын гүйцэтгэл 63%-тай болоод байна.	63%
177	5.9.2.БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр барьж байгаа “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийг МВт-ын хүчин чадалтай турбогенератора ар өргөтгөх төслийн ажлыг бүрэн гүйцэтгэнэ.	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн турбогенераторыг СС-50 МВт-иар өргөтгөх ажлыг дуусгах	2021-2022	“ЭДЦ С” ТӨХК ХЗА	ЭХЯ	Гадаад ын зээл тусламж аар	51.8 сая ам.доллар	36МВт	-	-		БНХАУ-ын Засгийн газрын 51.8 сая долларын хөнгөлөлттэй зээлээр энэ төслийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын тогтоол гарч, "Human Industrial Equipment Installation" компани тендерт шалгарч Эрчим хүчний яамтай гүйцэтгэлийн гэрээ байгуулсан. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн өргөтгөлийн ажил 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс Турбинд эргэлт өгч нэгдсэн сүлжээнд залган ажиллаж эхэлсэн. Ингэснээр "ЭДЦС" ТӨХК нь 7 зуух, 4 машинтай суурилагдсан хүчин чадал 71МВт болсон. Хэвийн үйл ажиллагаатай явж байна.	100%

178	5.9.3.Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр барьж байгаа 2А, 7А, 7, 11-р хорооллуудыг дулааны эх үүсвэрээр хангах “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-иас 9-р цэг хүртэл Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барина.	9-р цэг хүртэл Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих	2021-2023	“ЭДЦ С” ТӨХК	Эрчим хүчний яам	Улсын төсөв	3.692.0	-	-	1.000.0	2022 онд Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭДЦС ТӨХК-иас 9 дүгээр цэг хүртэлх Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих ажлын хөрөнгө батлагдсан. 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 677.0 сая төгрөг батлагдаж, 8 дугаар сард гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах ажил хийгдсэн ба одоогоор материал татан авалт хийгдэж байна.	30%	
179	5.9.4.Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжих “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийг хэрэгжүүлнэ.	“Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн хүрээнд үерийн сувгийг үе шаттай барих	2021-2023	Төслийн нэгж	БХБЯ ЕСБХ Б ХЗА ХТГ	Гадаадын зээл тусламжаар	39.900.0	Одоо байгаа Гэр хорооллын байгалийн гуу жалганы нийт 72.8км	-	-	2022 онд “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн зөвлөх үйлчилгээний компани Дани улсын “СВЕКО Дэнмарк” ХК шалгарсан бөгөөд Монголоос “Мон консалт” ХХК газар дээр 4 удаагийн үзлэг хийж зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Нийт 14,0 сая долларын хөрөнгө оруулалтаас 10,65 сая доллар үерийн хамгаалалтын далан, 3,35 сая доллар хотын инженерийн шугам сүлжээний ажилд зарцуулахаар төлөвлөөд байна	10%	
ТЭЭВЭР, АВТО ЗАМ													
180	5.10.1.Ухаалаг системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, зорчигч тээврийн	Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд төлбөрийн цахим карт нэвтрүүлэх	2021-2022	ХБТХ ОХ	АТТ	Хувийн хэвшилтэй хамтарч төсөл арга хэмжээн ий хүрээнд	500.0	0%	“Цахим төлбөрийн карт” төсөл бүрэн хэрэгжиж дууссан байна. 40%	200.0	хувийн хэвшлийн 500,0	Аймгийн Засаг дарга "Сим" ХХК-тай 2021 оны 12-р сарын 9-ний өдөр нийтийн тээврийн үйлчилгээнд Цахим картын үйлчилгээ буюу E-Pass төслийг хэрэгжүүлэхээр хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Төсөл хэрэгжих хугацаанд 36 автобусанд карт унших төхөөрөмж, спикер, 20 буудалд зарлан мэдээлэх төхөөрөмж, 21 автобусанд дэлгэц, 36 автобусанд хяналтын болон хүн тоологч нийт 72 ширхэг камер, дэлгэцийг байршуулсан. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдэд Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран 6000 ширхэг картыг олгосон бөгөөд 2 байршилд карт худалдан борлуулах, мэдээлэл өгөх түр төвийг байгуулж иргэдэд карт олгох ажлыг зохион байгуулж байна. Төслийн программ хангамж, модулийн сайжруулалт хийгдэж төсөл 100% дууссан.	100%

	үйлчилгээг үзүүлнэ.											Иргэдийг цахим картын үйлчилгээг идвэхтэй ашиглах талаар сурталчлах ажил хийж байна	
181		Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автобус парк шинэчлэлтэд дэмжлэг үзүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Хувийн хэвшил, олон улсын зээл, тусламж	зээл, тусламж	20 автобус 55.5%	8 автобус парк шинэчлэлт	зээл, тусламж	Орон нутгийн төсөв 2200,0	Нийтийн тээврийн парк шинэчлэлтэд зориулж орон нутгийн төсөвт 2,2 тэрбум төгрөгийг зарцуулж "Хьюндай моторс Монгол" ХХК БНСУ-д үйлдвэрлэгдсэн шинэ 12 ширхэг дунд оврын автобусыг 12 дугаар сарын 24 -ний өдөр бүрэн хүлээлгэн өгснөөр тус автобуснууд нийтийн тээврийн үйлчилгээнд явж эхлээд байна.	100%
182		Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийн төрлийг судлан нийтийн тээвэрт нэвтрүүлэх	2021-2022	ХБТХ ОХ	АТТ	Хувийн хэвшилтэй хамтарч төсөл арга хэмжээн ий хүрээнд	Авто замын тээврийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд	5.0	-	-		Аймгийн Авто тээврийн төвөөс нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглагдах Эко тээврийн хэрэгслийг судлах ажлын хүрээнд "Монгол машин байгууламж" үйлдвэр, "Цахилгаан тээвэр" компанийн "J-800 EV", Оросын холбооны улсын "ГАЗ" болон "КАМАЗ" "МАЗ"-ийн үйлдвэрийн Электробус зэрэг тээврийн хэрэгслийг судалсны дагуу Euro 4 стандартын шаардлагад нийцсэн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг нийтийн тээвэрт ашиглах нь зохимжтой гэж үзсэнээр БНСУ-д үйлдвэрлэгдсэн дунд оврын 12 ширхэг шинэ автобусаар нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлтийг хийлээ. Өнөөдрийн байдлаар хот хооронд болон орон нутаг, хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 458 тээврийн хэрэгслийн 226 буюу 49.3 хувь нь байгальд ээлтэй (Эко) хийн түлш хэрэглэж байна.	50%
183		Шинээр бий болж буй суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, маршрут нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Төр, хувийн хэвшил хамтарч	Хөрөнгө шаардлагагүй.	100%	Шинээр бий болсон суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэдийн ая тухтай зорчих боломж бүрдсэн байна.	Хөрөнгө шаардлагагүй		Иргэдийн санал, хүсэлтийн дагуу Аймгийн Засаг даргын 2022 оны А/86 дугаар захирамжаар "Төгөл-Вокзал" чиглэлд шинээр нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлсэн.	100%
184	5.10.2.Сурагчдын автобусны буудал болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн авто	Хотын доторх чиглэлийн нийтийн зорчигч тээвэр, сурагчдын автобусны үйлчилгээнд шаардагдах	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Орон нутгийн төсөв	460.0	75 сүүдрэвч 80%	10 сүүдрэвч 25%	115.0		2022 оны хөрөнгө оруулалтын ажилд 5 байршилд нийтийн тээврийн үйлчилгээний буудал, зогсоолыг, барьж байгуулахаар саналыг хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүй.	0

	буудал байгуулж, зорчигч	зогсоол, сүүдрэвч барих											
185	тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлнэ.	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төвлөрсөн “Орхон” авто буудлыг барьж, иргэдийг ая тухай зорчих нөхцөлөөр хангах	2021-2022	Аймгийн ЗДТГ	АТҮТ	Улсын болон орон нутгийн төсөв	-	Аймгийн хэмжээнд авто буудал байхгүй.	“АТҮТ” ТӨҮГ, Орон нутгийн төсөв	1.200.0	Улсын төсөв 1000.0	Улсын төсвийн 5,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал" баригдахаар шийдвэрлэгдсэн. 2022 онд 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдсан бөгөөд "Шинжүү" ХХК барилгын ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байна. Барилгын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй байна. 2022 онд 621 м.кв талбайн суурийг ухаж ул бетон авах ажил төлөвлөгөөний дагуу хийгдлээ. Барилгын ажил 2023 онд үргэлжлэн хийгдэнэ.	50%
186	5.10.3.Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөж, авто зам ашиглалтын үйлчилгээг сайжруулна.	Хотын доторх хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	436.5	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто зам ашиглагдаж байна.	300 м хатуу хучилттай авто зам барьсан байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв - 587,3 Орон нутгийн төсөв 6300,0	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сум багийн орчныг сайжруулах тохижилт / Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг баг/ -ийн хүрээнд 2 дугаар хорооллын 26 дугаар байрны 110 м.кв авто замыг 14,1 сая төгрөг, 3 дугаар хорооллын 22 дугаар байрны 186 м.кв авто замын өргөтгөлийн ажилд 33,7 сая төгрөг зарцуулсан байна. Гэр хороолол доторх 4 байршлын авто замын зураг төслийг “Классик роуд” ХХК 276,1 сая төгрөг, Орон сууцны 6 дугаар хороолол доторх авто замын зураг төслийг “Ихэр мөнх” ХХК 188,2 сая төгрөг, 2 байршилд авто замын уулзварыг өргөтгөх ажлын зураг төслийг “Дөрвөн тэнхлэг” ХХК 75,2 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6,3 тэрбум төгрөгөөр 12 байршилд авто зам, замын байгууламж, зогсоолын ажил хийж гүйцэтгэсэн. Үүнд: Их залуу баг 15 дугаар сургуулийн авто зогсоолоос 23 дугаар цэцэрлэгийн хажуугийн авто замтай холбох 267,4 сая төгрөг, Рашаант баг, Цагаанчулуут, Уртын гол багийн 3 замын уулзварт авто замын хурд сааруулагч, туузан хашлага хийх ажилд 29,3 сая төгрөг, Бүрэнбүст багийн Саруул болон Залуус хотхоны авто зам, шугам сүлжээний засварын ажилд 81,0 сая төгрөг, Баянбулаг, Булаг багийн нутаг дэвсгэрт ус түгээх 2 дугаар цэг хүртэлх 0.7 км хатуу хучилттай авто замын ажилд 1,3 тэрбум, Оюут баг, "Ачит" худалдааны төвөөс 2-40А байрны урдуур А1001 замтай холбох авто замын ажлыг 9,5 сая төгрөг, 11 дүгээр хорооллын Г хэсгийн авто замыг Уурхайчин хорооллын авто замтай холбох хатуу хучилттай зам /0.31км/ авто замын ажилд 447,4 сая төгрөг, Захиргааны 4 дүгээр байрны зүүн талын авто замын уулзварыг өргөтгөхөд 1,0 тэрбум төгрөг. Танил зах орчмын авто замын сүлжээг бий	100%

											болгох хатуу хучилттай авто замын ажилд /2.29 км/ 4,3 тэрбум төгрөгийн төсөвтэй авто замын засварын ажлууд хийгдсэн. Говил багт Арбулагийн хэсэгт 1786 м газарт сайжруулсан шороон замыг 189,6 сая төгрөг, Дэнж багийн Баруун дэнж 14-15 дүгээр гудамж, 15-16 дугаар гудамж, 16-17 дугаар гудамж, 17-18 дугаар гудамжнуудын дундах 1428 м газарт 65,5 сая төгрөгөөр, Цагаанчулуут багт 954 м газар 40,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сайжруулсан шороон замыг хийж гүйцэтгэсэн.Аймгийн хэмжээнд нийт 1,4 км хатуу хучилттай авто замыг шинээр барьж ашиглалтад оруулсан.		
187		Хотын доторх авто зогсоолыг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	840.0	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 69650 м.кв авто зогсоол ашиглагд аж байна.	5-6 авто зогсоолыг ашиглалтад оруулсан байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсвийн 219,2 сая төгрөг, Орон нутгийн төсвийн 384,1 сая төгрөг	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сум багийн орчныг сайжруулах тохижилт /Орхон, Баян-Өндөр, Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг баг/-ийн ажлын хүрээнд 2-1 дүгээр байранд 182 м.кв зогсоолыг 24,5 сая төгрөг, 2-5 дугаар байранд 47 м.кв зогсоолыг 10,1 сая төгрөгөөр, 2-7 дугаар байранд 203 м.кв зогсоол 24,5 сая төгрөг, 3-6, 3-7 дугаар байранд 380 м.кв зогсоолыг 46,2 сая төгрөг, 3-19 дүгээр байранд 132 м,кв зогсоол 17,4 сая төгрөг, 3-23,24 дүгээр байрны 192 м.кв зогсоолыг 20,7 сая төгрөг, 4-23 дугаар байранд 317 м.кв зогсоол 34,5 сая төгрөг, Анхны оч өрхийн эмнэлгийн 361 м.кв зогсоолыг 41,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Баянцагаан баг Төмөр замын вокзалын арын 4388 м.кв талбайг тохижуулах ажилд 304,4 сая төгрөг, 79,7 сая төгрөгөөр төв гандан хийдийн гадна 1048.5 м.кв зогсоолыг асфальт бетон хучилтаар бүрэн хучиж тус талбайд тэмдэг 1 ширхэг, 190 метрт тэмдэглэгээг хийсэн. Нийт 10 байршилд авто зогсоолыг ашиглалтад оруулсан.	100%
188		Хотын доторх авто замын нөхөөс, тэмдэг тэмдэглэгээг үе шаттайгаар хийх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	299.6	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто замын 15	5000 м.кв талбайд нөхөөсний ажил хийгдсэн байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Авто замын сангийн 500,0	Аймгийн Засаг дарга "Орхон АЗЗА" ТӨХК-тай 2022 онд Орхон аймаг Баян-Өндөр сумын доторх хатуу хучилттай авто замд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 23 байршилд 2969,7 м. кв талбайд нөхөлт, Их залуу багт 3100 у/м, Дэнж, Эрдэнэ багт 940 у/м хэсэгт авто замын тэмдэглэгээ, 10 байршилд явган хүний гарцын тэмдэглэгээ, Эрх чөлөөгий өргөн чөлөөний авто зам дагуу 50 ширхэг тэмдэгийг суурилуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Дэнж багийн авто	100%

								% -д нь нөхөөс, тэмдэг тэмдэглэгээний ажил хийгдэж байна.				замд 960 м.куб хучлагын суурийг сольж материал нэмж засварлан нөхөлтийг хийж дуусгасан. 24м.куб нүхэн эвдрэлийг хүйтэн асфальтбетоноор засварлах ажлыг 1160 м.кв талбайг халуун асфальтбетоноор бүрэн нөхөлтийг хийсэн. Хатуу хучилттай авто замын 24500 у/м хучлагын ан цав хагарал засварлах ажлыг хийж дуусгасан. Улсын чанартай А/1001 дугаартай авто замд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2 байршилд 4 сектор гэрлэн дохиог 173,3 сая төгрөгийн төсөвтэйгээр хийж гүйцэтгэсэн. Нийт авто замын 5089,7 м.кв талбай буюу 30 хувьд нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээний ажлыг 100 хувь хийсэн. Нэгдсэн 6 төрлийн маршрут, 1 видео контентыг шинэчлэн гаргаж, зурагжуулан бүх нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.	
189		“Явган зам” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	ХЗА ХББЗ А	ХБТХ ОХ	Улс орон нутгийн төсвөөс	1502.4		-	250.0		“Явган зам” дэд хөтөлбөрийн хүрээнд хотын төвийн 31 байршилд 9705 м.кв, гэр хорооллын 14 багийн нийт 17 байршилд 5548 м.кв явган хүний замын засвар шинэчлэлтийн ажил хийгдсэн. MNS 5682:2006 "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам", техникийн шаардлага, стандартын хүрээнд Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны дарга, Ерөнхий архитекторын баталсан нэг загварын зургийг батлуулан хэрэгжүүлж байна. Тус загварын зургийн дагуу аймгийн хэмжээнд явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг барьж байгуулах, засварлах ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэж байна.	100%
ЗУРГАА.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО													
6.1.Түүх, соёл, уул уурхайд түшиглэсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлсэн, цахим систем бүхий тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.													
190	6.2.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	“Хөх Монгол”, “Их шүтээн”, “Ёс заншлын өргөө” цогцолборуудын материаллаг бааз, менежментийг сайжруулж, амралтын бүс болгох	2021-2024	Аймаг, Сумдын ЗДТГ	БОАЖГ	Орон нутгийн төсөв	13.0	-	Нэгдсэн маршрут бий болсон байна.	-		Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, аймгийн Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Даян дэлхийн ногоон хөгжлийн институттай хамтран Олон улсын болон мэргэжлийн байгууллагууд, аймаг, орон нутаг, хотын төлөөлөл, хувийн хэвшил, хүүхэд, залуучуудын төлөөллийн дунд “Уур амьсгалын өөрчлөлт ба хот” чуулганыг ёс заншлын өргөөг түшиглэн зохион байгууллаа. Арга хэмжээнд оролцогчдыг хотын аялалд хамруулж, томоохон бүтээн байгуулалттай танилцууллаа.Ёс заншлын өргөөг түшиглэн ЕБС-ын сурагчдыг хамруулан	100%

											Монгол ахуй, соёл, түүх, Монгол хүний амьдралын мөн чанарыг хүүхэд багачуудад танин мэдүүлж, ойлгуулах зорилгоор "Хөдөлмөр" зуслан ажиллуулсан. "Хөдөлмөр" зусланд 46 хүүхэд хамрагдаж хөдөлмөр бүтээл ундарсан, дурсамжит долоо хоногийг өнгөрүүлсэн. "Аялал жуулчлалын цогцолбор"-ын зураг төсөл боловсруулах даалгавар, "Эрдэнэтэд тавтай морил" буюу Эрдэнэтийн угтах хаалганд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв боловсруулах даалгавар гарган батлуулж, 2023 онд орон нутгийн хөрөнгөөр зураг төсөв боловсруулахаар санал хүргүүлсэн. Нэгдсэн 6 төрлийн маршрут, 1 видео контентыг шинэчлэн гаргаж, зурагжуулан бүх нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа.	
191		Зочид буудал, жуулчны баазуудын үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх	2021-2024	БОАЖ Г	Сумдын ЗДТГ	Хувийн хэвшил	-	Зэрэглэлтэй Зочид буудал-3 жуулчны баазын тоо-1	Шаардлага хангасан байгууллагын тоо 2	-	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 22 зочид буудал, 2 амралтын газрын удирдлага, менежерүүдэд үйлчилгээний нөхөн сэргэлт, эрсдэл, одоогийн чиг хандлага сэдэвт 2 өдрийн сургалтыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 10 газарт зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Манай аймагт 3 одны зэрэглэлтэй 2, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2 зочид буудал шинээр ашиглалтад орохоор, 1 зочид буудал зэрэглэлийн стандартад нийцүүлэн засвар үйлчилгээ хийж байна. Аймгийн Засаг даргын 2019 оны А/339 дугаарт захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газартай хамтран дэн буудлын үйл ажиллагаа эрхэлж буй газруудад үзлэг шалгалт хийж, зөвлөмж, санамж, стандартын хэрэгжилтийг тогтмол ханган ажиллах чиглэлийг өгсөн. Аймгийн Засаг даргын 2019 оны А/339 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газартай хамтран 12 дэн буудлын үйл ажиллагаа эрхэлж буй газруудад 2 удаа үзлэг шалгалт хийж, зөвлөмж, санамж, стандартын хэрэгжилтийг тогтмол ханган ажиллах чиглэлийг өгсөн. Шалгалтын явцад ямар нэгэн ноцтой зөрчил илрээгүй.	70%

192	6.3.Орхон аймаг, Эрдэнэт хотын соёлын онцлогт тохирсон шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин, аялал жуулчлалаас орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.	Брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулан, гадаад, дотоодод сурталчлах, худалдан борлуулах боломжийг нэмэгдүүлэх	2021-2024	БОАЖ Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	5 брэнд бүтээгдэхүүн	Болзолт уралдаан зарласан байна.	5.0	Орон нутгийн төсөв 5.0	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих Progress төсөл хамтран "Аймгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт" дэд төслийн уралдааныг нээлттэй зарласнаас 5 бүтээгдэхүүн шалгарч үйлдвэрлэгч нарт тоног төхөөрөмж шинэчлэх дэмжлэг болох 5.0-15.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. "Эрдэнэт Шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-ын дэргэд орон нутгийн бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалах "Эрдэнэт бренд" дэлгүүрийг ажиллуулж, 30 бизнес эрхлэгчдийн 50 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалж байгаа бөгөөд "Эрдэнэт бренд" цахим хуудсыг ажиллуулж байна. Мөн "Орхон молл" худалдааны төвд инновацын дэлгүүр, бизнесийн зөвлөх үйлчилгээний цэг байгуулагдан ажиллаж байна. ITM Mongolia 2022 арга хэмжээнд орон нутгийн брэнд Артишок цайг оролцуулан, худалдан борлуулах боломжоор хангасан.	100%
193		Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн маршрутыг шинэчлэн гаргаж мөрдүүлэх, ААНБ, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих	2021-2024	ХБТХ ОХ	БОАЖ Г Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	52.0	14 чиглэлийн маршрут	Материаллаг бааз бэхэжсэн байна.	8.0	Орон нутгийн төсөв 9.0	Аймгийн нутаг дэвсгэр дээрх аяллын маршрутыг шинэчлэх ажлын хүрээнд Омогшил, М-1, Тогоочдын холбоо, Мэлмий, аймгийн аялал жуулчлалын холбоо, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран хот доторх болон адал явдалт аялалын маршрутыг гаргасан бөгөөд 5 дугаар сарын 20-нд Улаанбаатар хотоос 44 хүний бүрэлдэхүүнтэй 3 шөнө 4 өдрийн галт тэрэгний аяллыг "Сэлэнгэ" амралт аялал жуулчлалын цогцолбортой хамтран зохион байгуулж аймгийн мэдээ, мэдээллийг хүргэж, сурталчилгааг хүргэсэн. Мөн аймгийн аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн гаргаж зурагжуулж, аймгийн танилцуулга бүхий 4 минутын видео контентыг хийж гүйцэтгүүлэн нийтэд хүргэлээ. Уг арга хэмжээнд Орон нутгийн төсвөөс 9.0 сая төгрөг зарцуулагдсан.	100%
194	6.4.Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн төв цэгийг цахим хэлбэрээр байгуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ	БОАЖ Г Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв БХАХЗ	18.0	-	Цахим мэдээлэл авах боломж бүрдүүлнэ.	8.0	Орон нутгийн төсөв 18.0	Аймгийн аялал жуулчлалын мэдээ, мэдээллийг бүх нийтэд хүргэх төслийг боловсруулан веб сайт хэлбэрээр хийж гүйцэтгүүлээ. Уг мэдээлэлд зочид буудал, амралт сувиллын газар, ресторан зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут, түүхэн дурсгалт газар зэрэг мэдээллийг багтаасан бөгөөд аялал жуулчлалын танилцуулга бичлэгийг QR хэлбэрт хөрвүүлэн бүх нийтэд хүргэх ажлыг зохион байгууллаа	100%
195		Өвлийн аялал жуулчлалын материаллаг баазыг нэмэгдүүлж,	2021-2024	Аймгийн ЗДТГ	БОАЖ Г	Орон нутгийн төсөв	30.0	-	Аяллын шинэ маршрут, хөтөлбөртэ	5.0	Орон нутгийн төсөв 6.0	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 6.0 сая төгрөгөөр өвлийн аялал жуулчлалын материаллаг бааз суурийг бэхжүүлэх	70%

		дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх			Сумдын ЗДТГ				й болсон байна.			ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд "Бүх ард түмний өвлийн спортын их наадам" Орхон аймагт зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан аялал жуулчлалын болон хоол үйлдвэрлэлийн салбаруудтай хамтран зохион байгуулж, бүх нийтэд хүргэх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мөн өвлийн спортыг хөгжүүлэх хөтөлбөр, аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахаар 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган экстрим спортын барилга байгууламж, агаарын прайглайдингийн талбай, адал явдалт аялал, дугуйн замын маршрут тогтоох ажлуудыг спортын холбоодтой хамтран зохион байгуулж, санал санаачилгыг дэмжин ажилласан.	
ДОЛОО.ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ													
7.1.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.													
196	7.1.1.Металлургийн үйлдвэрлэлийн үндсэн хэсэг болох ширмийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Хувийн хэвшлийн оролцоотой ширмийн үйлдвэр байгуулах	2021-2022	Хувийн хэвшил	ХБТХ ОХ	Хөгжлийн банк	Төслийн санхүүжилтээр	Үйлдвэр байгуулах	Үйлдвэр байгуулсан байна.	Төслийн санхүүжилтээр		Үндсэн болон туслах түүхий эд (төмрийн хүдэр, кокс, шохойн чулуу, галд тэсвэртэй материал) нийлүүлэгч компаниудын судалгаа хийгдсэн. Түүхий эдийн шинж чанарын судалгааг хийж гүйцэтгэж байна. Зуухны галд тэсвэртэй доторлогоог шинэчлэн доторлосон. Агаар халаах зуухны форсунк, хий дамжуулах шугамд засвар хийсэн. Домен зуухны тоосны байгууламжийн уутан филтрүүдийг шинээр сольж, засвар гагнуур хийсэн. Зуухны хаалтуудад тосолгоо үйлчилгээ хийсэн. Зуухны фурмын нөөц бэлдэх ажил хийж шинээр 20 ширхэг фурм хийж нөөцөд бэлдсэн. Түүхий эд ачаалах автомат систем зураг төсөл хийж, угсрах бэлтгэл ажил хийгдэж байна. 2-р ээлжийн 70 м.куб Домен зуухны бүтээн байгуулалт, 70 м.куб-ийн Домен зуухны агаар халаах зуух, материал ачаалах системийн угсралт, гагнуурын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	30%
197	7.1.2."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн паркийг дэмжин байгуулна.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийг дэмжин ажиллах	2021-2024	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	ХБТХ ОХ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Төслийн санхүүжилтээр	Төслийн хэрэгжилт 50%-д хүрнэ	Төсөл хэрэгжилт 20%	-		ҮТП-ийн дэд бүтцийн ажил: -ҮТП-ийн нутаг дэвсгэрийн геоэкологийн болон дэд бүтэц авто болон төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын систем, цахилгаан хангамж, суурь судалгаа, инженер геологи, хөрсний судалгааны ажлыг 2021 онд "Инж геотех" ХХК гүйцэтгэж, тайланг 2021 оны 12 дугаар сарын 27-нд хүлээлгэж өгсөн.	30%

											Авто замын зураг төсөл боловсруулах ажлыг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан гэрээний дагуу "Ихэр мөнх" ХХК гүйцэтгэж, 2022 оны 03 дугаар сард Барилгын хөгжлийн төвөөр зураг төсвийг хянуулан батлуулсан. УТП-ийн авто замыг барих, авто замын гэрэлтүүлгийг хийх тендерийг 2022 оны 06 дугаар сард зохион байгуулсан боловч шаардлага хангах санал ирүүлээгүй тул тендерийг дахин зарласан. Дахин зарласан тендерийг 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр нээж, үнэлгээ хийсэн боловч шаардлага хангах санал ирээгүй тул уг шалгаруулалт хүчингүй болсон.		
7.2.Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.													
198	7.2.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумын ЗДТГ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	Хөнгөлөлттэй зээл олгоно.	Батлагдсан төсвийн хүрээнд	ЖДҮДС ХААҮДС 4700,0	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 аж ахуйн нэгжид 3,1 тэрбум, 53 иргэнд 1,2 тэрбум буюу нийт 4,3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2 аж ахуйн нэгжид 194,3 сая төгрөгийн, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1 аж ахуйн нэгж хамрагдаж 50.0 сая төгрөгийн зээл олгогдсон. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлд зөгийн аж ахуй, халтар арвай, мод үржүүлгийн чиглэлийн 5 аж ахуйн нэгж, 1 хоршоо хамрагдаж 230,0 сая төгрөгийн санхүүжилт авч 9 ажлын байр шинээр нэмэгдэж, 23 ажлын байр хадгалагдсан бөгөөд тайлант онд 18 аж ахуйн нэгж, 53 иргэн 4.7 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгт хамрагдсан байна.	100%
199	хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.	Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	24.0	415.5 сая төгрөгийн зээл, 513.0 сая төгрөгийн батлан даалт гаргасан.	Шаардлага хангасан төслийн тоогоор	4.0	Улсын төсөв - 4,3 ЖДҮДС-194,3 Хоршоо Г хөгжүүлэх сан - 230,0 Орон нутгийн төсөв - 50,0	Аймгийн ЗДТГ, Эрдэнэт ШУТП-Бизнес хөгжлийн төв, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэгийн-Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих "PROGRESS" төсөлтэй хамтран "Импортыг орлох бүтээгдэхүүн" цуврал сургалт болон төслийн бойжуулалт бүхий дэд төслийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зарласан. Уг хөтөлбөрт нийт 16 аж ахуйн нэгж хамрагдсанаас 10 аж ахуй нэгж өөрсдийн боловсруулсан төслөө танилцуулснаар 7.0-10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт авсан. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төслөөс 28 аж ахуйн нэгж 250.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Мэдээллийн технологийн старт-аппыг хөгжүүлэх, тэдний шинэ санал санаачлагыг хэрэглээнд нэвтрүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан	100%

											хакатоноос "Дусал Эрчим Хүч", "Bubble Laundry" өөртөө үйлчлэх угаалгын газар, "DERGED" цахим худалдааны аппликейшн зэрэг шилдэг 3 баг шалгарч тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт авсан.	
200	7.2.2.Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ.	Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	100.0	Суурь судалгаа хийгдсэн.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 40%-д хүргэнэ.	30.0	Орон нутгийн төсөв 9.9	100%
201		Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшин дээшлүүлэхэд сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, тохирлын үнэлгээнд хамруулах	2022-2024	СХЗХ	ХХАА Г Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	6.0	Шаардлага хангасан үйлчилгээнй хувь 20%	Жил бүр 10%	2.0		90%

202	7.2.3.Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.	“Эрдэнэт үйлдвэрлэл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	191.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 70%	Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. Хэрэгжилт 20%	50.0	Орон нутгийн төсөв 17.5	“Эрдэнэт Шинжлэх ухаан, технологийн парк” ОНӨААТҮГ-ын дэргэд орон нутгийн бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалах “Эрдэнэт бренд” дэлгүүрийг ажиллуулж, 30 бизнес эрхлэгчийн 50 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалж байгаа бөгөөд “Эрдэнэт бренд” цахим хуудсыг ажиллуулж байна. Тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр “Өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, тэдний бараа бүтээгдэхүүнийг Орхон аймгийн томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах, хамтын түншлэл үүсгэх зорилгоор үзэсгэлэн худалдааг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын” Спорт цогцолборт 3 хоног зохион байгуулж, 75 аж ахуйн нэгж оролцсон.	70%
203		“Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г Сумдын ЗДТГ	“ШУТ П” ХХҮГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	Хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 30%	Батлагдсан төсвийн хүрээнд		Өрхийн бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор “Өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/340 дүгээр захирамжаар байгуулж 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, төслийг батлуулахаар ажиллаж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрдэнэт ШУТП-аас “Гарааны бизнес” сургалт зохион байгуулж 20 гаруй гарааны бизнесийн санаа бүртгүүлж, үүнээс 5 төслийг шалгаруулан тус бүр 400,0 мянган төгрөгийн санхүүжилт олгож дэмжсэн бөгөөд тус төслөөс шалгарсан болон бизнес ширээгээр үйлчлүүлсэн 10 бизнес эрхлэгчдийг гадаад дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулан ахисан шатны зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	30%
204	7.2.4.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжин ажиллах	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г Сумдын ЗДТГ	ХХҮГ	Улсын төсөв болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	2.000.0	7 төсөл 330.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.	-	ОУ-ын төсөл 9.1	“Эрдэнэт хивс” ХХК нь зэрэх, нэхэх, ноос боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр эцсийн бүтээгдэхүүний тоог нэмж, шинээр 76 ажлын байр бий болгосон. “Эрдэнэт кашмер” ХХК нь 2023 онд сүлжих цехийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. “Энх-Ундрам үйлс” ХХК, “Мөнх баян алт” ХХК нь хонь, тэмээний ноос авч анхан шатны боловсруулалтаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлүүлж байгаа бөгөөд “Мөнх баян алт” ХХК нь Германы олон улсын хамтын ажиллагааны	90%

											нийгэмлэгийн GIZ, Progress төсөлд хамрагдаж хонины ноосон эсгий углааш, эсгий дотортой арьсан гутал, ажлын эсгий гутал үйлдвэрлэхээр 9.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авч тоног төхөөрөмжөө шинэчлэн бүрэн автомат үйлдэлтэй болгосноор ажлын байрыг 6-аар нэмэгдүүлэн 13 ажлын байр хадгалагдсан байна. Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "Ширмэг цүнх" ХХК нь "Хоршоо хөгжүүлэх сан"-ийн зээлд хамрагдан арьсан дээрх хөөмөл урлалын төхөөрөмж худалдан авч бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлсэн.	
205		Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тохирлын баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх	2021-2024	СХЗХ	ХХАА Г МХГ	Орон нутгийн төсөв	20.0	Нийт үйлдвэрлэлийн 20%	Нийт үйлдвэрлэлийн 30%	5.0	Аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мах, махан бүтээгдэхүүний 6, сүүний 2, гурил, тэжээлийн 3, ноос, ноолуурын 2, нийт 13 үйлдвэр ажиллаж байгаагаас сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2 аж ахуйн нэгж, гурил, малын тэжээл үйлдвэрлэгч 2 аж ахуйн нэгж, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 3, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1, нийт 8 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 24 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийн тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөхөд нь дэмжлэг үзүүлсэн. 2022 онд малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4 аж ахуйн нэгж баталгаажуулалтад хамрагдсанаас 3 аж ахуйн нэгжийн 9 нэрийн бүтээгдэхүүн стандартын шаардлагыг бүрэн хангаж "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэг эзэмшиж байна. Үүнд: "Эрдэнэт хивс" ХХК-ийн 5 нэрийн хивс, "Эрдмийт" ХХК-ийн 2 нэрийн махан бүтээгдэхүүн, "Эрдэнэт мах маркет" ХХК-ийн 2 нэрийн махан бүтээгдэхүүнүүд байна. "Эрдэнэт хивс" ХХК, "Эрдэнэт кашмер" ХХК-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний экспорт болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мах экспортлох зөвшөөрөл авсан 2 аж ахуйн нэгжийн БНХАУ, ОХУ-д экспортлох адууны махан бүтээгдэхүүнд тухай бүр нь тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгон гадаад худалдааны үйл ажиллагааг нь дэмжиж ажилласан.	100%
7.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.												
206	7.3.1.Тариалангийн нийт эргэлтийн талбайн	Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийг үргэлжлүүлэн,	2021-2022	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	240.0	Агро үйлчилгээний төвд 41.8 сая	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	120.0	Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийн хүрээнд Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас Техник дундын төвд дунд оврын тракторт тохирох бууц цацагч, байцайны үрсэлгээ суулгагч,	90%

	ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.	ашиглалтыг сайжруулан, агропарк байгуулах						төгрөгийг шийдвэрлэн LOVOL-824 трактор худалдан авсан.			бага оврын эрдэс бордоо цацагчийг нийт 55.2 сая төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өгснөөр тус төвөөс 68 иргэний төмс, хүнсний ногооны 67.3 га талбайд хагалгаа, тариалалт хийж, 24 иргэний 13 га талбайгаас төмс хурааж, 19 иргэний 54 га талбайгаас хадлан хадаж, 23 иргэний 62,13 га талбайн тэжээлийн таримлыг тармаж, 13 иргэний өвс тэжээлийг хаман боох чиглэлийн ажил хийж нийт 147 иргэний 196.5 га талбайд 5 төрлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Жаргалант сум дахь Агропаркийг түшиглэн төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай зоорь барихаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас "Төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай нэг маягийн агуулахын барилга" -ын нэгдсэн зураг төсвийг хүлээн авч орон нутгийн төсөвт шаардагдах хөрөнгийг тусган, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.	
207		Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулах	2022-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Улсын төсөв	84.0	Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 250 га талбайг хашаажуулсан.	Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.	28.0	Үр тариа, тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоог мал, тэжээвэр амьтдаас хамгаалах зорилгоор таримал ургамал тариалж буй иргэд, аж ахуйн нэгжүүд нийт 4000 орчим га талбайг түр болон байнгын хашаагаар хашаажуулж, харуул хамгаалалттай болгосон. Төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг нэгдсэн удирдлагаар ханган Бөөн бургас, Төмөр замын точик орчмын талбайн 1200 метр хашааг хувийн хөрөнгөөр сэргээн засварлах ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний 170 орчим га талбайг хашиж хамгаалсан.	100%
208	7.3.2.Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.	Усалгааны тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр худалдан авахад иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах	2022-2024	ХХАА Г ХААДС	-	Улсын төсөв болон төсөл хөтөлбөр	600.0	1 аж ахуйн нэгж 50 га талбайн инженерийн хийцтэй усалтын системийн дэмжлэгт хамрагдсан.	Аж ахуйн нэгжийг усалтын системийн дэмжлэгт хамруулна.	300.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа "Хөдөө аж ахуйг дэмжих сан"-гаас нийлүүлэгдэж буй усалтын системийн танилцуулгыг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулан ажилласан бөгөөд тайлант онд усалгааны тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах иргэн, аж ахуй нэгжийн хүсэлт ирээгүй. Мухар булан орчмын төмс, хүнсний ногооны талбайн усалгааны шуудуу, боолтыг сэргээн засварлах ажлыг 3.0 сая төгрөгийн зардлаар тариаланчдын оролцоотой хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд 72 өрхийн 90 орчим га талбайг гадаргын усалгаагаар услах боломж бүрдсэн. 2022 онд инженерийн хийцтэй худагтай 10 га талбайд хүнсний ногоо тариалж, 135 тн буюу 1га-аас 135 цн, гадаргын усалгаатай 273 га талбайд	50%

											төмс тариалж 3072 тн буюу 1га-аас 112.5 цн, хүнсний ногоо 493.2 га талбайд тариалж 5948 тн буюу 1га-аас 120 цн ургац тус тус хураан авсан.	
209		Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	600.0	Жил бүр 1000 өрхийг хөтөлбөрт хамруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 60%	150.0	Орон нутгийн төсөв 154.1	90%
											Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар тогтоолоор 2021-2024 онд хэрэгжүүлэх "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөр, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 28.5 сая төгрөгөөр 10 тонн төмсний үр, 1.0 тонн төл сонгино, 3000 ширхэг өргөст хэмхийн үрслэгээг 2 сумын Засаг даргын Тамгын газраар дамжуулан 500 өрхөд хуваариалан өгч ажилласан. 125.7 сая төгрөгөөр 120 м.кв хүлэмж 10 ширхэг, 60 м.кв хүлэмж 10 ширхэг, 48 м.кв хүлэмж 7 ширхэг, нийт 27 ширхэг хүлэмжийг хүлээн авч ирэх оны хаврын тариалалтын үеэр олгохоор бэлтгэл ханган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр хүнсний ногооны үрийн үнийг 80 хувь хөнгөлж хуваарилснаас манай аймагт 11 төрлийн 410 кг үр, 2.0 тн төл сонгино, 2.0 тн төмсний элит үр хуваарилагдсан. Тус үрийг сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан 200 өрхөд олгосон. Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд 6х20 метрийн харьцаатай нийлэг хальсан иж бүрэн 60 ширхэг хүлэмжийг Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан 60 иргэнд хөрөнгө хүлээлцэх актаар баталгаажуулан олгосон. Каритас Монгол байгууллага, аймгийн ХХААГ, Жаргалант сумын ЗДТГ хамтран ажиллах санамж бичиг байгуулж, нарны эрчмээр ажиллах 3 улирлын 480 м.кв хүлэмжийг Агропаркийн талбайд барьж ашиглалтад оруулан Жаргалант сумын 8 иргэнд гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулсан. Эдгээр ажлын үр дүнд нарлаг хүлэмж 1440 м.кв-аар, нийлэг хальсан хүлэмж 9224 м.кв-аар нэмэгдэж, 3.8 га хүлэмжийн тариалалт эрхэлж 278 тонн ургац хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацад хүлэмжийн ургац 4.7 хувийг эзэлж, өмнөх оноос 0.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
210	7.3.3.Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	30.0	-	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.	10.0		50%
											Малын удмын сангийн үндэсний төвд бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад хамрагдах хүсэлтэй 11 иргэний судалгааг хүргүүлснээр "Бог малын зохиомол хээлтүүлгийн технологич" бэлтгэх вакум сургалтад Жаргалант сумын нэг иргэн хамрагдаж, хонь,	

	малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.	арга хэмжээг зохион байгуулах									ямаанд зохиомол хээлтүүлэг хийх дадлага туршлага эзэмшсэн. Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын "Газар агро" ХХК-ийн сүү, махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлдэг эрчимжсэн мал аж ахуйн фермерийн үйл ажиллагаатай салбарын 14 ажилтан танилцаж, туршлага судалсан.		
211		Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	220.0	өвс 190 тн, тэжээл 70 тн	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.	60.0	Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор аймгийн аюулгүйн нөөцөд 30 тн өвс, 25 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 80 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээр төлөвлөснөөс аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 37.5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 118 тн өвс, 35.9 тн тэжээл, нийт 218 тн өвс, 73.4 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын аюулгүйн нөөцийг 100 хувь бэлтгэсэн.	100%	
212		Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	1.800.0	Үхрийн фермер 15, гахай фермер 1, тахианы аж ахуй 5, зөгийн 14 аж ахуйн нэгж	Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.	600.0	Орон нутгийн төсөв 129,0	2022 онд аймгийн хэмжээнд 132 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Үүнд: 19 иргэн сүүний чиглэлийн 294 толгой үхэр, 7 иргэн махны чиглэлийн 354 толгой үхэр, 1 иргэн 85 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 9 иргэн 252 толгой гахай, 81 иргэн 1298 толгой шувуу, 14 иргэн 229 бүл зөгий, 1 иргэн 7 толгой туулай тус тус өсгөн үржүүлж байна. Баян-Өндөр сумын Хоршоог хөгжүүлэх сангийн зээлд "Чамин үзэг" ХХК нь зөгийн аж ахуйн үржүүлгийг сайжруулах, ашиг шим болон бүл нэмэгдүүлэх зорилгоор 35.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас "Ижил марал" ХХК нь сүүний чиглэлийн үнээний ферм эрхлэхээр 94.2 сая төгрөгийн зээл авсан.	100%
213	7.3.4.Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана.	Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	270.0	Бэлчээрт 71 худаг ашиглагд аж, малчин өрхийн 80% усаар хангагдсан.	2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана.	90.0	2022 онд Жаргалант сумын Шувуут, Баруунбулаг зэрэг газарт бэлчээрийн 2 худгийг улсын комисс хүлээн авч ашиглалтад орсноор 43 өрхийн 8306 толгой мал буюу нийт малчин өрхийн 82.8 хувь нь усаар хангагдсан. Тайлант онд Жаргалант сумын Дулаан-Уул багийн Хөндлөн намаг, Жаргалант зэрэг газруудад шинээр 2 худаг гаргахаар судалгааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн бөгөөд 2023 онд тус 2 худаг нь ашиглалтад орох юм. Бэлчээрт байрших худаг, уст цэгийг малчдад гэрээгээр эзэмшүүлэн ажиллаж байна.	50%	

214		Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	6.0	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 30%-д хийсэн байна.	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна.	2.0	Жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногийг "Бэлчээр хамгаалах өдөр" болгон зарласантай холбогдуулан мэрэгч амьтан, шавьжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах тухай 100 гаруй гарын авлага, мэдээлэл бүхий зурагт хуудсыг малчдад тараан өгч сурталчилгаа хийсэн. Жаргалант сумын Дулаан-Уул багийн 4000 га бэлчээрийн талбайгаар үлийн цагаан оготно болон бусад мэрэгчдийн бэлчээр дэх голомт, нутгийн байрлал, тархалтын хүрээ, тоо толгой, үнэмлэхүй нягтшил, бэлчээрийн ургамалд учруулах хор хөнөөлийн хэмжээг тодорхойлох судалгааг Дулаан-Уул багийн Согоот, 18-ын карьер, Хөөвөр, Баруунбулаг, Зүүнбулаг, Хөндлөн намаг, Тугалч, Панзын далиу, Зэрэглээ, Хүүхдийн овоо, Арцатын өвөр зэрэг газруудад хийж, Хөдөө аж ахуйн цаг уурын бэлчээрийн ургамлын ажиглалтын зааврын дагуу мэрэгчид тархсан голомт нутаг, тархалтын хүрээг тодорхойлоход мэрэгч амьтдын тархалт илрээгүй ба Орхон аймгийн нутаг дэвсгэрт үлийн цагаан оготны тархац байхгүй болно.	90%
215	7.3.5.Орон нутгийн онцлогт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн цөм сүргийн малаар сайжруулна.	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх	2022-2024	ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	150.0	496 толгой хуц, ухна тоологдсоноос 81% буюу 402 толгой хуц, ухныг 3 суурьт ялган төвлөрүүлсэн.	Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.	50.0	"Малын генетик нөөцийн тухай" хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: Аймгийн хэмжээнд 670 хуц, ухна тоологдсоноос 570 толгой хуц, ухна буюу 85.0 хувийг 5 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.	100%
216		Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	24.0	35.8 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаа жуулалт хийсэн.	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртэлх хувийг хамруулна.	6.0	Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. "Малын генетик нөөцийн тухай" хууль, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн Засаг даргын 2022 оны А/189 дүгээр захирамжийн хүрээнд үржлийн малд үзлэг, ангилалт, ялган тэмдэглэгээ, бүртгэлжүүлэх ажлыг сумдын Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран	90%

											зохион байгуулан ажилласан. Энэ жил аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийж 668 толгой хээлтүүлэгч, 36332 толгой хээлтэгчийг хамруулсан. Орон нутгийн төсвөөр 2.0 мянган толгой мал, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр 3.6 мянган толгой мал, нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.		
217	7.4.Татвар төлөгчдөд чиглэсэн сургалт, зөвлөгөөг тогтмол явуулж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан сургалт, үйлчилгээг үзүүлнэ.	Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх цахим сургалтын төвийг тохижуулах	2021-2024	Татварын хэлтэс	СТСХ	Орон нутгийн төсөв	12.0	Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх цахим сургалт хийх боломж бүрдсэн байна.	Иргэд, татвар төлөгчдөд цахим сургалтын төвөөр дамжуулан 20 удаа сургалт зохион байгуулна.	0.5	Орон нутгийн төсөв 10,0	Аймгийн Татварын хэлтэс нь сургалтын танхимыг тохижуулан цахим сургалтын төвийг бүрэн байгуулж дууссан. Тус сургалтын төвийг түшиглэн, татвар төлөгчийн ангилал тус бүрийн зан хандлагад нийцүүлэн танхимаар 101, цахимаар 49 удаагийн удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор дунд сегмент 77, жижиг сегмент 448, бичил сегмент 1485, хувь хүн 11376 нийт 13386 татвар төлөгч хамрагдлаа.. Аймгийн Татварын хэлтсийн пэйж хуудас, or.mta.gov.mn вэб сайтад олон нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх зорилгоор нөлөөллийн 21 видео контент, мэдээний 592 цахим гарын авлагыг олон нийтийн сүлжээгээр давхардсан тоогоор 380018 татвар төлөгчид хүргэж 32557 лайк, 13093 иргэн хуваалцсан байна. Орон нутгийн хэвлэл мэдээллийн Тусгал, ETV, НоминHD, EBS TV, Лхатэнгэр ТВ 4 телевизэд 155, Улсын хэмжээнд МОНЦАМЭ сайт, орон нутгийн Эрдэнэт.mn, ГэрэгэТВ, Arbis.mn, Баян-Өндөр.mn,Tusgal.mn Эрдэнэт хот, erdenetnews.mn зэрэг 12 сайтаар 152, 107.1 FM радиод “Та баялаг бүтээгч” уриа дор 11 удаагийн зайн сургалт нийт 318 нэвтрүүлэг, ярилцлага, мэдээ мэдээлэл өгч ажилласан	100%
НАЙМ.НАЙДВАРТАЙ ЗАСАГЛАЛ													
“ЦАХИМ ЭРДЭНЭТ” ТӨРИЙН ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ													
8.1.Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.													
218	8.1.1.“Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагад байгаа мэдээллийг	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хүрээнд “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх	2020-2024	ТЗУХ	Холбогдох байгууллагууд	Улсын болон орон нутгийн төсөв	200.0	16%	50%	100.0		Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг мастер төлөвлөгөөний дагуу 2022 онд хийж гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авах	100%

	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас шаарддаг байдлыг зогсоож, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.										ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж гүйцэтгэл 55%-тай байна. Төрийн цахим үйлчилгээ бүхий аймаг, хот болох зорилготойгоор E-Mongolia төвийг 4 дүгээр байранд 2021 онд, Жаргалант суманд 2022 онд нээн ажиллуулж эхэлсэн.		
219		Иргэд, байгууллагууд төрийн үйлчилгээг цахимаар авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	ТЗУХ	-	Улсын төсөв	-	16%	50%	-	Орон нутгийн төсөв 21,5	2022 онд Орхон аймаг дахь И-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр нийт 83 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 38988 ширхэг лавлагаа тодорхойлолт, тусгай зөвшөөрөл зэргийг гаргаж иргэдэд Тараах материал гарын авлага тогтмол өгч ажиллаж байна. Үүнээс 4745 ширхэг төлбөртэй лавлагаа, тодорхойлолт гарган тухайн байгууллагуудын дансанд нийт 69,051,222,71 төгрөгийн орлого оруулсан дүнтэй байна. Тус онд 152 нэр төрлийн лавлагаа үйлчилгээ шинээр нэмэгдсэнээр төрийн 28 байгууллагын нийт 333 нэр төрлийн үйлчилгээг иргэд ААНБ-дад үзүүлэх боломжтой болж, төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 80-90 хувьд И-Монголиа аппликейшн суулгаж, бүртгэл үүсгэж, төвийн 70351000, 70396000 лавлах дугаарт ирсэн дуудлага бүрд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 2022 оны 08-р сард Орон нутгийн Төсвийн 21.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон аймгийн Жаргалант суманд Төрийн үйлчилгээний E-Mongolia төвийг нээн ажиллуулж эхэллээ. Энэ нь улсын хэмжээнд Хөдөөгийн суманд нээж буй Анхны төв гэдгээр ээ онцлогтой бөгөөд Жаргалант сумын иргэд, малчид, тариаланчид, орон нутгаас аа төрийн үйлчилгээг шууд авах боломж бололцоог бүрдүүлээ..	100%
220		Төрийн байгууллагуудын И-Оффис системийн хөгжүүлэлтийг сайжруулах	2021-2023	ТЗУХ	-	орон нутгийн төсөв	30.0	20.0%	80%	30.0		Төрийн байгууллагуудын албан хэргийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа И-Оффис системд хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу дотоод үйл ажиллагаанд ашиглагддаг цахим шуудан бичих, илгээх ажиллагаанд ирсэн цахим шууданг дамжуулах, хууль болон хуулийн өөрчлөлтийг нэг дороос төрийн албан хаагчид ашиглах боломжийг бүрдүүлж хуулийн сан бүхий функцийг нэмж оруулан хөгжүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна. 147 байгууллагын 1472 хэрэглэгч албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Өмнөх онтой харьцуулахад байгууллага 8%, хэрэглэгч 13%-р өссөн байна.	100%

221	8.1.2.Иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг тогтолцоог улам сайжруулна.	Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цахимаар хянах боломжийг бүрдүүлэх	2021-2023	ТЗУХ	-	Орон нутгийн төсөв	50.0	20.0%	60.0%	50.0	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг И-Оффис цахим системд бүртгэн шийдвэрлэлтийн талаар тогтмол хяналт тавин ажиллаж байна. Иргэн,мн-2022 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 13853 өргөдөл, гомдол ирсний 62 нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 13791 буюу 99,5 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн нийт өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд газрын харилцааны асуудлаар, нийтийн аж ахуйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар, татварын асуудлаар, барилгын асуудлаар болон эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаарх өргөдлүүд нийт өргөдлийн 62.3 хувь нь байна. Тайлант хугацаанд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувиар буурсан байгаа нь татварын асуудлаар ирүүлсэн өргөдөл 5.5 дахин буурсантай холбоотой байна. Ирсэн нийт өргөдлийг агуулгын хувьд авч үзвэл хог хаягдал, цахилгаан, нийгмийн даатгал, татварын асуудлаар ирүүлсэн өргөдөл 0.2 - 5.5 дахин буурсан ч, хүнс хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, нийтийн аж ахуй болон нийгмийн халамжийн асуудлаар ирсэн өргөдөл 0.2- 0.6 дахин өссөн байна.	100%
222	8.1.3.Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын зарим багуудыг хувааж шинээр баг нэмж байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.	“Багийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2020-2024	ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	260.0	-	60%	65.0	Орон нутгийн төсөв 100,0 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 22 дугаар тогтоолоор Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 2021-2024 он хүртэл үргэлжлүүлэхээр шинэчлэн батлуулсан. 2022 онд 16 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал: - Улсын төсвийн 4.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумын Зэст, Яргуйт багийн цогцолбор төвийн барилгын ажлыг үргэлжлүүлэн хийж байгаа ба ажлын явц 80-90%-тай байна. - Баян-Өндөр сумын Дэнж багт орон нутгийн төсвийн 12.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар урсгал засварын ажлыг хийсэн. -Багийн ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 52.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр, Жаргалант сумын 25 багт суурин компьютер, 31.6 сая төгрөгийн хөрөнгө	100%

											оруулалтаар Баян-Өндөр сумын 8 багийг эд хогшлоор, Жаргалант сумын Дулаан-Уул, Улаантолгой багийг суурин компьютер, 3 үйлдэлт принтерээр хангасан. - Багт ажиллагсадын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, хяналт тавих, алдаа дутагдал гаргасан албан хаагч бүртэй хариуцлага тооцон ажиллахын зэрэгцээ хэсгийн ахлагч нарын гар утасны болон бичиг хэргийн зардалд орон нутгийн төсвөөс 29.5 сая төгрөг, хэсгийн ахлагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 9.0 сая төгрөгийг зарцуулсан. Нийт багуудын хэмжээнд бодлого хөтөлбөр, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, захиргаа хүний нөөц, албан хэрэг хөтлөлт зэрэг бүхий л үйл ажиллагааг хамруулсан "E-Office" онлайн системийг бүрэн ашиглаж байгаа бөгөөд мэдээллийн аппикейшн, веб сайтыг ашиглаж мэдээлэл сурталчилгааны сан бүрдүүлэх, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, нийт багууд нэйж хуудсаараа дамжуулж мэдээлэл солилцох ажлуудыг хийж байна. Багийн үйл ажиллагаанд иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд иргэдэд төр засгийн бодлого, нутгийн хурал, захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр, бусад мэдээллийг хэсгийн ахлагчдаар дамжуулан давхардсан тоогоор 6000 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төв, багийн ажлын алба хамтран цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж санал солилцон, ажлаа эрчимжүүлэх чиглэлээр хамтран хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг хамтарсан төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж байна. 2022 онд Цахим Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах зорилгоор irgen.erdenet.mn вэб системийг шинээр нээж нийт багууд дээр зохион байгуулалтын ажлуудыг хийсэн. Үүний үр дүнд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх боломж бүрдсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

											Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих ажлын байр бий болгох, ажлын байранд иргэдийг зуучлах, хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр бизнес эрхлэх хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлттэй зээл олгох, өрх бүрийг хашаандаа мод тарих, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд иргэдийн оролцоотойгоор зохион байгуулан ажиллаж байна. 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьтай хэрэгжиж байна.		
223		Хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын зарим багийг хувааж, баг нэмж байгуулах асуудлыг шийдвэрлэх	2021-2023	ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	2.500.0	-	60%	1.000.0		Аймгийн ИТХ-ын 2022 оны Ээлжит VIII дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын Эрдэнэ багийг хувааж Чингэл, Яргуйт багийг хувааж Баян-Овоот, Цагаанчулуут багийг хувааж Найрамдал, Чандмань багуудыг шинээр байгуулсан.	100%
224	8.1.4.Иргэдийн санал, хүсэлт, санаачилгыг дэмжин бүртгэх, хүлээн авах, бодлого шийдвэрт тусгах нэгдсэн цахим платформ бий болгоно.	Нэгдсэн платформтой болох	2022-2024	ХЗА ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	80.0	-	55%	70.0	Орон нутгийн төсөв 64.8	"Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлт, шийдвэрлэлтийн явц хэрхэн явагдаж байгааг иргэдэд нээлттэй ил тод байхаар нэгдсэн платформын техникийн тодорхойлолтыг боловсруулж зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт хийгдсэн. 2022 оны 10 дугаар сард иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах irgen.erdenet.mn вэб системийн нээлтийг хийж ашиглаж эхлээд байна. Уг системд Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд өргөдөл гомдол санал хүсэлтийг нийтэд ил тод, нууцад хамаарах өргөдөл гомдол санал хүсэлтийг зөвхөн өргөдөл гомдол санал хүсэлт гаргагч иргэнд өөрт харагдахаар зохион байгуулагдсан ба Windows, Mac, android, iOS аль ч үйлдлийн системийн орчинд ажилладаг байхаар веб программчлалын html, php, javascript хэлүүдийг ашиглан бичигдсэн бөгөөд цаашид өргөжүүлэн хөгжүүлэх бүрэн боломжтой систем болсон.	100%
ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА													
8.2.Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавхийг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.													
225	8.2.1.Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийн	Аймгийн хэмжээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, дүгнэх системийг бий	2021-2022	ТЗУХ	-	Орон нутгийн төсөв	65.0	-	100%	-		Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зохион байгуулалтын	100%

	гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх системийг үлгэр жишээ хэрэгжүүлнэ. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга	болгож И-Оффис системд холбох									нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг программ хангамж ашиглан түргэн шуурхай, хялбар байдлаар төлөвлөх, тайлан гаргах, хяналт үнэлгээ хийж, үйл явцыг автоматжуулах программ хангамжийг И-Оффис цахим системд холбосон бөгөөд программ хангамжийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Төрийн захиргааны байгууллагууд Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зохион байгуулалтын нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна.	
226	хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохион байгуулалтын арга хэмжээ авах	2020-2024	ТЗУХ	Нийт төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжү үд	-	-	30%	75%	-	Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдад иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож дүгнэж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/122 дугаар захирамжаар Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газар, 23 захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх Ажлын хэсэгт ажиллан Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан.	100%
227	8.2.2.Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт,	Хүний нөөцийн программыг цалингийн нэгдсэн системтэй холбох ажлыг хийх	2020-2021	ТЗУХ СТСХ	-	Орон нутгийн төсөв	167.0	20%	100%	-	Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэх сургагч багшаар бэлтгэгдсэн 5 багш баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн болон Баян-Өндөр, Жаргалант сумдын нийт 96 байгууллагын хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг хянан явцын засвар өөрчлөлтийг байгууллага, албан хаагч бүрээр хийж өгч, ажилтан, алба хаагчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний шинэчлэлтийг бүрэн хийлгэж гүйцэтгэсэн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын цалингийн нэгдсэн систем нь	100%

	хэрэгжилт, хяналтыг сайжруулна.										нууцын зэрэглэлд байдаг тул тус системд хамрагдаагүй болно. Сургалтыг төлөвлөгөөний дагуу байгууллагын цалингийн загвар үүсгэх, цалингийн загварт багануудын үзүүлэлтийг зөөвөрлөн байршуулж хадгалах, ур чадварын нэмэгдлийг тооцож оруулах, амралтын цалин бодох, цалингийн түүх оруулах, цалингийн суутгал тохируулж хийх, кодын блок үүсгэх, Хүний нөөцийн нэгдсэн сангийн системд цалингийн сүлжээний зэрэглэл, шатлал өөрчлөх, алба хаагчийн цалингийн мэдээллийн өөрчлөлтийг татах, цалингийн загварт шинээр нэмэгдэл болон суутгал нэмж оруулах, ээлжийн амралт хэрхэн тооцох, загвар файл хэрхэн үүсгэх, зэрэг зааврыг өгч ажиллаж байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн систем болон Хүний нөөцийн удирдлагын системийг Орхон аймгийн төсвийн байгууллагын хэмжээнд 100 хувь хамруулж ажилласан.		
228	8.2.3.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг тухайн байгууллагуудын жил бүрийн төлөвлөгөөнд тусган шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	2020-2024	ТЗУХ	Төрийн байгууллагууд	Улсын болон орон нутгийн төсөв	-	20%	40%	-	Улсын болон орон нутгийн төсөв 1812,3	Төрийн байгууллага бүр албан хаагчдыг дэмжих нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. Төрийн байгууллагууд албан хаагчдын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулан, ажлын байранд ариутгал халдваргүйтгэл хийж, ажлын хэвийн горимыг уян хатан байдлаар тогтоож, шаардлагатай тохиолдолд дайчлах татан оролцуулах алба хаагчдийн шинэчлэн судалгааг гарган үүрэгжүүлж тэдгээрийн хувцас хэрэглэл, ажлын хувцас, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, нэг удаагийн хувцас хэрэглэлийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлаар захиргааны байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны санал, танилцуулгыг төрийн захиргааны 15 байгууллагаас хүлээн авч судлан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүлээсэн үүргээ "Хангалттай сайн" биелүүлсэн ахлах түшмэл 8, дэс түшмэл 71, туслах түшмэл 12 бүгд 91 төрийн жинхэнэ албан хаагчдад	90%

											төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох ажлыг зохион байгуулсан. Төрийн албыг бэхжүүлэх, чадавхижуулах чиглэлээр орон нутагт төрийн албан хаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах, сурах боломжийг бүрдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2022 оны 13/05 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулсан. 2022 онд албан ажил үүргээ гүйцэтгэгч байгаа 677 төрийн албан хаагчид албан томилолтод 151.5 сая төгрөг, албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн зардалд 32 төрийн албан хаагчид 3.1 сая төгрөг, хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөрт 1204 төрийн албан хаагчид 985. 4 сая төгрөг олгосон бол өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 96 төрийн албан хаагчид 1.649.8 сая төгрөг, орон байраар хангагдахад дэмжлэг үзүүлж 30 төрийн албан хаагчид 600.0 сая төгрөг, давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдсан 22 төрийн албан хаагчид 53.2 сая төгрөг, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны 29 албан хаагчид түүний зөвшөөрснөөр 19.1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал тус тус олгосон байна.	
229		Төрийн албан хаагчдыг богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар төрөл бүрийн хэлбэрээр хамруулах	2020-2024	ТЗУХ	Төрийн албаны салбар зөвлөл	Улсын болон орон нутгийн төсөв	145.0	10.0	50%	35.0	Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 26, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 54, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 9 , эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 2, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл” цахим зайн сургалтад 10, “Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг” сэдэвт сургалтад 9, “Төсвийн хөрөнгө оруулалт, үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ” сэдэвт богино хугацааны зайн сургалт болон “Орон нутгийн хөгжлийн стратеги, бодлогын төлөвлөлт, зохицуулалт” сэдвээр богино хугацааны танхимын сургалтад 4, Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо” сэдэвт сургалтанд 1, Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "Алсын хараа 2050 сэдэвт богино хугацааны зайн ажлын байран дахь	100%

												сургалтыг аймгийн ЗДТГ болон аймгийн ИТХ-ын төрийн албан хаагч нийт 8, “Системт сэтгэлгээ”, “Дизайн сэтгэлгээ”, “Зан үйлийн нөлөөлөл” зэрэг зайн болон танхимын сургалтанд 135 төрийн албан хаагчийг тус тус хамруулан суралцах явцад хяналт тавин ажилласан. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын чиглэлээр тусгагдсан. Төрийн албаны зөвлөл, “Мерит” төслөөс хамтран “Хувь хүний хөгжил”-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтыг 33 удаа цахимаар зохион байгуулагдан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, агентлагуудын хүний нөөцийн ажилтан, аймаг, сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга нар нийт давхардсан тоогоор 2216 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан. Тайлант хугацаанд Засгийн газрын зорилтот сургалтад 8 төрийн албан хаагч, төрийн албаны зөвлөлийн арга зүйн сургалталд 2216 төрийн албан хаагч, Удирдлагын академийн богино хугацааны зорилтот сургалтад 135 албан хаагч, мэргэжлийн бусад байгууллагын сургалтад 3668 төрийн албан хаагч нийт давхардсан тоогоор 6119 төрийн албан хаагч хамрагдсан байна.	
230	8.2.4.Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог нэмэгдүүлнэ.	Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг байгуулан ажиллах	2021-2024	ХШҮХ НБХ АОЭХ ОАҮЭ Х	ХХҮГ МХГ	Үйл ажиллагааны чиглэлээр	-	2019-2020 оны хамтын хэлэлцээрийн хэрэгжилт 92.6%-тай байна.	Хэлэлцээрийн хэрэгжилт 90%-тай байна.	-		Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 13 зүйл заалтын 80 арга хэмжээ тусгагдаж байсан бол 2023-2024 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 13 зүйл заалтын 90 арга хэмжээг тусган батлуулахаар ажиллаж байна.. 2022 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээр урьдчилсан байдлаар 91,4 хувьтай хэрэгжиж байна. Мөн аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2024 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган гурван талт байнгын хорооны даргаар батлуулан албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд зориулсан гарын авлага болгон хэвлүүлж тараахаар ажиллаж байна.	90%
231		Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагуудтай	2021-2024	ХБТХ ОХ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсви	2020 онд 28 ТББ 87.0 сая	12 чиг үүрэгт хамаарах	Батлагдсан	Орон нутгийн	2022 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас ТББ-уудтай гэрээ байгуулахад 60.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс, нэгжээр	100%

		гэрээ байгуулан хамтран ажиллах					йн хүрээнд	төгрөгийн гэрээ байгуулсан	үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	төсвийн хүрээнд	төсөв 58,0	хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 онд нийт 18 ТББ-тай гэрээ байгуулж 58.8 сая төгрөг зарцуулаад байна. Чиг үүргийн хувьд хэрэглэгчийн эрх ашгийн төлөө, хоршоо хөгжүүлэх, байгаль экологийн, хүнсний аюулгүй байдал, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг, үнийн асуудал зэрэг 9 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж байна.	
АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ ХОТ													
8.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.													
232	8.3.1.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах	2021-2024	ХЭЗХ	МШУТ	Орон нутгийн төсөв	361.5	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	54.0		Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолоор "Мэдээлэл шуурхай удирдлагын төв"-ийг байгуулан явуулж байна. Орон нутгийн төсвөөр 2021 онд 31,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төвийн өрөөний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах болон өрөөний шилэн тусгаарлалт хийх, Баян-Өндөр ууланд суурилуулах камерын дамжуулах станц, холбогдох тоног төхөөрөмж худалдан авах ажлууд хийгдсэн. 2022 онд 90,0 сая төгрөгөөр камерын засвар үйлчилгээ хийхэд ашиглах тусгай зориулалтын /автовишка/ машин худалдан авах ажиллагаа зарлагдсан боловч гүйцэтгэгч шалгараагүй тул уг зардлыг 2023 оны төсөвт шилжүүлэн батлуулсан. 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан болно	70%
233	удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Хотын гудамж, зам талбайн камержуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2021-2024	ХЭЗХ	МШУТ ЦГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Ажиллаж буй камерын тоо 183	Камерын тоог нэмэгдүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 338.4	2022 онд ажиллахгүй байгаа камеруудыг засварлах, солих ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 338,4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгаж батлуулсны дагуу бараа материалыг 100% нийлүүлж, камеруудыг шинэчлэн засварлах ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант багт 43 ширхэг камерыг хүлээж авч төвийн камерын нэгдсэн системд холбосон. Орон нутгийн 80,0 сая төгрөгийн төсвөөр дугаар илрүүлэгчтэй 8 ширхэг камерыг шинээр суурилуулах ажил хийгдсэн. Ингэснээр тайлант хугацаанд "Мэдээлэл шуурхай удирдлагын төв" УТҮГ-т бүртгэлтэй нийт 574 хяналтын камер байгаагаас 487 хяналтын камер хэвийн ажиллагаатай байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 450 иргэн, 60 цагдаагийн ажилтны хүсэлтээр камерын бичлэгийг шүүж 20.0 гаруй сая төгрөгийн хохирлыг барагдуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлгөөний аюулгүй байдал,	90%

											тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4.8 хувиар буурсан байна.		
234	8.3.2.Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байр байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.	Түр хамгаалах байрыг байгуулах	2021	ХЭЗХ ХБТХ ОХ	ГБХЗ ХГ ЦГ ЭМГ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-	Түр хамгаалах байрыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллуулж, хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг үзүүлж, энэ онд нийт 32 иргэн /үүнээс 24 хүүхэд/-ийг түр хугацаагаар хамгаалалтад авч дээрх үйлчилгээг үзүүлээд байна. Шинээр стандартад нийцсэн хамгаалах байрны төсөл боловсруулан газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг боловсруулж, 2020 онд улсын төсвийн 400,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажил эхлүүлсэн бөгөөд 2021 онд улсын төсөвт 929,0 сая төгрөг батлагдаж барилгын ажил 75,0 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	90%	
235	8.3.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	30.0	-	Урьдчилан сэргийлэх ажлын хамралтын хувь нэмэгдсэн байна.	7.0	Орон нутгийн төсөв 5.0	2022 оны 01 сард аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сан, эм ханган нийлүүлэх газруудад хяналт шалгалт хийх удирдамжийг Аймгийн Засаг даргаар батлуулж, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газруудтай хамтран хяналт шалгалт хийж бүртгэл судалгааг шинэчилсэн. Аймгийн хэмжээнд эм ханган нийлүүлэх байгууллага 12, эмийн сан 65, мал эмнэлэг 5 нийт 82 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа ба дээрх эмийн сангуудад Эрүүл мэндийн сайдын 2015 оны 68 дугаар тушаалаар батлагдсан Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдан борлуулдаг эмийн сангуудаар өвчний учир эмчийн хяналтад мансууруулах эм хэрэглэдэг 81, сэтгэцэд нөлөө эм бэлдмэл хэрэглэдэг 150 иргэдийн судалгааг гарган эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. 2018-2022 онд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 52 иргэнийг, 2 буюу түүнээс дээш гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 6 иргэнийг бүртгэл судалгаанд авч урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулсан. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, өнөөгийн нөхцөл байдал" сэдвээр Цагдаагийн газрын 159 албан	100%

											хаагчид сургалт явуулж, иргэдийн хандалт ихтэй 10 фэйсбүүк хуудасны админтай хамтран ажиллаж хар тамхи, мансууруулах бодисны хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвшөөрөгдсөн видео бичлэг, шторк зэргийг сар бүрийн 15-ны өдөр байршуулан иргэдэд түгээсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 36.4 хувиар буурсан байна.		
236		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх зорилгоор зориулалтын шаардлага хангасан тестийг үйл ажиллагаандаа ашиглах	2022-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	9.0	-	Гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулсан байна.	3.0	Орон нутгийн төсөв 3.0	Орон нутгийн 3,0 сая төгрөгийн төсвөөр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ашигладаг зориулалтын шаардлага хангасан 100 ширхэг тестийг худалдан авч, 2022 онд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон 3 холбогдогчтой 2 гэмт хэргийг илрүүлсэн байна.	100%
237		Мансууруулах төрлийн ургамлыг устгах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	31.0	-	Ургамлын тархцын хэмжээ багассан байна.	8.0	Орон нутгийн төсөв 8.0	Аймгийн Прокурорын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран аймгийн нутаг дэвсгэрт ургасан зэрлэг олсны ургамлын тархалтыг судлан тогтоож, "Устгал-2022" нэгдсэн арга хэмжээг зохион явуулах төлөвлөгөөний дагуу нийт 150 орчим га талбайд ургасан зэрлэг олсны ургамлыг хор цацах, гараар түүх, хадах аргаар устгаж ажилласан.	100%
238	8.3.4.Ял эдэлж буй иргэдийг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нөхцөл боломжийг хангана.	ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хөдөлмөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	2021, 2024	ХЭЗХ ШШГГ	-	Орон нутгийн төсөв	75.0	-	-	-	Орон нутгийн төсөв 60.0	Орон нутгийн төсвийн 59.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ШШГГ-ын үйлдвэрлэлийн мужаан цехийн хэсэгт шаардлагатай хөрөө, токарын машин, тавцантай өргөх подъяём, компрессор зэрэг нийт 9 нэр төрлийн 11 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлснээр хоригдлуудыг ажлын байраар ханган ажиллаж байна. Аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн Мужаан, модон эдлэлийн багш 15 хоригдолд мужаан модон эдлэлийн чиглэлээр 30 цагийн багц сургалтыг зааж, мэргэжлийн чиг баримжаа олгосон. 2022 онд мужаан цехэд тогтмол 10-15 хоригдлыг ажиллуулан сийлбэртэй гэр, цаг, шатар, эмээлийн тавиур, морин хуур, бусад бэлэг дурсгалын зүйлс, гар урлал, суран эдлэл, хазаар ногт, чөдөр зэргийг үйлдвэрлэж 5.4 сая төгрөгийн цалин хөлс бодож	100%

												үүнээс 70 хувь буюу 3.7 сая төгрөгийг хоригдлын нийгэмд учруулсан төлбөрт шилжүүлж, 30 хувь буюу 1.7 сая төгрөгийг хоригдлын нэрийн дансанд шилжүүлж ажилласан.	
239	8.3.5.Үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, иргэдэд архивын баримтын лавлагаа мэдээллээр шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалт, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх	2022-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 21,0	Орон нутгийн төсвийн 21.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар архивын баримтын бүртгэлийн ухаалаг тоологчийн соронзон чип худалдан авч нийт 14,0 мянган хадгаламжийн нэгжийг кодлон тооллогын программд холбоод байна.	100%
240		Архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Цахимжуулалтын хувь 20%	Цахимжуулалтын хувь 35%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 18,3	"Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 18,3 сая төгрөгийг тусган батлуулснаар 2 архивч операторчийг нэмж нийт 4 гэрээт ажилтан архивын баримтыг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна. Тайлангийн хугацаанд 28 хөмрөгийн 33 дансны 1066 хадгаламжийн нэгжийн 81728 хуудас баримтыг нягтлан шалгаж, сканердаж, цахим хувь үүсгэсэн. Үүнээс 16 хөмрөгийн 25 дансны 904 хадгаламжийн нэгжийн 76282 хуудасны 163727 хүний нэр, 23519 байгууллагын нэр, 3825 газар зүйн нэр, 20832 заалтыг архивын AMS болон E-DOC программд шивж цахим холболт хийн мэдээллийн сан үүсгэн лавлагаанд ашиглаж байна. Байнга хадгалах баримтын цахимжуулалтын ажил 35,0 хувийн гүйцэтгэлтэй байна.	100%
241		Архивд хадгалагдаж буй баримтыг сэргээн засварлах лаборатори байгуулах	2022	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	5.0	-	Лабораторийг байгуулсан байна.	5.0	Орон нутгийн төсөв 8,0	Архивын баримтыг сэргээн засварлах лаборатори байгуулахад зориулж 5,0 сая төгрөгийг 2022 оны орон нутгийн төсөвт тусган батлуулж, зориулалтын ширээ, багаж хэрэгслээр хангагдсан. Архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа байнга хадгалах баримтын 920 хадгаламжийн нэгжийн 53250 хуудас баримтад нягтлан шалгалт хийж, сэлбэн засч, хавтас, хамгаалалтын хайрцгийг шинэчилсэн	100%
242		Архивын байр барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	2021-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Байрыг барих хөрөнгийг шийдвэрлүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд		Архивын зориулалтын барилга, өрөө тасалгаанд тавигдах шаардлага, стандарт шинээр батлагдсаны дагуу стандартад нийцсэн барилгын зураг төсвийг хийлгэх хөрөнгийг 2023 оны төсөвт тусгахаар саналаа хүргүүлсэн боловч аймгийн ИТХ-ын хуралдаанаар дэмжигдээгүй.	0%

243		Архивын баримтын бүртгэлийн UF TAG систем, соронзон кодын бүртгэл, баримтын цахим ухаалаг тоолох систем нэвтрүүлэх	2022	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	30.0	-	Бүртгэлийн цахим системийг нэвтрүүлсэн байна.	30.0	Орон нутгийн төсөв 21,0	Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтыг гараар тоолох ажиллагаанд автоматжуулалт нэвтрүүлэх, мөн баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилготой цахим бүртгэлийн RFID USB уншигч төхөөрөмж болон шошгыг 2021 онд 5,0 сая төгрөгөөр авч 900 хадгаламжийн нэгжийг кодлох ажлыг эхлүүлсэн. 2022 оны хөрөнгө оруулалтаар архивын баримтын бүртгэлийн ухаалаг тоологчийн соронзон чипийг худалдан авч байнга хадгалах нийт 14,0 мянган хадгаламжийн нэгжийг кодлон тооллогын програмд холбоод байна.	100%
244	8.3.6.Зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол түүнээс үүдэх хор уршгийг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ.	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	БШУГ ГБХЗ ХГ	Орон нутгийн төсөв	1.003.0	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 60%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 5,5	Аймгийн хэмжээнд 2021-2024 онд хэрэгжүүлэх 3 зорилт 24 арга хэмжээ бүхий “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор 2022 онд орон нутгийн төсвөөр авто замыг шинээр барих, өргөтгөх, зогсоолуудыг шинээр барих, өргөтгөхөд 3,9 тэрбум, авто замууд дээр хурд сааруулагч, хаалт, хашилт, замын тэмдэг тэмдэглэгээ хийх, засвар үйлчилгээ хийхэд 529,5 сая, зам, уулзварыг гэрлэн дохиотой болгоход 190,3 сая, гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, засварлахад 1,9 тэрбум нийт 6,6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт тусгаж хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн. Орон нутгийн төсвөөр нийт 40 олон нийтийн цагдаа ажиллуулж байгаагаас 7 ажилтанг замын хяналт, шалгалт, хөдөлгөөн зохицуулалтанд ажиллуулж байна. Орон нутгийн төсвийн 338,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ажиллахгүй байгаа камеруудыг засварлах ажил хийгдэж байна. Урьдчилан сэргийлэх чиглэлээр “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Зөвийг хэвшүүлье”, “Уусан бол бүү жолоод”, “Гар утас” зэрэг нийт 3 нэгдсэн арга хэмжээ болон 12 хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, 65 аж ахуйн нэгж, байгууллагад 104 удаагийн сургалтад 3000 гаруй хүн хамрагдсан байна. 2022 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 82.3 хувьтай байна.	100%
245	8.3.7.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан	Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих, урьдчилан	2021-2024	ХЭЗХ ЦГ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	27.0	Гэмт хэргийн тоо 197	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн	7.0	Орон нутгийн төсөв 17.0	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл хяналтыг эрчимжүүлж, 21:00-01:00 цагийн хооронд	70%

	сэргийлэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээг үйлчилгээг сайжруулна.	сэргийлэх ажлыг эрчимжүүлэх							бууралтын хувь 5%			хөдөлгөөнт болон явган эргүүлийн 12-15 чиглэлд 25-30 алба хаагчийг тогтмол ажиллуулж байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчин гар дээрээс болон насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл худалдан борлуулсан 60 зөрчил илрүүлэн 44 иргэн, 16 хуулийн этгээдэд Зөрчлийн тухайн хуулийн дагуу арга хэмжээ авч, 194 литр согтууруулах ундааг хураан авч аймгийн орон тооны бус комисст шилжүүлсэн. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Төрийн бус байгууллагатай хамтран архины хор уршгийн талаар 2 удаагийн уулзалт, сургалт зохион байгуулж 300 гаруй иргэн хамрагдсан. Цагдаагийн газраас согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан эргүүл, шалгалтыг 21 удаа явуулж, албан мэдэгдлийг 604 аж ахуй нэгж байгууллагад өгч, мэдэгдлийн хариуг 359 аж ахуй нэгж байгууллагаас хүлээн авч биелэлт үр дүнг тооцсон, "Зөвийг зөвлөө" арга хэмжээний хүрээнд иргэд олон нийтэд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн уриалга, зөвлөмжийг 800 ширхэг, хулдаасан самбар 2 ширхэг зэргийг хэвлүүлэн, 18 шторк, видео мэдээлэл, 21 зурагт постер зэргийг иргэд олон нийтэд түгээсэн. Согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхэлдэг 35 иргэнд сургалт зохион байгуулж, 3 төрлийн уриалга, зөвлөмж, мэдэгдэл өгч ажилласан. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 399 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40.2 хувиар буурсан байна.	
246		Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээг сайжруулах, албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЭЗХ ЦГ	ЭМГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	Хамрагдсан хүний тоо 20	Шаардлагатай иргэдийг эмчилгээнд хамруулах	5.0	Орон нутгийн төсөв 3,0	Архины архаг хэрэглээтэй иргэдийг албадан эмчлэх зардалд шаардагдах 3,0 төгрөгийг орон нутгийн төсөвт тусган шүүхийн шийдвэрийн дагуу 19 иргэнийг эмчилгээнд хамруулаад байна.	100%
247	8.3.8.Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник тоног	Хуулийн байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг	2021-2024	ХЭЗХ	ЦГ ШШГГ ШША УБХ МШУТ	Орон нутгийн төсөв	1.864.0	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр	460.0	Орон нутгийн төсөв 1252,1	Хуулийн байгууллагуудын хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр 40 олон нийтийн цагдаа ажиллуулахад 271.6 сая, Улсын бүртгэлийн хэлтэст 4, Архивын тасагт 2 гэрээт ажилтан ажиллуулахад нийт орон нутгийн төсвөөс ..., 43,5 сая төгрөгийн	100%

	төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	сайжруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх							хангагдсан байна.			санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган дэмжлэг үзүүлсэн. Мөн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, хуульд заасан үйлчилгээ үзүүлэхэд 30.0 сая, камержуулалтыг засварлахад 338.4 сая, Цагдаагийн газрын байрны сантехникийн засварын ажилд 147.4 сая, тусгай зориулалтын автомашин худалдаж авахад 47,0 сая, техник хэрэгсэл /UTV 4 дугуйт-1 ш , кросс мотоцикл -2 ш / авахад 60.0 сая, мансууруулах бодис илрүүлэх тест авахад 3,0 сая, ШШГТ-ын үйлдвэрийн хэсэгт тоног төхөөрөмж авахад 59.4 сая, ШША-нд тусгай зориулалтын автомашин авахад 130.0 сая, Улсын бүртгэлийн хэлтэст архивын шүүгээ авахад 19,5 сая, Архивын тасагт сэргээн засах лабораторийн тоног төхөөрөмж авахад 5,0 сая, архивын баримтын бүртгэлийн ухаалаг тоологчийн чип авахад 21,0 сая төгрөгийг тусган хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.	
БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ													
248	8.4.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, Батлан хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.	Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог, бэхжүүлж, томилгоот нэгжийн бэлтгэлжилтийг хангах, нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх	2021-2024	Цэргийн штаб	Сумдын ЗДТГ Хүчний байгууллагууд	Орон нутгийн төсөв	16.2	Томилгоот бүрэлдэхүүний 0%	Томилгоот бүрэлдэхүүний 10%	3.5	Орон нутгийн төсөв 3,5	Батлан хамгаалахын Сайдын 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/133 дугаар тушаалын дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжтэй хээрийн дадлага хэлбэрээр сургалтыг төлөвлөн бэлтгэж 2022 оны 11 дүгээр сард зохион явуулсан. Баян-Өндөр сумын томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнийг тодотгох ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байрлалд Орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх тусгай байрыг шинээр тохижуулах, нөөц бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан. Томилгоот бүрэлдэхүүнийг 15 хувьд хүргэлээ.	100%
249		Эх оронч үзэл хүмүүжлийн үндэс байх, бодлогыг хэрэгжүүлж иргэн цэргийн харилцааг бэхжүүлж иргэдэд цэргийн боловсрол олгох	2021-2024	Цэргийн штаб БШУГ	БШУГ аймагдахь МЦНХ-ны салбар	Орон нутгийн төсөв	186.0	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 5%	Иргэн, цэргийн харилцаа бэхжинэ	38.0	Орон нутгийн төсөв 38,0	Аймгийн ерөнхий боловсролын ахлах, дунд, бага ангийн сурагчдын дунд "Монгол цэрэг энхийн үйлсэд" сэдэвт эсээ, гар зургийн уралдаан "Цэргийн дуу хэн сайн дуулах вэ" гоцлол дууны уралдаануудыг амжилтай зохион байгуулсан. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, аймагдахь Монгол цэргийн нэгдсэн холбоо, Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай хамтран аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрийн төв, ерөнхий боловсролын болон хувийн хэвшлийн нийт 24 сургуулийн ахлах анги буюу 12 дугаар ангийн 43 бүлгийн 1121 сурагчдад 3 дугаар сарын 15-ны өдөр, эхний нэг цаг дээр нэгэн зэрэг "Эх оронч үзэл үндэсний бахархал" сэдвээр лекц зохион байгууллаа. Батлан хамгаалахын сайдын 2022 оны 02 дугаар сарын А/50 дугаар тушаалын	100%

											хэрэгжилтийг хангах, Орхон аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгон, эх орон, эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг олон түмэнд хүргэх нийгэмд зэвсэгт хүчний нэр хүндийг өсгөх өсвөр үе хүүхэд залуучуудын бие бялдар ур чадварыг хөгжүүлэх цэрэг эх оронч хүмүүжил олгох бие бялдрын өв тэгш хөгжилтэй залуу хойч үеийг төлөвшүүлэх зэрэгт онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.		
250	8.5.Дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгон, дайчилгааны бэлтгэл нөөцийн бие бүрэлдэхүүний тоо чанарыг нэмэгдүүлнэ.	Дайчилгааны төлөвлөгөөг өнөөгийн нийгэмд эдийн засгийн нөхцөлд тулгуурлан шинэчлэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүний тоо, чанар материаллаг баазыг сайжруулах	2021-2024	ЗХЖШ, Цэргийн штаб	Аймгийн ЗДТГ Цэргийн штаб Зэвсэгт хүчний 186 дугаар анги	Улсын болон орон нутгийн төсөв	86.6	Дайчилгааны бэлтгэл нөөц 20%	Дайчилгааны бэлтгэл нөөц 15%	20.0	Орон нутгийн төсөв 20,0	“Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-ний дагуу аймаг, сумын дайчилгааны төлөвлөгөөг тодотгон ажилласан. Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай дайчилгааны төлөвлөгөөний дагуу тодотгол хийж акт нотломжийг Зэвсэгт хүчний Жанжин штабын бодлого стратеги төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Мөн дайчилгааны нөөцийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний, цэргийн дүйцүүлэх албаны сургалтуудыг Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудын сургалтын материалаг баазыг түшиглэн бие бүрэлдэхүүний сургалтыг үе шаттайгаар явуулж байна.	100%
251	8.6.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Орон нутгийн хэмжээнд тохиолдож болох гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах зорилгоор үе шаттайгаар	2021-2024	ОБГ	Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн	Орон нутгийн төсөв	100.0	Гамшиг осолд ажиллах хүн хүч техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал хангах	Баян-Өндөр, Жаргалант сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалт дадлагын ажлыг	150.0	Орон нутгийн төсөв 48,0	Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон багийн бүрэлдэхүүн аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийж 16 алба, 24 мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, хүн хүч, техник хэрэгслийн судалгаа мэдээллийг шинэчлэн бэлтгэл ажлыг хангасан. Онцгой байдлын Ерөнхий газраас зохион байгуулсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2022 оны 10 дугаар сарын 1-ээс 9-ны өдрүүдэд 6 үе шаттайгаар зохион байгуулж “Дүүрэн Хангалттай” гэсэн үнэлгээ авч ажилласан.	100%

		сургалтуудыг зохион явуулах, шаардлагатай хүн хүч техникийн нөөц бүрдүүлэх							зохион байгуулсан байна.				
	Нийт дүн												88.4%

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР
--oOo--